БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН

БАГА БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

Хүн ба орчин. I-III анги
Хүн ба байгаль. IV-V анги
Хүн ба нийгэм. IV-V анги

Улаанбаатар
2019

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

ГАРЧИГ

ХҮН БА ОРЧИН

НЭГДҮГЭЭР АНГИ
1.1. Би ... 8
Миний хичээлийн хэрэглэл ... 8
Миний бие ... 9
1.2. Миний гэр бүл ... 11
Манай гэрийнхэн ... 11
1.3. Манай сургууль ... 13
Сургуулийн дотоод орчин ... 13
1.4. Миний нутаг ... 14
Орон нутаг ба хүмүүс ... 14
Орон нутаг ба байгаль ... 15
1.5. Манай дэлхий ... 16
Эх орон, эх дэлхий ... 16

ХОЁРДУГААР АНГИ
2.1. Би ... 18
Миний хичээлийн хэрэглэл ... 18
Миний бие ... 19
2.2. Миний гэр бүл ... 20
Манай гэрийнхэн ... 20
Миний гэр орон ... 21
2.3. Манай сургууль ... 22
Сургуулийн гадаад орчин ... 22
Сургуулийн дотоод орчин ... 23
2.4. Миний нутаг ... 23
Орон нутаг ба хүмүүс ... 24
Орон нутаг ба байгаль ... 25
2.5. Манай дэлхий ... 25
Эх орон, эх дэлхий ... 26

ГУРАВДУГААР АНГИ
3.1. Би ... 28
Миний хичээлийн хэрэглэл ... 29
Миний бие ... 30
3.2. Миний гэр бүл ... 31
Манай гэрийнхэн ... 32
Миний гэр орон ... 32
3.3. Манай сургууль ... 33
Сургуулийн гадаад, дотоод орчин ... 33
3.4. Миний нутаг ... 34
Орон нутаг ба хүмүүс ... 35
Орон нутаг ба байгаль ... 36
3.5. Манай дэлхий ... 37
Эх орон, эх дэлхий ... 37

ХҮН БА БАЙГАЛЬ

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

4.1. Амьдрал 40
Өсөлт хөдөлгөөн 40
Амьд бие ба амьдралын орчин 43
4.2. Юмс үзэгдэл 45
Гэрлийн шинж чанар 45
Соронзон 48
Цахилгаан дамжуулагч ба тусгаарлагч 51
Хатуу, шингэн, хий 52
План ба газар зүйн зураг 54

ТАВДУГААР АНГИ

5.1. Гараг, дэлхий 56
Одот тэнгэр 56
Голдож, зэргэдээр зүг чиг олох 62
5.2. Юмс үзэгдэл 64
Бодисын төлөвийн шилжилт 64
Эргэх ба үл эргэх өөрчлөлт 65
Цаг агаар ба уур амьсгал 66
Хөшүүрэг, хялбар механизм 68
5.3. Амьдрал 70
Ургамлын амьдралын эргэлт 70
Амьтдын үржил, хөгжил 73

ХҮН БА НИЙГЭМ

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Удиртгал 78
4.1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал 78
4.2. Нутгийн хүмүүс, нийгэм, аж ахуй, соёлын амьдрал 79
4.3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх үүрэг, хариуцлага 80

ТАВДУГААР АНГИ

Удиртгал 82
5.1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал 83
5.2. Нутгийн хүмүүс, аж ахуй, соёлын амьдрал 83
5.3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх үүрэг, хариуцлага 84
5.4. Миний эх орон - Монгол бахархал 85
5.4.1. Эх орон, эх түүхийн бахархал 85
5.4.2. Үндэсний тусгаар тогтнол, орчин үеийн бахархал 87

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 06 өдөр Дугаар А/35 Улаанбаатар хот

Суралцахуйн удирдамж батлах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/491 дүгээр тушаал, "Хөтөлбөр батлах тухай" А/492 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг нэгдүгээр; суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, дүрслэх урлаг, хөгжим, дизайн, технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг хоёрдугаар; бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн, технологийн сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэг, хоёр, гуравдугаар хавсралтаар батлагдсан суралцахуйн удирдамжийг нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газруудад хүргүүлж, холбогдох мэдээллийг байгууллагын цахим хаяг /mier.mn/-т байршуулахыг Боловсролын хөтөлбөрийн секторын эрхлэгч /А.Энхтогтох/-д даалгасугай.

ЗАХИРАЛ П.ЛХАГВАСҮРЭН

ХТА2990

ӨМНӨХ ҮГ

Суралцахуйн удирдамж, түүний зориулалт

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөр дэх суралцахуйн зорилтыг суралцахуй болон багшлахуйгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг үлгэрчлэн төлөвлөсөн баримт бичиг юм.

Суралцахуйн удирдамж нь сургалтын хөтөлбөрийг жилээр болон нэгж, ээлжит хичээлээр зохистой төлөвлөх, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, хичээлийн арга зүйн санааг хөгжүүлэх, үнэлгээг үр дүнтэй зохион байгуулах хөтөч болно.

Суралцахуйн удирдамж нь арга зүйн зөвлөмж төдий бус, өнөөгийн боловсролын хөгжлийн чиг хандлага, үзэл санаанд суурилсан шинэлэг арга зүйг тусгасан тул суралцахуй, багшлахуйд тулгамдаж буй бэрхшээл, сорилтыг даван туулахад дэмжлэг үзүүлнэ.

Багш суралцахуйн удирдамжийг сайтар ойлгож, мөрдөн хэрэгжүүлэх нь хичээлийг үр өгөөжтэй зохион байгуулах, суралцахуйн үйл ажиллагааг бүтээлчээр дэмжих, багшлах ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Суралцахуйн удирдамжийг багш нар бэлэнчлэн хуулбарлаж хэрэглэх биш, өөрсдийн туршлага, ур чадвараар баяжуулан хөгжүүлэхийн сацуу сурагчдынхаа ялгаатай байдал мэдлэг, чадвар, хандлагад тохируулан уян хатан, нээлттэйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

Суралцахуйн удирдамжийн бүтэц

Суралцахуйн удирдамж нь суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, багшид зөвлөмж, хэрэглэгдэхүүн гэсэн үндсэн бүтэцтэй.

Суралцахуйн зорилт нь сурагчийн эзэмших мэдлэг, чадвар, чадамжийн илэрхийлэл. Өөрөөр хэлбэл; тухайлсан үйл ажиллагааны үр дүнд сурагчийн эзэмших мэдлэг, чадвар юм.

Суралцахуйн үйл ажиллагаа: Багш төвтэй сургалтын арга зүйг биш, сурагчийн бүтээлч сэтгэлгээ, идэвх, оролцоо, бие даасан байдлыг хүндэтгэн дэмжсэн, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх зэрэг сурагч төвтэй сургалтын арга технологид суурилсан үйл ажиллагааг тусгасан.

Суралцахуйн зорилт бүрээр сэдэлжих, мэдлэг бүтээх сорил туршилт, дадлага ажил, даалгавар гүйцэтгэх арга, аргачлал, үр дүнгээ үнэлэх, ганцаарчлан болон багаар ажиллах арга зүйн шийдлийг зөвлөсөн болно. Мөн багш суралцахуйг дэмжих, туслах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, багийн үйл ажиллагааг хөгжүүлэх, сурсан зүйл нь хүүхэд бүрт “үр өгөөжтэй” байхад санаа тавих, хүүхэд бүрийн суралцах ялгаатай байдлыг харгалзан хичээл зохион байгуулахад анхаарах зүйлийг зөвлөмжилсөн.

Хэрэглэгдэхүүн: Энэ хэсэгт суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурах бичиг, гарын авлага, цахим болон бусад эх сурвалж, дадлага, туршилт, аялал, төсөлт хичээл, хамтын хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгон ашиглахыг санал болгосон.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжийг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр боловсруулсан тул сургууль, багш нар судлагдахуунуудын хөндлөн ба босоо залгамж холбоог сайтар судлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Боловсролын хүрээлэн

ХҮН БА ОРЧИН

I-III анги

Удиртгал

ЕБС-ийн 1-3 дугаар ангийн “Хүн ба орчин” хичээлээр “Би”, “Миний гэр бүл”, “Манай сургууль”, “Миний нутаг”, “Манай дэлхий” гэсэн бүлэг 5 бүлэг сэдвийн хүрээнд агуулгыг суралцахуйн зорилтоор нэгжилсэн болно.

Сургалтын хөтөлбөрийн агуулга буюу суралцахуйн зорилтыг судалснаар сурагчид тодорхой мэдлэг, чадварыг эзэмшинэ. Мөн багшийн чиглүүлгийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэсний эцэст дараах хандлага төлөвшинө.

- Хүрээлэн буй орчноо сонирхох, танин мэдэх хүсэл эрмэлзэлтэй болох;
- Өөрийн эрүүл мэндийг хайрлах, хамгаалахыг ойлгодог, өдрийн дэглэм баримталдаг байх;
- Өөрийгөө идэвхжүүлдэг, бие даан болон бусадтай хамтран суралцах сонирхолтой, сурч мэдсэн зүйлээ бусадтай хуваалцах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Эх орон, орон нутгийн хүмүүсийн хөдөлмөр, амжилтаар бахархдаг, тэдний уламжлалт зан үйл, ёс заншлыг хүндэтгэдэг байх;
- Дэлхийн хүмүүсийн амьдрах бүс бүслүүр, амьдрал, арьс өнгө ялгаатай болохыг ойлгон, олон соёлыг хүндэтгэдэг болох;

НЭГДҮГЭЭР АНГИ

Энэхүү суралцахуйн удирдамжид суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх сурагчдын сурах үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэглэгдэхүүнийг санал болгосон болно.

БҮЛЭГ 1.1. БИ

Энэ бүлэгт сурагчид “Миний хичээлийн хэрэглэл”, “Миний бие” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд ойр орчныхоо хүмүүс, байгаль, нийгэмтэй харилцах явцад өөрийгөө нээн таних; сонирхон судлах арга барил эзэмших; эрүүл аж төрөх энгийн дадал, хэвшилд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Сонирхон судлах арга барил эзэмших; ажиглах, таамаглах, турших, үр дүнг танилцуулах
- Хичээлийн хэрэглэлээ нэрлэж, зориулалтаар нь ялган таних, зөв, ариг гамтай хэрэглэх, хадгалах
- Мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар хүрээлэн байгаа орчны юмс үзэгдлийг ажиглаж, хоорондоо хэрхэн зохицдогийг таних зэрэг болно

Бүлгийн нэр томьёо: Хичээлийн хэрэглэлийн зориулалт, мэдрэхүйн эрхтэн, өдрийн дэглэм

Миний хичээлийн хэрэглэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.1а. Өөрийн хичээлийн хэрэглэлээ нэрлэж, үүрэг зориулалтаар нь ялган таних	- Өөрт байгаа хичээлийн хэрэглэлүүдээ нэрлэнэ. - Хэрэглэх зориулалтаар нь ялгаж ангилна (дөрвөлжин, тууш шугамтай болон зургийн, ноотны дэвтэр гэх мэт. Мөн ном сурах бичиг байж болно. Эдгээр дэвтэр, ном сурах бичгийг хэрхэн ялган ангилах санааг сурагчдад хэлж болно).	- Дөрвөлжин шугамтай дэвтэр, шугам - Тууш шугамтай дэвтэр, үзэг - Зургийн дэвтэр, усан будаг, бийр - Ноотны дэвтэр, харандаа, баллуур

	- Сурагчид дөрвөлжин шугамтай, элементийн дэвтэр, зургийн болон ноотны дэвтрийг ямар хичээлд, хэрхэн, яаж хэрэглэж болохоо ширээнийхээ найздаа харуулж тайлбарлана. - Нэг хичээлээр жишээ болгох замаар зургийн хичээлд хэрэглэгдэх материалуудыг ширээн дээр бэлтгүүлж (дэвтэр, өнгийн болон балын харандаа, шугам, баллуур усан будаг), хэрэглэх байдлаар нь хэрхэн ангилах, үүрэг зориулалтаар нь хэрэглэх дадлага ажил хийнэ. - Дүрэмт хувцас, биеийн тамирын хувцас, чөлөөт хувцсны зураг харуулж хэзээ, хаана өмсдөг болохыг асууж яриулна. ***Багшийн анхаарах зүйл:*** - *1-р ангийн "Хүн ба орчин" хичээлийн энэ суралцахуйн зорилтыг бэлтгэл хөтөлбөрийн агуулгатай уялдуулан заах боломжтой.* - *Багшийн арга зүй сурагч бүр хичээлийн хэрэглэлээ сонгож, үүрэг зориулалтаар нь зөв, ариг гамтай хэрэглэж, хадгалах чадварт сургаж, хэвшүүлэхэд чиглэнэ.* - *Багш өөрөө эхлэн зааж, хэлэхээс татгалзаж сурагчдаар өөрсдөөр нь ангилах, ялгуулах, хийж бүтээх шинэ санаа гаргуулахад анхаарна. Тухайлбал: Шугамгүй цаас болон дөрвөлжин шугамтай дэвтрийн цаас өгч гурвалжин, дөрвөлжин дүрс зурахыг санал болгоно. Аль цаасан дээр зурахад амархан байсан бэ? Ямар тохиолдолд шугам хэрэглэх боломжтой бэ? зэргээр асуулт асууж хичээлийн хэрэглэлийг зориулалтын дагуу хэрэглэх, ач холбогдлыг таниулахад анхаарна.*	- Цаас, цавуу, хайч - Үзэг харандааны сав - Биеийн тамирын хувцас, пүүз - Бусад хичээлийн хэрэглэл - Сурах бичиг

Миний бие

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.1б. Мэдэрхүйн эрхтний тусламжтайгаар биетийн өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөн, амт үнэр, дуу чимээ, бат бөх чанарыг мэдэрч ялган таних	- Сурагчид зурган мэдээлэл дээр ажиллан, ялгааг ажиглах, нэрлэх, тоолох, тайлбарлах зэрэг дасгалуудыг хийнэ. - Өөрийн бие дээр болон тоглоом, биет үзүүлэнг ашиглан заах, нэрлэх дасгал ажиллана. - Сурагчид дуу, шүлэг сонсож ямар мэдрэмж төрснөө илэрхийлнэ o *Харах*: Хүний нүд өнгө, хэлбэр, хэмжээ, хөдөлгөөн байршлыг харж тодорхойлдог болохыг дасгал хийж нотолно. o *Сонсох*: Чихний сонсголыг шалгах туршилтыг төлөвлөнө. Дуу хөгжим сонсгоно. o *Үнэрлэх:* Хамраараа үнэрийг мэдрэх, ялган таних туршилт хийнэ. Урьдчилан бэлтгэсэн жижиг нүхтэй хайрцагт үнэрээрээ ялгаатай чихэр, жимс, ааруул зэргийг хийж, үнэрлэх, үнэрийг ялган таних дадлага ажил хийнэ. o *Мэдрэх:* Гар, хуруугаар тэмтэрч мэдрэх туршилт хийнэ. Цүнхэнд юу байна вэ? гэх	- Зурагт үзүүлэн - Тоглоом - Өсгөгч шил - CD дуу, шүлэг - Хоол, үнэртэн - Тэмтрэх цүнх - Багийн тоогоор хайрцаг бэлтгэсэн байх - Нүд боох алчуур - Хүүхэлдэй - Сурах бичиг

	мэт. Сурагчид тэмтэрч мэдэрснээр биетийг хэлбэр, хэмжээ, урт богино, гадаргуу, жин зэргээр ялган танина. o *Амтлах:* Хэлний мэдрэх онцлогийг таниулах туршилт хийнэ. Чихэрлэг, гашуун, исгэлэн, давслаг амтыг ялган танина. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш хичээл заахдаа ангидаа орон зайн чөлөөтэй нөхцөл байдлыг бүрдүүлэхэд анхаарна.* - *Мэдрэхүйн эрхтний бүтэц, үүргийг таниулахдаа өдөр тутам тоглодог тоглоомоор нь (хүүхэлдэй, машин, лего, бөмбөг, дуу гаргадаг тоглоомууд, үнэртэй жимс жимсгэнэ гэх мэт) дамжуулан насанд нь тохирсон туршилтын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж болно. Жишээ нь: Сурагчдыг 4-5 баг болгож багийн тоогоор хайрцаг бэлтгэн дотор нь үнэрлэх, сонсох, гараар барьж тэмтрэхэд ашиглах зүйлийг бэлтгэж, дадлага ажил хийлгэнэ.* - *Мэдрэхүйн эрхтнээ хамгаалах, хэт ойр ба холоос ном, зурагт үзэхгүй байх, хэт чанга дуу авиа сонсохгүй байх, чихэвч, гар утсыг зөв зохистой хэрэглэх аргыг зааж сургахад анхаарах хэрэгтэй.* - *Мөн хэн, юунаас харшил авч болох эсэхийг урьдчилан судалсны үндсэн дээр хичээлийн хэрэглэгдэхүүнээ сонгон бэлтгээрэй.*	
1.1в. Өдөр тутам хийдэг ажлуудаа дарааллаар нь танилцуулж, өдрийн дэглэмээ зургаар илэрхийлэх	- Өглөө, өдөр, орой юу хийдэг талаар эргэцүүлэн бодож, дарааллаар нь хамт сууж буй найздаа ярьж өгнө. Хичээл хийх, амрах цагаа зөв зохицуулах, дасгал хөдөлгөөн хийх зэрэг үйлийг тусгана. - Багш 5-6 сурагчийг сонгож, өчигдөр юу хийснийг бусдад сонсгоно. - Сурагчдын ярьсан зүйлийг сонсоод нийт сурагчид тэд өглөө, өдөр, орой ихэвчлэн юу хийсэн болохыг зургаар илэрхийлнэ. - Нийт сурагчдын зурсан зургийг өглөө, өдөр, орой хийсэн ажил гэсэн байдлаар 3 ангилж самбарт байрлуулж болно. - Зурсан, 3 ангилсан зургийнхаа тайлбарыг найзуудадаа танилцуулна. - Өглөө, өдөр, орой тогтмол хийдэг зүйлийг өдрийн дэглэмийн хуваарь гэж нэрлэдэг болохыг тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш эхлээд өдрийн дэглэм гэж ярихаасаа илүү өглөө, өдөр, оройн цагаар, юу хийдэг тухай нь яриулна.* - *Сурагчлын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон өдрийн дэглэмийн зургийг урьдчилан хайчилж бэлтгэсэн байна Сурагч бүрийн сурах арга барил, хурд ялгаатай байдгийг анхаарч дагуулж хийх, зөвлөх зэргээр хүүхэд бүрт хүрч ажиллах арга зүйг сонгож, хичээлийг зохион байгуулна.* - *Сурагч бүрийн бусдаас өөр ялгаатай хийдэг зүйлс буюу нэмж тусгах зүйл байгааг асууж, сануулаарай.*	- Өдрийн дэглэмийн цагийн хуваарийг харуулсан зураг - Хэрчмэл зураг - Нийтлэг нэг жишээ харуулсан зураг - Өдрийн дэглэмийн хуваарь хийх загварыг (тэмдэглэх, зурах, будах) хүүхдийн тоогоор бэлтгэсэн байна - Сурах бичиг

БҮЛЭГ 1.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Энэ бүлэгт сурагчид “Манай гэрийнхэн”, “Миний гэр орон” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд ойр орчныхоо хүмүүстэй харилцах; сонирхон судлах арга барил эзэмших; аюулгүй байдлыг эрхэмлэх дадал, хэвшлийг төлөвшүүлэх агуулгыг судална. Үүнд:

- Гэр бүлийнхээ тухай бусдад танилцуулах, бие биедээ харилцан туслах
- Гэр, байрныхаа эргэн тойронд хаана, юу байдгийг нэрлэх, харьцуулан ажиглах, аюулгүй амьдрах үндсийг тайлбарлах зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо: Гэр бүлийнхний утасны дугаар, цахилгаан хэрэгсэл, орчны аюулгүй байдал

Манай гэрийнхэн

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.2а. Гэр бүлийнхнээ танилцуулах, шаардлагатай үед утсаар холбоо тогтоож чаддагаа харуулах	- Гэртээ хамт амьдардаг хүмүүсээ нэрлэж, танилцуулна. Жишээ нь: Аавынхаа овог нэр хаана ажилладаг, утасны дугаар, гэр орондоо юу хийж тусалдаг, сохирхдог зүйл гэх мэт. - Самбарт 1-10-ын цифрүүдийг өлгөж, байрлалыг нь сольж (соронзтой бол сайн) аав, ээж, ах, эгчийнхээ утасны дугааруудыг хийх дасгал ажиллуулна. - Шаардлагатай үед яах гэж, хэн рүү, ямар дугаар луу залгаж болохыг тайлбарлана. - Гэрийнхнийхээ утасны дугаарыг хэлэх дасгал ажиллана. Мэдэж буй эсэх, үнэн зөв хэлж байгааг залруулан, нүдлүүлж тогтоолгоно. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багшийн зүгээс хүүхэд бүрийн гэр бүлийн талаар хийсэн судалгаатай байж, аав, ээжийнх нь утасны дугаарыг мэддэг байх шаардлагатай.* - *Сурагчид гэр бүлээ танилцуулах явцдаа аав, ээжийнхээ утасны дугаарыг мэдэж, хэлэх нь аюулгүй байдлаа хамгаалах үндэс болно гэдгийг анхааараарай.* - *Гэр бүлийн цомог хийлгэж болно. Эсвэл гэрийн даалгаварт өгч болно. Хийлгэсэн цомгоо ангидаа булан байгуулан байрлуулбал хүүхдэд анги, сургууль нь илүү дотно санагдах магадлалтай.*	- 1-10-ын соронзтой цифрүүд - Гэр бүлийнхнийх нь фото зургууд - Цомог хийх цаас - Сурах бичиг

Миний гэр орон

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.2б. Орчин тойрны зүйлстэй харьцуулж, гэр байраа хаана оршдогийг тодорхойлох	- Сурагчдын өмнөх төсөөлөл дээр тулгуурлан гэр, байраа хаана байрладгийг хажууд, цаана, наана, хол, ойр гэх мэт үгсийг ашиглан танилцуулах дасгал ажиллана. - Гэрийнхээ эргэн тойрны барилга байгууламжийг ажиглаж, хаана, юу байгааг нэрлэнэ (сумын төв, дүүргийн барилга байгууламжийг). - Ажигласны дараа гэрийн хаана, юу байгааг харьцуулж, гэрийнхээ байрлалыг үндсэн 4 зүг чигээр тодорхойлох дасгал даалгавар гүйцэтгэнэ.	- Гэр байрны эргэн тойрны юмсын байрлалыг харж болохуйц фото зураг - Сурах бичиг

	Жишээ нь: Манай гэрийн урд зүгт дэлгүүр, хойт зүгт Туяагийнх, баруун талд цэцэрлэгт хүрээлэн, зүүн талд нуур оршдог гэх мэт ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш хүүхэд бүрт урьдчилан гэрийнхээ ойр орчимд юу байгааг мэдэж ирэх даалгавар өгсөн байна.* - *Гэр, байр нь сургууль болон тодорхой барилга байгууламжаас хэр ойр, хол байгааг баримжаалан ажиглахад мөн наана, цаана нь юу байрладгийг хэлэхэд тусална.* - *Хойд, урд, баруун, зүүн гэсэн үндсэн зүг чигээр гэрийнхээ байрлалыг тодорхойлж хэлэхэд голлон анхаарах боловч энэ нь аливаа осол, гамшгийн үед өөрийгөө хамгаалах ур чадварт сургаж байгаа гэдгийг анхаараарай.* - *Гэрийн даалгаварт эцэг эхтэйгээ хамтран гүйцэтгэх дасгал даалгаврыг төлөвлөж бэлтгээрэй.*	
1.2в. Гэр, байрны орчин (тухайлбал, гал тогоо) тойронд хаана, юу байдгийг ажиглаж, зураглах	- Монгол гэрийн дотор байгаа зүйлийг зүг чиг, байрлалаар танилцуулах дасгал ажиллана. - Өөрийнхөө гэрийн унтлагын болон зочны, гал тогооны өрөөнд хаана, юу байгааг нэрлэж тойм зураг гаргана. - Тэдгээрийг ямар зориулалтаар, яаж хэрэглэдгийг тайлбарлана. - Нэрлэсэн зүйлээ хэрхэн аюулгүй хэрэглэх талаар ярилцана. Жишээ нь. Хутга мэс зэрэг иртэй зүйл, сэрээ халбага, хайч зэрэг үзүүртэй зүйлс, халуун зуух, шил шаазантай хэрхэн болгоомжтой харьцах, хаягдал хоол хүнсийг хаана, яаж хаях зэрэг зөв дадал хэвшилд сургах нь өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад тустай гэдгийг ойлгуулах дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш энэ хичээлийг заахдаа гэрт ба байшинд амьдардаг хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан зурагт хуудас, хэрэглэгдэхүүнээ сонгон бэлтгэхэд анхаарна.*	- Гэр, байрны зураг - Гал тогоо, унтлагын өрөө, зочны өрөөний байдлыг харуулсан зурагт хуудас - Байрны болон монгол гэрийн харьцуулсан зураг (эд хогшил тавилгатай) - Сурах бичиг
1.2г. Гэрийнхээ цахилгаан хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааг тодорхойлох	- Гэртээ байдаг цахилгаан хэрэгслүүдийг нэрлэнэ. Нэрлээгүй зүйлсийн зургийг харуулж, багшийн чиглүүлэх асуултын дагуу ярилцана. - Цахилгаан хэрэгсэлтэй аюулгүй ажиллах дүрмийг харуулсан зурагт тайлбар хийнэ (хориглосон тэмдэг тэмдэглэгээг зургаар илэрхийлнэ). - Гэр ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслийг зөв, аюулгүй хэрэглэх энгийн аргуудад сурах дадлага, сургуулалт хийж болно. Жишээ нь: гал гарсан үед доош сууж, ам, хамраа чийгтэй алчуураар дарж, утаат орчноос гарах гэх мэт. ***Багшийн анхаарах зүйл:*** *Гэр ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгсэл болон амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох зүйлтэй болгоомжтой харьцах, урьдчилан сэргийлэх дадал хэвшилд сургахад анхаарна.*	- Айл гэрт байдаг цахилгаан хэрэгслүүдийг харуулсан зурагт хуудсууд - Цахилгаан зуух, индүү, зурагт, радио, хөгжим, цахилгааны залгуур гэх мэт - Болгоомжгүйгээс гарах үр дагаврыг харуулсан бичлэг, зурагт хуудас, жишээ - Сурах бичиг

БҮЛЭГ 1.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Энэ бүлэгт сурагчид “Сургуулийн гадаад орчин”, “Сургуулийн дотоод орчин” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Сургуулийн гадаад, дотоод орчинд дуу үүсгэж байгаа биеүүд, дууны чанга, сулыг мэдэрч, эрүүл мэндээ хамгаалах
- Ангид ургадаг ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таних зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо: Дуу үүсгэгч, ургамлын бүтцийн хэсгүүд

Сургуулийн гадаад орчин

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.3а. Сургууль орчмын дуу чимээг сонсоод ялган таних	- Багшийн заасан чиглэлийн дагуу сурагчид 4-5 баг болж сургуулийн орчинд хаана, ямар дуу чимээ сонсогдож байгааг сонсож тэмдэглэнэ. - Ангидаа ирээд өөрийн сонссон, мэдсэн зүйлээ бусдадаа тайлбарлаж, дуу бүхэн ялгаатай сонсогдож байгаа талаар санал бодлоо солилцоно. - Дуу чимээ эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж болох талаар ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш сурагчдыг дагуулан сургууль орчмоор аялал хийж, дуу чимээг сонсгоно.* - *Сурагчид бие даан ажиглалт хийх тохиолдолд явах чиглэл, замыг тодорхой болгож, тэмдэг тэмдэглэгээ тавьж өгөх (өнгийн хуулга, цаасаар сум хайчлан хана, шалан дээр байрлуулах) нь бага цагт ажиглалт хийх боломжийг бүрдүүлж өгдөг гэдгийг санаарай. Энэ тохиодолд ажиглалт хийх хугацааг тодорхой хэлж өгөх хэрэгтэй.* - *Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртэж мэдрэх боломжийг олгоно.*	- Аяллын маршрут - Ангид ба эргэн тойронд байгаа дуу гаргадаг биеүд - Чихэвчний хөгжим - Тэмдэг тэмдэг-лэгээ - Сурах бичиг

Сургуулийн дотоод орчин

1.3б. Ангид ургаж буй ургамлын бүтцийн хэсгүүдийг ялган таньж, нэрлэх	- Ангид ургаж буй тасалгааны ургамлуудаас сонгон, бүтцийн хэсгүүдийг (үндэс, иш, навч, цэцэг) нэрлэнэ. - Ургамлын навч, иш зэргийн ялгаатай байдлыг ажиглана (өнгө, хэлбэр, хэмжээ, урт богино). - Ургамлын цэцгийн өнгө, дэлбийн тоо ширхэг өөр, өөр ялгаатай байдгийг харьцуулна. - Ургамлын бүтцийн хэсгүүдийг харуулсан бүтээл хийж урлах, зурж дүрслэх дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Энэ хичээлийг орохын өмнө сурагчдын амьд биеийн талаарх өмнөх төсөөллийг тандана. Сурагчид өмнөх хичээлээр хүний биеийн бүтцийн үндсэн хэсгүүд (толгой, гар, хөл, их бие)-ийг ялган таньдаг болсон. Харин одоо ургамлын бүтцийн үндсэн хэсэг нь хүнийхээс ямар ялгаатай болохыг харьцуулан тайлбарлана. Ангид ургаж байгаа ургамлыг сонгон жишээ болгон ярилцаж болно.*	- Бодит ба хиймэл ургамал - Ургамлын бүтцийн хэсгүүдийг харуулсан зураг - Ургамлын навчны зураг, тасалгааны ургамлын навч - Цэцгийн бүтцийн зураг, загвар - Өнгийн цаас, харандаа, хайч, цавуу - Сурах бичиг

	- *Сурагчид тасалгааны ургамлыг хараад "цэцэг" гэж хэлдэг боловч цэцэг гэдэг нь ургамлын зөвхөн нэг эрхтэн, тэгэхээр ургамлын нэг эрхтний нэрээр нэрлэсэн ерөнхий нэршил төдий л оновчтой бус. Иймээс "ургамал" гэдэг ерөнхий нэршлээр нэрлүүлж сургахад анхаарах хэрэгтэй.* - *Ургамлын биеийг бүрдүүлж байгаа хэсгүүдийг (эрхтэн) зөв нэрлүүлэхдээ ургамлын олон янз байдлыг ажиглуулж чөлөөтэй сэтгүүлэх боломж бүрдүүлээрэй. Жишээ нь: ургамал навчтай боловч навчны өнгө, хэлбэр, хэмжээгээрээ өөр өөр ялгаатай байдаг гэсэн дүгнэлтэд хүргэнэ. Гэхдээ эрхтэн гэдэг үгийг хэрэглэхгүй, харин эдгээр нь ургамлын биеийг бүрдүүлж байгаа бүрдэл хэсгүүд гэж дүрслэх урлагийн хичээлийн агуулгатай холбон ойлгуулж болно.* - *Сурагч бүрийн сурах арга барил, хурд ялгаатай байдгийг анхаарч ангид ургасан ургамлын ялгааг олж ажиглах, зааж нэрлэх, тэмдэглэх, зурж дүрслэх, биетээр хийх үйлд сургахад дагуулж хийх, зөвлөх зэргээр хүүхэд бүрт хүрч ажиллах арга зүйг сонгож хичээлийг зохион байгуулаарай.*	

БҮЛЭГ 1.4. МИНИЙ НУТАГ

Энэ бүлэгт сурагчид "Орон нутаг ба хүмүүс", "Орон нутаг ба байгаль" гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Амьдарч буй аймаг, сум, хот дүүргийнхээ нэр, хаяг, байршлийг нэрлэх
- Эргэн тойрноо ажиглах, орон нутагтаа ургадаг ургамлыг ургах байдлаар ялган таних, зөв ашиглаж хамгаалах
- Гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо: Гэр, сургууль, хот, дүүргийн хаяг, байршил; орон нутгийн үйлчилгээний газрууд; хүнсний ногоо, жимс жимсгэнэ; гэрийн тэжээмэл амьтан; ашиг шим

Орон нутаг ба хүмүүс

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.4а. Гэр, сургуулийнхаа болон аймаг, сум, хот дүүргийнхээ нэр, хаяг, байршлийг зөв хэлж чаддагаа харуулах	- Гэр, сургуулийнхаа хаягийг цээжлэн тогтоож, бусдад танилцуулна. - Аль хот, аймаг, дүүргийн харьяа болохыг хэлж чаддаг болно. Манай сургууль ..... хотын (аймгийн) ..... дүүргийн (сумын) ..... багт (хороонд) байрладаг. Манай гэр ..... хотын (аймгийн)..... дүүргийн, (сумын) ..... хороонд, (багт) оршдог. Гэр сургууль, аймаг, хотынхоо талаар дэлгэрэнгүй мэдээллийг аав ээжээсээ асууж тодруулах даалгавар гүйцэтгэнэ.	- Орон нутгийн зураг - Хаяг бичих ажлын хуудас - Сурах бичиг

	Багшийн анхаарах зүйл: - *Хүүхэд бүр гэр бүлээ өмнөх бүлгээр танилцуулсан туршлагад тулгуурлана.* - *Гэрийнхээ болон сургуулийнхаа хаягийг яаралтай үед хэлж чаддаг болох нь өөрийн аюулгүй байдлыг хангахад чухал гэдгийг ойлгуулна.* - *Үүний тулд хүүхдүүд харилцан бие биенээсээ гэрийнх нь хаягийг асууж, асуултад зөв хариулж сурах дадлага ажлыг давтан хийлгэж, зөв танилцуулж сурахад багшийн тусламж хэрэгтэй.*	
1.4б. Орон нутгийнхаа үйлчилгээний газруудыг нэрлэж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх	- Өөрийнхөө болон гэр бүлийхнийхээ хамгийн их очиж үйлчлүүлдэг газар, байгууллагуудыг нэрлэж, хэрхэн үйлчлүүлдэг тухайгаа жишээгээр тайлбарлана. - Орон нутгийнхаа үйлчилгээний газруудыг нэрлэж, танилцах аялал хийнэ. - Аялалын үед зурж тэмдэглэх, зарим үйлчилгээний ажилтнуудаас хийж буй үйл ажиллагааных нь талаар сонирхсон асуулт асууж, харилцан ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Тухайн орон нутагт байдаг үйлчилгээний газруудыг зөв сонгож, аялалын аюулгүй ажиллагааг хангах нь чухал.* - *Хүний хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэрч, тэднийг хүндэтгэн харилцах соёлд сургахад анхаарна.*	- Орон нутгийн байгууллагуудын хаяг - Танилцах аяллын маршрут зураг - Аяллын тэмдэглэл хөтлөх зурагт хуудас - Сурах бичиг

Орон нутаг ба байгаль

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.4в. Орон нутагтаа ургадаг хүнсний ногоо болон жимс, жимсгэнийг ялган таних	- Нутгийнхаа таримал болон зэрлэг ургамлын орчны ялгаатай байдлыг ажиглаж харьцуулна. - Орон нутагтаа тарьж ургуулдаг зарим хүнсний ногоо (төмс, лууван, байцаа, сонгино, сармис), жимс жимсгэнэ (алим, улаан лооль, өргөст хэмх)-ийг таниж, нэрлэх дасгал ажиллана. - Ургамлыг хоол хүнсэнд хэрэглэхээс гадна гоёл чимэглэлийн, бэлэг дурсгалын гэх мэт зориулалтаар нь ангилдаг болохыг танин мэдэх дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Сурагчдыг сургуулийн орчинд ургадаг ургамал болон цэцэрлэгт хүрээлэн, жимс ногоо тариалдаг талбайд дагуулан очиж ургамлуудыг ажиглуулна.* - *Мөн хүмүүс ногоогоо хэдийд тарьж эхэлдэг, яаж арчилж ургуулдаг, хэдийд хураан авдаг талаарх мэдээллийг үйлчилгээний ажилтнаас асуулт асууж тодруулах боломжийг бүрдүүлнэ. Хүүхдүүд аливаа зүйлийг бодитоор харах нь илүү үр дүнтэй байдаг тул энэ хичээлийг танхимын бус аргаар зохион байгуулаарай.*	- Орон нутагт ургадаг ургамалын зураг, - Хүнсний ногоо болон, жимс жимсгэний зураг - Сурах бичиг

1.4г. Орон нутагтаа амьдардаг гэрийн тэжээмэл амьтдыг нэрлэж, хайрлан хамгаалах арга, ашиг шимийг жишээгээр тайлбарлах	- Гэрийн тэжээвэр амьтад болон зэрлэг амьтдын амьдрах орчны ялгааг харьцуулан ярилцана. - Гэрийн тэжээвэр амьтдын үр төл, өсөж том болж байгаа амьтдын зургийг харьцуулан жишээгээр тайлбарлах дасгал ажиллана. - Хүүхдүүд гэртээ тэжээдэг амьтныхаа тухай яаж тэжээж арчилдаг, хэрхэн хайрлан хамгаалдаг тухайгаа бусдад танилцуулж болно. - Амьтдыг хэрхэн хайрлан хамгаалах болон ашиг шимийн талаар мэддэг зүйлээ харгалзуулан бичнэ. - Амьтдыг хайрлах, өсгөж үржүүлэхэд өөрийн оруулж чадах хувь нэмрээ тодорхойлно. ***Багшийн анхаарах зүйл:*** *- Багшийн ажиллуулах дасгал, даалгавар нь амьтныг хайрлах, хамгаалах сэдэл төрүүлэхэд чиглэгдсэн байхыг анхаараарай.* *- Орчин нөхцлийг бүрдүүлэх үүднээс сэдэлжүүлэх асуулт, даалгаврыг бэлтгэх хэрэгтэй. Жишээ нь: Амьтдыг хараад чамд ямар сэтгэгдэл төрсөн бэ? (Зураг болон биет үзүүлэн ашиглаж болно).* *А. Таалагдсан ☐* *Яагаад? .....* *Б. Айсан ☐* *Яагаад? .....* *Чи амьтан тэжээдэг үү?* *А. тийм Б. үгүй* *Тийм бол яагаад? .....* *Үгүй бол шалтгаанаа бичнэ үү ..... гэх мэт*	- Гэрийн тэжээвэр амьтдын зураг - Өөрийн тэжээдэг амьтны зураг - Сурах бичиг

БҮЛЭГ 1.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Энэ бүлэгт сурагчид “Эх орон, эх дэлхий” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах, хэм хэмжээ, дэглэм сахих, үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Өдөр шөнө солигдоход хүмүүс болон эргэн тойрны юмсын хоногийн хэмнэл өөрчлөгддөг болохыг мэдэх
- Нар мандах, жаргахаас хамаарч байгалийн юмс, үзэгдэл, хүний амьдрал үйл ажиллагаа өөрчлөгддөгийн учир шалтгааныг тайлбарлах зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо: өдөр, шөнө, байгалийн юмс үзэгдэл, хоногийн хэмнэл, нар мандах, жаргах, гэрэлтэй, харанхуй, дулаан, хүйтэн

Эх орон, эх дэлхий

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1.5а. Өдөр (гэрэлтэй, дулаан), шөнө (харанхуй, хүйтэн) -ийн ялгааг харьцуулах	- Нар, сар, одыг ажиглан өдөр-гэрэлтэй, дулаан, шөнө-харанхуй, сэрүүн байдгийн учрыг тайлбарлах дасгал ажиллана. - Нар бол гэрэл гаргадаг, дулаан өгдөг гэдгийг ширээний чийдэн ашиглаж, загварчилж харуулж болно. - Од гэрэл гаргадаг ч, асар хол зайд байгаа тул дулаан өгдөггүй талаар ярилцана. - Сар өөрөөсөө гэрэл гаргахгүй, нарны гэрэл туссанаас бидэнд гэрэлтэж харагддаг гэдгийг таниулах дадлага ажил төлөвлөж хийнэ.	- Өдөр шөнийн зураг - Нартай үеийн зураг - Тэнгэрт сар, од харагдаж буй зураг - Термометр - Халуун ба хүйтнийг харьцуулах - Сурах бичиг

	Багшийн анхаарах зүйл: - *Дасгал ажил хийлгэхдээ нар, сар, одыг загварчилсан хэрэглэгдэхүүн бэлтгэж сургалтад ашиглана.* - *Өдөр, шөнийг ялгааг нар бол гэрэл үүсгэгч, дулаан гаргадаг гэсэн санаагаар чиглүүлж тайлбарлана.*	
1.5б. Байгалийн юмс үзэгдэл нар мандах, жаргахаас хамаарч өөрчлөгддөгийн учрыг жишээгээр тайлбарлах	- Нарны мандах ба жаргах зүгийг ялган тодорхойлно. - Нар мандахад дулаан болж, шөнө нь өдрөөсөө сэрүүн болдгийг нар мандах, хөөрөх, жаргахтай холбон тайлбарлах дасгал ажиллана. - Нартай үед ургамал ямар байдаг, наргүй үед яаж өөрчлөгддөгийг бичлэгээс харж тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Нарны мандах ба жаргах зүгийг ялган тодорхойлоход дөрвөн зүгийн зургийг ашиглана.* - *Нар мандах (зүүн) ба жаргах (баруун) зүгийг өмнө үзсэн агуулгатай уялдуулах, их сайн мэдэх уул, хад (хөдөөгийн хүүхдийн хувьд), юмуу өндөр барилга (хотын хүүхдийн хувьд) зэргээр баримжаалж болно.* - *Өдөр нартай үед дулаан болдог бас гэрэлтэй байдаг тул амьтан ургамалд ямар өөрчлөлт гардаг, шөнө харанхуй, хүйтэн байдаг учраас амьтан, ургамалд гарах өөрчлөлтийг хүүхдүүд ажиглаж эргэцүүлэн бодох, учир шалтгааныг сонирхож, өөрийнхөө ойлгосноор ярих зэрэг сонирхон судлах арга барилд суралцуулах төрөл бүрийн хэрэглэгдэхүүн, видео бичлэг зэргийг бэлтгэнэ.*	- Өдөр, шөнийн зураг - Нартай үеийн зураг - Тэнгэрт сар, од харагдаж буй зураг - Термометр - Халуун ба хүйтнийг харьцуулах - Сурах бичиг
1.5в. Хүний амьдрал, үйл ажиллагаа өдөр, шөнийн урт богино болон улирлаас хамаарч өөрчлөгддөгийг тодорхойлох	- Би өглөө, өдөр, орой юу хийдэг болохоо бусдад танилцуулна. - Манай гэрийнхэн өглөө, өдөр, орой юу хийдэг болохыг зургаар танилцуулна. - Хэн өглөө эрт босдог вэ? Хэн орой унтаж амардаг вэ? гэдгээр сэдэлжүүлж, хүний амьдрал, үйл ажиллагаа өдөр, шөнийн алинд нь илүү идэвхтэй байдгийг дүгнэн хэлэлцэнэ. - Улирлаас хамаарч хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлт өөрчлөгддөг болохыг ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Өдөр болоход нар гардаг, шөнө од, сар харагддагийг зургаар илэрхийлэх, үлгэр, оньсогоор бусдад таниулах зэргээр хичээлийн агуулгыг бусад хичээлтэй уялдуулж болно. Жишээ нь: шөнө болоход малаа хотлуулдаг (хөдөөгийн хүүхдийн хувьд), гэрлээ (лаа) асаадаг гэх мэтээр сурагчид өөрсдийн амьдралын жишээгээр ярилцах орчин хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ.*	- Унтаж байгаа, өглөө нар мандаж байгаа гэх мэт өдөр шөнийн ялгааг үзүүлсэн зураг, ном - Улирлын ялгааг харуулсан зураг, бичлэг - Сурах бичиг

ХОЁРДУГААР АНГИ

БҮЛЭГ 2.1. БИ

Энэ бүлэгт сурагчид “Миний хичээлийн хэрэглэл”, “Миний бие” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд ойр орчныхоо хүмүүс, байгаль, нийгэмтэй харилцах явцад өөрийгөө нээн таних; сонирхон судлах арга барил эзэмших; эрүүл аж төрөх энгийн дадал, хэвшилд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Ангид байрлах сургалтын хэрэглэгдэхүүнийг хийсэн материалын шинж чанарт үндэслэн ангилах, зөв хэрэглэх
- Биеийн бүтцийн хэсгүүдийг нэрлэх ба ялгаж таних, тэдгээрийн үүргийг тодорхойлох, гадны нөлөөллөөс хамгаалах, эрүүл ахуйн дэглэм баримтлах зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Материалын шинж чанар, биеийн бүтцийн хэсгүүд

Миний хичээлийн хэрэглэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн

2.1а. Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг хийсэн материалаар нь төрөлжүүлэн бүлэглэх	- Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг ямар материалаар хийсэн болохыг нэрлэнэ.
	- Сургалтын хэрэглэгдэхүүнийг материалын шинж чанарт нь голлон анхаарч ангилна. (даавуугаар, арьс ширээр, цаасаар, хуванцараар ба модоор хийсэн гэх мэт)
	- Хичээлийн хэрэглэгдэхүүнийг хийсэн материал ямар шинж чанартай болох талаар таамаглал дэвшүүлнэ.
	- Таамаглалаа батлах туршилт хийнэ (хэврэг, хатуу, уян хатан, ус шингээдэг, соронзон шинж чанартай гэх мэт)
	- Туршилтын үр дүнг бусдадаа тайлбарлан танилцуулна.
	- Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хэрэглэх талаар зөвлөмж бичнэ.
	
	Багшийн анхаарах зүйл:
	- *Сурагчид хичээлийн хэрэглэл гэсэн энэ сэдвийн агуулгаар дамжуулан материалын шинж чанарын тухай анхны төсөөлөл, ойлголттой болох тул сурагчдын өмнөх төсөөллийг тандах, туршилт хийх, зөвлөмж бичих, хэрэлцүүлэг хийх арга зүйг төлөвлөхөд анхаарна.*
	  o *Таамаглал дэвшүүлэх: Төмөр шугам бол бат бөх, харин хуванцар шугам хэврэг, номны хавтас бол усыг удаан шингээнэ, харин дэвтрийн цаас усыг хурдан шингээнэ гэх мэт).*
	  o *Туршилт хийх: Соронз гэх мэт энгийн багаж хэрэгсэл ашиглан шинж чанарыг нь тодорхойлж, юугаар хийсэн болохыг тайлбарлах гэх мэт).*
	  o *Зөвлөмж бичих: Хичээлийн хэрэгсэлээ ариг гамтай хэрэглэх талаар найздаа зөвлөх*
	  o *Хэлэлцүүлэг хийх: Ангид байгаа сургалтын хэрэглэгдэхүүнийг хэн, яаж арчилж хамгаалах тухай ярилцаж болно.*
		- Самбар, самбарын алчуур
		- Ширээ сандал,
		- Ном, дэвтэр, цаас
		- Уян хатан хуванцар, модон ба төмөр шугам
		- Үзэг, харандаа, баллуур, хайч
		- Бусад хичээлийн хэрэглэл
		- Шилэн аяга
		- Дэвтрийн цаас, уугч цаас (сальфетка)
		- Шохойтой буюу кардон цаас (номны хавтас)
		- Сурах бичиг

Миний бие

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.1б. Биеийн бүтцийн нүдэнд харагдах хэсгүүдийг нэрлэж, үүргийг ялган таних	- Хүний биеийн толгой, их бие, дээд доод мөч (гар, хөл), тэдгээрийн нүдэнд харагдах хэсгийг зураг болон өөрийн бие дээр зааж нэрлэнэ. - Хүний биеийн бүтцийн хэсгүүдийг ижил үүрэг гүйцэтгэх байдлаар нь ангилна (хөдөлгөөний, тулгуурын, мэдрэх гэх мэт). - Хүний толгойн хэсэгт байгаа биеийн бүтцийн хэгүүдийг нэрлэж, үүргийг тайлбарлах дасгал ажиллана (нүд, зовхи, сормуус, хөмсөг, ам, хамар, чих гэх мэт). - Биеийн тулгуурын буюу хөдөлгөөнд оролцдог бүтцийн хэсгүүдийг нэрлэж, үүргийг тайлбарлах дасгал ажиллана (нуруу, хөл, гар, хуруу, хумс) - Хүний гар, хөл хөдөлгөөний гол үүргийг хэрхэн гүйцэтгэдгийг өдөр тутмын ажил хөдөлмөрийн жишээгээр тайлбарлана. (Үзэг барих, явах зэрэгт хүний гар, хөлийн хуруу хэрхэн зохилдсон болохыг ажиглах) - Гар хөлийн хуруунуудын ялгаатай байдлыг ажиглуулах, ажил хийхэд зохилдсон байдгийг тайлбарлана. - Нуруу, хөл түшиг тулгуурын үүрэг гүйцэтгэдэг болохыг жишээгээр тайлбарлана. - Эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн их биеийн хэсэг (цээж, бүсэлхий, таазны тойрог) ижил болов уу гэх мэт сонирхолтой асуулт өрнүүлж, дадлага ажил хийнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Бага насны хүүхдүүдэд хүний биеийн эрхтэн гэхээс илүүтэйгээр нүдэнд харагдах биеийн бүтцийн хэсгүүд нь биеийнхээ аль хэсэгт байрладаг, тэдгээр нь хүнд ямар хэрэгтэй зүйл болох тухай ярилцаж, сонирхон судлах боломжийг олгоно.* - *Энэ сэдвийг заахад зарим хүүхдийн хувьд эмзэг байж болзошгүй. Иймд тухайн сурагчийн сэтгэлд ямар нэг таагүй мэдрэмж төрүүлэхгүй байхыг анхаарах хэрэгтэй.* - *Багш хичээлд хүний биеийн бүтцийн зурагт үзүүлэн хэрэглэхээс гадна хүүхэлдэй тоглоомыг ашиглаж болно.* - *Хүүхэд бүрт анхааралтай хандаж ямар нэг гэмтлээс нүд, чих, гар, хөлөө хамгаалж байх талаар сургалтын явцад анхааруулж сануулга өгч байх нь зүйтэй.* - *Хичээлийн явцад сурагч бүрийн хичээлд оролцох идэвхийг урамшуулан дэмжиж, сурагчийн өөрийн үнэлгээний хуудсыг хэрэглэж болно.*	- Хүний биеийн бүтцийг харуулсан биет үзүүлэн - Зурагт үзүүлэн - Сурах бичиг

2.1в. Биеийн бүтцийн хэсгүүдийг хамгаалах аргуудыг жишээгээр тайлбарлах	- Хүний толгой, нуруу, гар хөл, нүд зэрэг биеийн хэсгүүдийг гадны нөлөөллөөс хэрхэн хамгаалах талаар таамаглал дэвшүүлж ярилцана. - Сурагчдын таамаглалын ялгаатай хэсгийг самбарт тэмдэглэж харилцан ярилцана. - Боломжтой нэг аргыг сонгон зөв буруу эсэхийг ярилцана. Жишээ нь: Найз нөхөдтэйгөө тоглох явцдаа унаж бэртэхээс болгоомжлохын тулд хурдаа тохируулах, ном унших, зурагт үзэхдээ холоос харах, сандалд суухдаа хэтэрхий бөхийж, хазгай суухгүй байх зэрэг жишээг сонгон хэлэлцүүлэг өрнүүлнэ. - Бичих, цаас базах, цаас хайчлах үзгээ зөв барих зэрэг үйлийг хийхэд аль хуруунууд илүү үүрэг гүйцэтгэж, хэрхэн оролцож байгааг ажиглана. - Хүний гар, хөл хөдөлгөөнд гол үүргийг гүйцэтгэдэг тул эвгүй хөдөлгөөн хийж, яс хугарч гэмтэхээс урьдчилан сэргийлэх талаар ярилцана. - Нурууны ясны хөгжилд өөрчлөлт орох шалтгааныг тайлбарлаж, урьдчилан сэргийлэх аргад суралцах дасгал, даалгавар гүйцэтгэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Нуруу, хөл нь түшиг тулгуурын үүрэг гүйцэтгэдэг тул зохистой хөдөлгөөн хийх, зөв суух зэрэг дадал хэвшил болгох зүйлийг анхааруулна.* - *Мөн бэртэж гэмтэхээс өөрийгөө хамгаалах энгийн аргуудыг эзэмшүүлэхэд анхаарна.*	- Биет үзүүлэн - Ажил хөдөлмөр хийж байгааг харуулсан зурагт үзүүлэн - Зөв суух, буруу сууснаас болж хүний нуруунд гарсан өөрчлөлтийг харуулсан зурагт үзүүлэн - Сурах бичиг

БҮЛЭГ 2.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Энэ бүлэгт сурагчид “Манай гэрийнхэн”, “Миний гэр орон” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд ойр орчныхоо хүмүүстэй харилцах; сонирхон судлах арга барил эзэмших; аюулгүй байдлыг эрхэмлэх дадал, хэвшлийг төлөвшүүлэх агуулгыг судална. Үүнд:

- Аав, ээжийнхээ ах дүүсийг бусдад танилцуулах, өөрийн аюулгүй байдлыг эрхэмлэн, шаардлагатай утасны дугааруудыг тогтоож хэрэглээ болгох.
- Юмсыг ажиглаж, зүг чигийн баримжаатай болох, эргэн тойронд байгаа зүйлс амьдралд хэрхэн нөлөөлдөг болохыг тодорхойлж, аюулгүй байдлыг эрхэмлэх зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Ахан дүүс, авга, нагац, тусгай дугаар, зүг чиг

Манай гэрийнхэн

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.2а. Аав, ээжийнхээ ах дүүс (авга, нагац гэх мэт)-ийг модны мөчир хэлбэрээр зураглаж, танилцуулах	- Аавынхаа ахан дүүсийг нэрлэж бичнэ. Тэдгээрийг авга гэж нэрлэдэг болохыг тайлбарлана. - Ээжийнхээ ахан дүүсийг нэрлэж бичнэ. Тэдгээрийг нагац гэж нэрлэдэг болохыг тайлбарлана. - Өөрийн аав, ээж, авга, нагацыг модны мөчир хэлбэрээр зураглан дүрсэлж бусдад танилцуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Гэрийнхнийхээ фото зургийг ашиглах гэх мэт сонирхолтой арга зүйг сонгоорой. Гэхдээ багш ангийн сурагчдын гэр бүлийн талаар хичээл орохоос өмнө сайн судалсан байх хэрэгтэй. Учир нь зарим сурагчдын хувьд энэ арга зүй тохиромжтой биш байж ч болох талтай.*	- Зураглан тэмдэглэх хуудас - Гэрийнхний фото зураг - Аав, ээжийнхээ ах дүүсийн нэрсийг асууж тэмдэглэл хөтөлсөн дэвтэр - Сурах бичиг

	- Энэ насны сурагчдад аав, ээж болон гэрийнхний тусламжтайгаар төрөл садны хүмүүсээ (авга, нагац гэх мэт) нэрлэж, модны мөчир хэлбэрээр зураглан бусдад танилцуулах арга зүйг сонгох нь тохиромтой арга зүй байж болно. Анги ахих тусам дүрс ашиглан угийн бичгийг зураглан хөтлөх аргыг гүнзгийрүүлэн судлах болно.	
2.2б. Нэн шаардлагатай утасны дугаарууд (101, 102, 103, 109)-ыг хэрэглэхийн учрыг тайлбарлах	- Эмнэлгийн тусламж, цагдаа, гал, онцгой байдлын тусламжийн машин дуут дохио хэрэглэдгийн учрыг тайлбарлах дасгал ажиллана. - Нэн шаардлагатай утасны дугаарын таних, тэмдэг, тэмдэглэгээг ялган таних дасгал ажиллана. - Шаардлагатай утасны дугаарыг мэдсэнээр гэрийнхэндээ хэрхэн тусалж болох талаар ярилцаж, тайлбар хийнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Тусламжийн машины дуут дохио, таних тэмдэг, утасны дугаар бүхий хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, гэр, анги танхимд байрлуулж болно. (Эмнэлгийн тусламж, цагдаа, галын тусламжийн машин, дуут дохио,тэмдэг, утасны дугаар)*	- Түргэн тусламж, гал команд, цагдаагийн гэх мэт байгууллагуудын онцлогийг харуулсан зурагт хуудас - Сурталчилгааны материал байж болно - Сурах бичиг

Миний гэр орон

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.2в. Гэр, байрнаасаа сургууль хүрэх замыг заах, үндсэн ба завсрын зүг чигийг тодорхойлох	- Өмнөх ангид үзсэн агуулгыг бататган үндсэн 4 зүгийг тодорхойлох тоглоом тоглох ба дасгал ажиллана. - Сургууль хаана байдгийг тодорхойлохдоо үндсэн ба завсрын зүг чигийг дөрвөн зүгийн зураглал ашиглан баримжаална. - Гэрээс сургууль хүрэх замын зураг зурж, хүрэх замыг заах, хаана юу байгааг нэрлэж аюулгүй байдлыг эрхэмлэх дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** *- Багш хичээлдээ дөрвөн зүгийн зураглал болон луужин ашиглаж болно.* *- Сурагчид үндсэн 4 зүгийг мэдэхээс гадна завсрын зүгийг ялган таньж сурах дасгал, даалгавар, тоглоом, дүрд тоглох зэрэг олон арга зүйг хэрэглэн хичээлийг зохион байгуулж болно.*	- Зүг чигийг тодорхойлох тоглоом - Зүг чигийн зураглал - Зурагт үзүүлэн - Хатгагч зүү - Сурах бичиг

2.2г. Гэр, байрны орчин тойронд байгаа зүйлс нь амьдралд хэрхэн нөлөөлдгийг жишээгээр тайлбарлах	- Гэр, байрны орчин тойронд байгаа эд зүйлс болон өдөр тутам хэрэглэдэг үйлчилгээг ажиглана (Үүнийг ажиглаж ирэх талаар багш урьдчилан гэрийн даалгаварт өгсөн байна).
	- Гудамжны гэрэлтүүлэг, чийдэн асдаг эсэх, чийдэн асахад юу хэрэгтэй байж болох зэргийг жишээ болгон хичээл зааж болно.
	- Үүний тулд чийдэн асаах туршилтын хичээлийг төлөвлөж хэрэгжүүлнэ.
	  o Чийдэн хэрхэн асдаг талаар таамаглал дэвшүүлэх
	  o Чийдэн асаахад юу хэрэгтэй талаар ярилцах
	  o Гар чийдэн болон зай ашиглан гэрэл асааж, хэрхэн юунд ашиглаж болох талаар хэлэлцэх
		- Зай, түүний суурь
		- Дамжуулагч утас
		- Жижиг чийдэн, чийдэнгийн суурь
		- Сурах бичиг

	- Гэрэлтүүлэг, чийдэн асах нь аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй болохыг дүгнэж тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Чи харанхуйд гутлаа үдэх хэрэгтэй болсон чамд юу хэрэгтэй вэ? гэх мэтээр хичээлээ сэдэлжүүлэн сурагчдын сонирхлыг төрүүлээрэй.* - *Хичээлд батарей болон зайгаар ажилладаг зүйлсийг ашиглана. Шинэ жилийн гацуур чимэглэдэг чийдэн, дуут ил захидлын гэрлийг ашиглаж болно. Ханын залгуур ашиглахаас татгалзаарай.*	

БҮЛЭГ 2.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Энэ бүлэгт сурагчид “Сургуулийн гадаад орчин”, “Сургуулийн дотоод орчин” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Сургуулийн эргэн тойрон дахь зам, барилга, тоглоомын талбай, ногоон байгууламжийг ажиглан эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зүйлийг тодорхойлох
- Анги танхимд ургах тасалгааны ургамлын ургах орчны онцлогийг ажиглаж, төрлөөр нь ангилах зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Дуу чимээ, дүрэм, журам, эрүүл мэнд, тасалгааны ургамал

Сургуулийн гадаад орчин

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.3а. Сургуулийн гадаад орчны дуу чимээний талаар жишээ гаргаж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг хэлэлцэх	- Сургуулийн гадаа гарч хаана ямар барилга, байгууламж, зам тээвэр, харилцаа холбоо, зүлэг ногоо байгааг ажиглана. - Сургууль орчмын зураглал дээр дуу чимээ ихтэй гурван газрыг дүрсээр тэмдэглэнэ. - Ямар учраас ийм тэмдэглэгээ хийснээ бусдадаа тайлбарлана. - Дуу чимээ эрүүл мэндэд эерэг болон сөрөг нөлөө үзүүлж болох талаар ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Сургууль орчмын зураглалыг багш энэ насны сурагчдад ойлгомжтой байдлаар урьдчилан бэлтгэсэн байна.* - *Зураг дээр сургуулийн орчинд гарах дуу чимээ ихтэй газрыг тэмдэглэх өнгийн үзэг болон дүрс бүхий наадаг цаасыг бэлтгэнэ.* - *Хэлэлцүүлэг хийх нь орчин тойрноо ажиглан үнэлэлт дүгнэлт өгөх, эрүүл мэнд, аюулгүй байдалдаа анхаарахад тустай байх болно.*	- Сургууль орчмын план зураг - Тэмдэг, тэмдэглэгээ бүхий хуудас - Өнгийн харандаа - “Аюултай”, “аюулгүй” гэдгийг тэмдэглэх тэмдэглэгээ буюу наадаг цаас - Сурах бичиг

Сургуулийн дотоод орчин

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.3б. Ангид ургадаг ургамал олон төрөл болохын тодорхойлж, ангилах	- Сонгож авсан 4 өөр зүйлийн тасалгааны ургамлыг ажиглан, харагдах байдлаар нь ангилах (навчаараа гоёдог, цэцгээрээ гоёдог, унжиж ургадаг, шүүслэг ургамал гэх мэт) - Гэрэл ба ус чийгт дуртай ургамлыг дүрс, тэмдэглэгээ ашиглан ялгана. - Ургамлын онцлог шинжийг мэдэж арчлах энгийн аргыг тайлбарлана. - Тасалгааны ургамлын ач тусыг тодорхойлж, ангид ургаж байгаа ургамлыг арчлах ажлын хуваарь гаргаж мөрдөнө. - Гэр, сургуулиасаа удаан хугацагаар хол явах тохиолдолд гэр, ангид байгаа ургамлаа яаж хамгаалах тухайгаа ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш ангид ургаж байгаа тасалгааны ургамлыг гадаад шинж, орчны ялгаатай нөхцөлд ургах байдлаар нь ангилах дасгал ажиллуулна. Тухайлбал: Ургамлыг ургах байдлаар нь:* o *гоёмсог цэцэглэдэг (хайтан, сарнай, ялдам цэцэг, цэгцүүхэй, шимтэглээ, алаг цэцэг)* o *гоёмсог навчтай (удам бор, эрээн халгай, муутуу цэцэг, мөнхрөө, хэрээн нүд)* o *унжиж ургадаг буюу ороонго (багцхан, ороогуулгана)* o *шүүслэг навчтай (зузаалай, зуун наст, кактус) ургамал гэх мэт ангилна.* - *Орчны ялгаатай нөхцөлд ургах байдлаар нь:* o *гэрэлд дуртай (✷)* o *гэрэлсэг (❋)* o *сүүдэрт дуртай (❍)* o *сүүдэрт тэсвэртэй (●) гэж ялган ангилуулж хаана байрлуулах (гэрэлд дуртай ургамлыг урд талын цонхон дээр байрлуулах, гэрэлсэг ургамлыг нарны хурц тусгалаас хамгаалах гэх мэт), яаж арчлах (зузаан шүүслэг навчтай ургамлын услах хугацааг уртасгах гэх мэт) аргад сургахыг чухалчлаарай.*	- Олон төрлийн тасалгааны ургамал - Тасалгааны ургамал арчлах энгийн багаж хэрэгслэлүүд - Дүрс тэмдэглэгээ бүхий карт - Видео хичээл (Тасалгааны ургамлын арчилгаа, зөвлөгөө) https://www.youtube.com/watch - Сурах бичиг

БҮЛЭГ 2.4. МИНИЙ НУТАГ

Энэ бүлэгт сурагчид “Орон нутаг ба хүмүүс”, “Орон нутаг ба байгаль” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогтой танилцах, хүмүүсийн хөдөлмөрийг бахархан хүндэтгэх, хувь нэмэр оруулах
- Орон нутгийн ургамал, амьтныг ажиглах, орчны ялгаатай байдалд ургамал, амьтан дасан зохицдог болохыг тайлбарлах
- Амьдарч байгаа орон нутгийнхаа байгаль, түүх, соёлын онцлогоос мэдэж, түүгээр бахархах сэтгэлгээтэй болох зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Ажил хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, амьдрах орчин, түүхийн дурсгалт газар

Орон нутаг ба хүмүүс

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.4а. Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогийг жишээгээр тайлбарлах	- Орон нутгийн хүмүүсийн юу хийж, хэрхэн аж төрдгийг (ажил хөдөлмөр, эрхэлдэг аж ахуй, тэмдэглэлт үйл явдал г.м)-ийг мэдэж танилцах, аялал хийж болно - Мэдсэн зүйлээ тэмдэглэж, нутгийн хүмүүсийн эрхэлдэг аж ахуй, ажил мэргэжлийн онцлогийн талаар мэдээлэл цуглуулна. - Үзвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэр, уул уурхай гэх мэт чиглэлээр хүмүүс юу хийж байгаа талаар үзэсгэлэн гаргаж, танилцуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Аялалд явахдаа хэн аялалыг удирдаж байгаа, хэнтэй хамт явсан, хаашаа явсан, хэдэн цагт хөдөлсөн, хэзээ ирэх, хэнтэй ямар утсаар холбоо барих зэргийг урьдчилан төлөвлөх ба сургуулийн удирдлагад тэмдэглүүлж, хүүхдийн аюулгүй байдалд анхааараарай.* - *Мөн эцэг эх, зарим ажил мэргэжлийн хүмүүсийг хичээлд "зочин багш"-аар урьж оролцуулж болно.*	- Танилцах аялал хийх удирдамж, маршрут - Аялалын тэмдэглэл хөтлөх хуудас - Аялалын тухай мэдээлэл цуглуулах, зургийн аппарат, гар утас, камер гэх мэт - Сурах бичиг
2.4б. Нутгийнхаа томоохон уул, ус, байгалийн болон түүхийн дурсгалт газрыг нэрлэх, танилцуулах	- Нутгийнхаа томоохон уул, усны зураг цуглуулж, нэрлэнэ. - Нутгийнхаа бахархах зүйл, домог түүхийг уншиж танилцана. Ахмад хүмүүсийг урьж домог хууч, түүхийг яриулж болно. - Өөрийн амьдарч буй нутгийнхаа тухай дуу, шүлгийг сурч, түүгээр бахархах бусдад зааж дэлгэрүүлэх үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлнэ. - Цуглуулсан мэдээллийг ашиглан бяцхан ном хийж болно. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Үйл ажиллагааг төлөвлөхийн өмнө сурагчдын өмнөх төсөөллийг тандана.* *Нутгийнхаа томоохон уул, усны нэрийг бичээрэй.* ..... *Манай нутгийн уул усны тухай ямар домог түүх, дуу шүлэг байдаг вэ? Нэрлэн бичээрэй.* ..... *Нутаг орныхоо талаар юу мэддэг чамд ямар сэтгэл төрсөн тухайгаа бичээрэй.* ……..... *Нутаг орныхоо тухай өөр юу мэдмээр байгаагаа бичээрэй.* ..... - *Хүүхэд өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, чин сэтгэлээсээ хүндэтгэсэн, хайрласан, бахархсан сэтгэлийг төрүүлэхүйц үйл ажиллагаануудыг төлөвлөн бэлтгэнэ. Үүний тулд:*	- Тухайн орон нутгийн томоохон уул ус гол мөрөн, дурсгалт газруудын тухай зураг, бичлэгүүд - Домог түүхийн тухай бичвэр үзүүлэн - Уул ус, байгаль дэлхий, ургамал, амьтантай хүмүүс хэрхэн харьцаж буй зургууд - Сурах бичиг

	o *Нутгийн томоохон уул усны нэр, домог түүхт зураг, бичлэгүүдийг бэлтгэнэ.* o *Нутгийнхаа тухай, дуу шүлэг, домог түүх, хэрхэн үүссэн талаарх мэдээлэл цуглуулна.*	

Орон нутаг ба байгаль

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.4в. Ургамал, амьтны амьдрах орчны ялгаатай байдлыг ажиглаж, амьдрах орчиндоо дасан зохилддог болохыг жишээгээр тайлбарлах	- Ургамал, амьтны амьдрах орчныг ажиглаж, ургамал, амьтан амьдрах орчиндоо хэрхэн дасан зохилдсон болохыг жишээгээр тайлбарлана. - Гэрэлтэй, харанхуй, өдөр шөнө нь ургамал, амьтанд хэрхэн нөлөөлдөгийг зарим, амьтан ургамлаас ажиглаж, хүснэгтэд тэмдэглэнэ. - Жилийн 4 улиралд болон байгалийн янз бүрийн орчинд амьд бие хэрхэн дасан зохилдож амьдардаг болохыг жишээгээр тайлбарлана. Жишээ нь: туулай өвөл цагаан, зун бор болдог, тэмээ говьд амьдардаг зэргийн учрыг тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Орчны ялгаатай байдал ургамал, амьтанд хэрхэн нөлөөлдгийг мэдэхийн тулд баримт нотолгоо цуглуулж, ажиглах, турших, удирдамж заавpыг мөрдөх, ажлын үе шатыг тэмдэглэх үйлд шатлан сургахад анхаараарай. Тухайлбал: Өмнөх бүлэгт сурагчид тасалгааны ургамлын тухай үзсэн байгаа тул өдөр, шөнө, улирал, амьдрах орчны ялгаатай байдал ургамалд хэрхэн нөлөөлж байгааг ажиглуулах, шаардлагатай тохиолдолд амьтны биед гарсан өөрчлөлт, зохилдолгоог харуулсан бичлэг үзүүлж болно. Жишээ нь амьтад хэзээ ичээнд ордог, Яагаад? Шувууд хэзээ нүүдэллэж ирдэг, Яагаад? Муур харанхуйд юмыг сайн хардаг, Яагаад? Тэмээ говьд амьдрахад зохилдсон байдаг, Яагаад? гэх мэт*	- Ургамал, амьтны дасан зохилдолгоог харуулсан зурагт үзүүлэн - Сурах бичиг

БҮЛЭГ 2.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Энэ бүлэгт сурагчид “Эх орон, эх дэлхий” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Гэрэл ба харанхуй, гэрэл ба сүүдэр, гэрэл ба халуун хүйтний холбоо хамаарлыг ялган таних**,** байгаль болон нийгмийн юмс үзэгдэл улирлаас хамааралтай өөрчлөгддөгийг тайлбарлах
- Цаг агаарын байдал хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг ойлгож, амьдрах арга ухаанд суралцах зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо*:* Термометр, гэрэл үүсгэгч, сүүдэр, жилийн дөрвөн улирал, сар, байгаль, нийгмийн юмс үзэгдэл, цаг агаарын мэдээ

Эх орон, эх дэлхий

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
2.5а. Гэрэлтэй ба сүүдэртэй газрын халуун, хүйтний ялгааг термометр ашиглан тодорхойлох	- Эргэнд тойронд байгаа гэрэл гаргадаг биеүдийг нэрлэнэ. - Харанхуй ба гэрэлтэй, халуун ба хүйтэн байх нь гэрэл үүсгэгчтэй холбоотой эсэх талаар таамаглал дэвшүүлж ярилцана. - Сүүдэр үүсэх нь гэрэл үүсгэгчтэй холбоотой болохыг туршилт хийж нотолно. - Гэрэл үүсгэгч ба биетийн байрлалыг өөрчилж сүүдрийн хэмжээ өөрчлөгддөгийг ажиглаж тайлбарлана. - Цонхон дээр хар ба цагаан өнгийн ижил хэмжээтэй хоёр цаас наагаад 15–20 минутын дараа гараа тавьж үзээд юу мэдэрснээ бусдадаа тайлбарлана. - Мөн хар ба цагаан өнгийн дугтуй хийж, цонх ба нартай газар байрлуулна. Дугтуйн доторх термометрийн заалтыг 15 минутын дараа тэмдэглэн үр дүнг харьцуулан дүгнэлт гаргаж ярилцана. - Гэрэл ба халуун, хүйтний холбоо хамаарлын талаар юу гэж таамаглаж байсан, туршилтаар ямар үр дүн гарч байгааг дүгнэн ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Гэрэл гаргадаг ба гэрэл гаргадаггүй биеүдийг ангилуулаад, гэрэл гаргадаг биеүдийг гэрэл үүсэгч гэж нэрлэдгийг таниулна.* - *Проектор, дэлгэц ашиглан сүүдэр үүсгэж тоглох, сүүдэр үүсэх нь гэрэл үүсгэгчтэй холбоотой, гэрэл үүсгэгч болон биеийн байрлалаас сүүдрийн хэмжээ өөрчлөгддөг болохыг таниулах туршилтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ.* - *Сурагчдын сонирхолыг татахын тулд хайрцаг дотор тод өнгийн зурагтай цааснууд нааж жижиг нүхээр ажиглуулах, дараа нь хажуу талаас нь гэрэл тусгаад дахин харуулах дадлага ажил хийлгэж, харанхуй болох нь гэрэл үүсгэгчтэй холбоотой болохыг тайлбарлана (гар чийдэн ашиглаж болно).* - *Нарнаас гэрэл ба дулаан ирж байгааг хялбар туршилтаар илрүүлэх сургалтын орчин ба хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ (хар ба цагаан өнгийн дугтуй, термометр гэх мэт).* - *Термометрээр хэмжилт хийх, заалтыг зөв унших, аюулгүй ажиллах, үр дүнг тэмдэглэх хүснэгтийг бэлтгэсэн байна.*	- Гар чийдэн, лаа гэх мэт гэрэл үүсгэгч - Проектор - Термометр - Хар, цагаан өнгийн дугтуй - Сурах бичиг
2.5б. Жилийн 4 улирал тус бүрд хамаарах саруудыг нэрлэж, улирлын ялгааг харьцуулан тодорхойлох	- Гарын сарвууны үеүүдийн тусламжтайгаар жилийн 4 улиралд хамаарагдах саруудыг нэрлүүлэх дасгал ажиллана. Тэгш, сондгой хоногтой саруудыг хүснэгтэд тэмдэглэнэ. - Саруудыг 4 улиралд хуваж, ангилна. - Өвөл, хавар, зун, намрын улиралд ямар сарууд хамрагдаж байгааг нүдлэх дасгал ажиллана.	- Жилийн 4 улирлын зураг - Сурах бичиг

2.5в. Байгалийн юмс үзэгдэл улирлын ялгаанаас хамаарч өөрчлөгддөгийг жишээгээр нотлох	- Байгалийн юмс, үзэгдэл улирлаас хамаарч өөрчлөгддөгийг видео бичлэг, богино хэмжээний кино үзэж тодорхойлох дасгал ажиллана. Жишээ нь: Намар өвс ургамал шарладаг, хавар ногоорч эхэлдэг гэх мэт - Байгалийн үзэгдлийг ажиглаж, тодорхойлох дасгал ажиллана. Жишээ нь: Голын мөс хайлж байгаа зургийг харж хавар гэдгийг ялгах гэх мэт - Тухайн улиралд гарч буй өөрчлөлтүүдийг жишээгээр нотолж харуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Байгалийн үзэгдэл улирлаас хамаарч өөрчлөгддөг талаар сурагчдын өмнөх төлөөлөл байгаа эсэхийг анхаарч, нэмэлт агуулгаар хөгжүүлэх дасгал бэлтгээрэй.* - *Гол нуур хэдийд яагаад хөлддөг, цонх яагаад цантдаг, хайлж байгаа цас, мөс, шарлан унаж байгаа навч зэргийг ажиглуулна. Хотын хүүхдийн хувьд цонх цантах, зам талбайд мөсөн бүрхэвч үүсэх, усан оргилуур хэдийд ажилладаг, хүүхдийн паркад аль улиралд очдог гэх зэргээр жишээ татахад тохиромжтой бол хөдөөний хүүхдийн хувьд гол, нуур хөлдөх, гэсэх, цас орох зэргээр жишээ авч болно.*	- Жилийн дөрвөн улиралд явагдах байгалийн үзэгдлийн зураг - Ажиглалтын дэвтэр - Сурах бичиг
2.5г. Хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэлт улирлаас хамаарч өөрчлөгддөгийг тодорхойлох	- Хавар, зун, намар, өвөл хүмүүс ямар ажил хөдөлмөр эрхэлдэг болохыг зурагт үзүүлэн ашиглаж тайлбарлана. Хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай байдлыг улирал ба сараар тодорхойлох дасгал ажиллана. Жишээ нь: Зуны улирал эхлэхэд сурагчид амарна. Хавар хүмүүс мод ургамал тариалдаг. Намар сурагчдын хичээл эхэлдэг гэх мэт - Өөрсдийн ахуй амьдрал улирлаас хэрхэн хамаардаг болохыг жишээгээр тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Улирал ба сараар хүний ажил хөдөлмөр өөрчлөгддөг болохыг таниулах жишээнүүдийг бэлтгэхдээ сурагчдын өмнөх төсөөллийг хөгжүүлэх агуулгыг сонгоорой. Үүнд: Ногоо хураах, газар хагалах, ногоо тарих, мал төллөх, хадлан хадах зэрэг ажил хөдөлмөрийг харуулсан зураг ашиглан ямар улиралд, хэддүгээр сард явагдах үйл явц болохыг тайлбарлана.*	- Газар хагалж, ногоо тарьж, ногоо хурааж, хадлан хадаж, мал төллөж байгаа гэх мэт улирлын ялгаатай ажил хөдөлмөрийн зураг - Сурах бичиг
2.5д. Цаг агаарын мэдээг сонсож, 7 хоногийн цаг агаарыг зураг, дүрс, тэмдэгтээр илэрхийлэх	- Цаг агаарын урьдчилсан мэдээг телевизээс үзэх ба радиогоор сонсоно. - Тэнгэрийн байдлыг шинждэг ардын уламжлалт аргуудын талаарх мэдээлэл цуглуулна. - Цаг агаарын байдлыг тэмдэглэсэн дүрсийг ялган таньж зурж тэмдэглэдэг болно. - Цаг агаарын байдалд тохируулж хувцсаа сонгон өмсөх дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Телевизийн цаг агаарын мэдээ болон интернэтээс (tsag-agaar.mn) цаг агаарын зураг авч ашиглаж болно.*	- Цаг агаарын байдлыг харуулсан (цас, бороо орсон, салхи шуургатай болон тогтуун үеийн г.м) зурагт үзүүлэн - Сурах бичиг

	- *Янз бүрийн цаг агаарын байдлыг үзүүлсэн (цас, бороо орсон, салхи шуургатай болон тогтуун үеийн г.м) зураг цуглуулж бэлтгэнэ.* - *Хүүхдүүдийг цаг агаар, улирлын онцлогт тохируулан хувцсаа зөв сонгон өмсөх чадвартай болгохын тулд ажлын хуудас бэлтгэж ажиллуулах боломжтой.*	
2.5е. Цаг агаарын байдал хүмүүсийн амьдралд хэрхэн нөлөөлдгийг жишээгээр батлах	- Тэнгэрийн байдлыг шинждэг энгийн аргуудын талаар ахмад хүмүүстэй уулзаж ярилцана. - Тухайн орон нутгийн цаг агаарын өөрчлөлтийг харуулсан зурагт үзүүлэн, бичлэг үзнэ - Өөрсдийн ахуй амьдрал, цаг агаараас хамаарч хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглан шинжиж батлан тайлбарлана. - Их хүйтэн, халуун, салхи, шуурга, аянга цахилгаантай үед учирч болзошгүй аюулаас өөрийгөө хамгаалах, бэлтгэлтэй байх талаар ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш байгалийн аюултай үзэгдлийн үед гадагшаа гарахгүй байх, аянга цахилгаантай бороотой үед цахилгаанаар ажилладаг зүйлс, гар утсаа унтраах, шуургатай үед цонхоо хаах зэргийг сурагчдад сануулаарай.* - *Цаг агаарын байдалд тохируулж хувцсаа сонгон өмсөх талаар хэлэлцэх гэх мэт цаг агаарын онцгой үзэгдэл болох үед урьдчилан сэргийлэх, авах арга хэмжээний талаар ойлгуулахад анхаарна.* - *Өвөл цаг агаарын тааламжгүй нөхцлөөс болж хайрагдах, осгох, хөлдөх зэргээр эрүүл мэндэд учирч болох эрсдлийн талаар ойлгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж болно.*	- Цаг агаарын байдал хүмүүсийн амьдралд нөлөөлж буй зурагт үзүүлэн бичлэг

ГУРАВДУГААР АНГИ

БҮЛЭГ 3.1. БИ

Энэ бүлэгт сурагчид “Миний хичээлийн хэрэглэл”, “Миний бие” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд байгаль, нийгэмтэй харилцах явцад өөрийгөө нээн таних; сонирхон судлах арга барил эзэмших; эрүүл аж төрөх энгийн дадал, хэвшилд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Хичээлд хэрэглэж буй багаж хэрэгслийг үүрэг зориулалтаар нь ялган таньж, аюулгүйгээр сонгож хэрэглэх
- Амьд ба амьд бус биеийг ялган таних, амьд биеийн үндсэн хэрэгцээг мэдэрч, биеийн өсөлт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох
- Хүн ба амьтны мэдрэхүй, гадаад орчинд үзүүлэх хариу үйлдлийг туршилт, жишээгээр нотлох зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Багаж хэрэгсэл, аюулгүй сонголт, амьд биеийн үндсэн 5 шинж, биеийн өсөлт хөгжил, мэдрэхүй

Миний хичээлийн хэрэглэл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.1а. Хичээлд хэрэглэж буй өгөгдсөн багаж, хэрэгслийг үүрэг зориулалтаар нь ялган таньж, аюулгүй байдлыг ханган зөв сонгож хэрэглэх	- Хичээлд хэрэглэдэг багаж хэрэгслийг үүрэг зориулалтаар нь зөв хэрэглэх туршилтыг төлөвлөж хэрэгжүүлнэ. Тухайлбал: ургамлын үр соёолуулж, өөрчлөлтийг хэмжих гэх мэт. - Шугам, цаг, өсгөгч шил, термомерт зэрэг хэмжигч багаж ашиглан хэмжилт хийнэ. - Хэмжилтийнхээ үр дүнг бусдадаа тайлбарлана. - Үр дүнг зураг, диаграмм болон хүснэгтээр илэрхийлнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Нэгдүгээр ангид хичээлийн хэрэглэлийг зөв сонгох, ариг гамтай хэрэглэх, зөв хадгалах чадварт суралцсан. Харин хоёрдугаар ангид хичээлийн хэрэглэл гэдэг бүлгээр дамжуулан бага ангийн сурагчдад материалын шинж чанарыг таниулж хичээлийн хэрэглэлээ зөв хэрэглэх чадварт сургахад анхаарч байсан бол энэ ангид хичээл сургалтад хэрэглэдэг энгийн багаж хэрэгсэлийг зөв хэрэглэх гэдгээр агуулга гүнзгийрч байгаа болно.* - *Энэ суралцахуйн зорилтыг эзэмшүүлэхэд үрийн ургах нөхцлийг таниулах явцдаа багаж хэрэгслийг зөв хэрэглэж сургах агуулгыг сонгосон болно. Туршилт хийж байгаа тул 1 цагийн хичээлээр бус тасралтгүй 7 хоногийн турш ажиглалт хийлгэж, үр дүнд хүрнэ гэдгийг анхааараарай.* - *Багш сурагчдын ажиглалтын үр дүнг тэмдэглэх ажлын хуудсыг бэлтгэсэн байна.* - *Шилэн аяганд чийгтэй хөвөн дэвсээд буудайн үрийг 2 см (сурагчдаар хэмжилт хийлгэнэ) зайтай тавьж гялгар уутаар таглан гэрэлтэй газар тавьж ургах явцыг өдөр бүр ажиглуулна. Шилэн аяганд термометр байрлуулж заалтыг өдөр бүр тогтмол нэг цагт харж тэмдэглүүлэх ба өрөөний халуунтай харьцуулж дүгнэлт гаргуулна.* - *Хөвөн байнга чийгтэй байхыг анхааараарай. Үр соёолсны дараа анхны навчны уртыг өдөр бүр цаасаар болон утсаар баримжаалуулан хэмжүүлнэ (дараа нь хэмжилтийн уртыг шугам ашиглан илэрхийлж болно).* - *Ургасан хоног ба навчны уртын хамаарлыг диаграммаар илэрхийлүүлж дүгнэлт гаргуулна.* - *Ургасны дараа навчны судлыг өсгөгч шилээр харж дэвтэртээ зурах даалгавар ажилуулна..* - *Сурагчид үр ургахад гэрэл, дулаан, чийг, агаар нөлөөлсөн болохыг дүгнэж ярилцана.*	- Сурах бичигт байгаа туршилтын багажуудыг бэлтгэх - Ажлын хуудас бэлтгэх - Төлөвлөсөн туршилтын дагуу багаж хэрэгслүүдийг бэлтгэх - Сурах бичиг

Миний бие

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.бг. Амьд ба амьд бус биеийг ялган таньж, амьд биеийн үндсэн 5 шинжийг жишээгээр тайлбарлах	- Амьд бие (хүн, амьтан, ургамал), амьд бус бие (ширээ сандал, машин, тоглоом гэх мэт)- ийг амьд биеийн 5 үндсэн шинжээр харьцуулж, ялгааг бичиж тэмдэглэнэ. - Амьд, амьгүй биеийг ялган таньж, хүснэгт болон схемээр зураглал хийнэ. Ямар ялгаатай байгааг бусдад тайлбарлана. - Хүн, амьтан, ургамал нь хооллох, амьсгалах, хөдлөх, мэдрэх, өсөх, үржих зэрэг шинжээр ижил тул амьд бие гэдгийг нотлох дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Энэ насны хүүхдүүд хооллодог, амьсгалдаг, хөдөлдөг, өсдөг, үрждэг гэсэн шинжээр амьд биеийг амьд бус зүйлсээс ялган таньж байгаа эсэхийг ажиглан чиглүүлээрэй.* - *Амьд биеийг нян, эгэл биетэн, мөөг, ургамал, амьтан гэж 5 үндсэн аймагт ангилах боловч энэ насны хүүхдийн төсөөллийн хүрээнд хүн, амьтан, ургамал гэсэн байдлаар ангилуулж болно.*	- Амьд ба амьд бус биесийг онцлог шинжийг харуулсан зурагт хуудас - Бичлэг - Сурах бичиг
3.в. Амьд биеийн үндсэн хэрэгцээг мэдэрч, биеийн өсөлт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийг хэлэлцэх	- Амьд биеийг хоол тэжээлээр нь ангилан бүлэглэх дасгал ажиллана. - Хүний өдөр тутам иддэг хоол хүнсийг зурагт хуудас ашиглан хүнсний ногоо, мах, цагаан идээ, амьтны гаралтай, ургамлын гаралтай, өсөлтийн, илчлэгтэй, амин дэмтэй, гэх мэтээр ангилна. - Хоол хүнийг боловсруулахад шүд ямар үүрэгтэй болох, амны хөндийн ариун цэврийг сахих талаар ярилцана. - Сургуулийн үдийн цай хоолны цэсэд ажиглалт хийж, сайжруулах санал гаргана. - Хоол хүнс нь өсөлт хөгжилтөд хэрхэн нөлөөлдөг болохыг жишээгээр тайлбарлана. - Амьд биеийн хөдөлгөөнийг харуулсан зургаас хөдөлгөөнийг тодорхойлж (сэлэх, мөлхөх, нисэх, үсрэх, гүйх, харайх гэх мэт), хөдөлгөөн хийхийн учрыг тайлбарлана (хоол хүнсээ эрж хайх, аюулаас зугтах, дайснаас биеэ хамгаалах гэх мэт). - Хүний хөдөлгөөн хэрэгцээ, зорилгоороо ялгаатай байдгийг хүмүүсийн хийж буй үйлээс харж тодорхойлно. - Хөдөлгөөн багатай буюу ихтэй байвал хүний биеийн жин ямар байх талаар ярилцана. - Эрүүл хоол хүнс хэрэглэх, идэвхтэй хөдөлгөөн хийхийн давуу талыг хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Энэ насны сурагчдад амьд биеийн үндсэн хэрэгцээг хооллох, хөдлөх жишээгээр таниулах нь бие бялдрын болон оюун ухааны хөгжилд нөлөөлөх байдалтай холбон тайлбарлахад дөхөм байх талтай.*	- Амьд бие тэдгээрийн хоол тэжээлийг харуулсан зурагт хуудас - Хооллох дэглэмийн зураг - Хүний болон амьд биеийн хөдөлгөөн харуулсан зураг - Бие бялдарыг хөгжүүлэхэд чиглэсэн биеийн тамирын хөдөлгөөн - Хоол хүнс, хөдөлгөөний хамаарлыг илэрхийлсэн үзүүлэн - Өндрийн хэмжүүр, жин - Сурах бичиг

	- *Багш хүний хооллох, хөдлөх хэрэгцээнд үндэслэсэн олон янзын үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлснээр бид өсөж том болдог, оюун ухаан хөгждөг гэдгийг ойлгуулж болно. Тухайлбал:* o *Биеийн өндөр, жинг хэмжих багажийг ашиглан өөрийн өндөр, жинг хэмжиж тэмдэглэх* o *Тэмдэглэлээ ашиглан баганан диаграммаар зурж биед гарч буй өөрчлөлтийг тодорхойлох* o *Бие өсөж, том болохын баяр, сэтгэгдлээ бодит жишээгээр тайлбарлах* - *Хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгож хэрэглэх агуулгын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний шошго унших, эрүүл мэндэд тустай хоол хүнсийг ялган таних, өөрийн өглөөний цайны цэс зохиж мөрдөх, сургуулийнхаа үдийн цайны цэсэд ажиглалт хийж санал өгөх гэх мэт идэвхтэй, сонирхолтой үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлж болно.* - *Багш сургуулийн эмчтэй хамтран жил бүр сурагчдын биеийн өндөр, жинг хэмжин эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн, эцэг эхэд мэдээлэл өгч, сурагчдын биеийн өсөлт хөгжилтөд хяналт тавина.*	
3.1г. Хүн ба амьтны мэдрэхүй, гадаад, орчинд үзүүлэх хариу үйлдлийг туршилт, жишээгээр нотлох	- Хүн ба зарим амьтдын мэдрэхүйн эрхтэн, тэдгээрийн гадаад орчиндоо хариу үйлдэл үзүүлэх онцлогийг хэлэлцэнэ. - Хүний мэдрэхүйн эрхтэн (харах, хүрэлцэх, амтлах, сонсох, үнэрлэх)-ий онцлог, орчинд үзүүлэх хариу үйлдлийг туршилт, тоглоомын аргаар илрүүлж тайлбарлана. - Зарим амьтдын аль нэг мэдрэхүй илүү хөгжсөн тухай жишээ баримт цуглуулж ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Амьд биеийн мэдрэхүйн эрхтний ялгаатай байдал, мэдрэхүйн эрхтний онцлог, орчинд үзүүлэх хариу үйлдлийг туршилт, тоглоомын аргаар нотлох арга, аргачлалуудыг багшийн номонд тусгасан бөгөөд багш та баяжуулан заах боломжтой.*	- 100 граммын хэмжээтэй шилэн аяга - Электрон жин - Элсэн чихэр, лимон- нимбэг, давс, тараг, эм, ам зайлах цэвэр ус - Дусаагуур - Хөгжим, лаа, чүдэнз, хүж - Янз бүрийн хэлбэр хэмжээ бүхий бие - Өнгийн цаас - Сурах бичиг - Багшийн ном

БҮЛЭГ 3.2. МИНИЙ ГЭР БҮЛ

Энэ бүлэгт сурагчид “Манай гэрийнхэн”, “Миний гэр орон” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд ойр орчныхоо хүмүүстэй харилцах; сонирхон судлах арга барил эзэмших; аюулгүй байдлыг эрхэмлэх дадал, хэвшлийг төлөвшүүлэх агуулгыг судална. Үүнд:

- Аав, ээжийн ажлын газрыг мэдэх, угийн бичгийг зураглан дүрслэх, хүмүүсийн ажил, мэргэжлийн онцлогийг судлах
- Гэрээс сургууль хүрэх орчны аюулгүй байдлыг үнэлэх чадварт суралцах зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо*:* ураг төрөл, угийн бичиг, мэргэжил, ажлын газар, план зураг

Манай гэрийнхэн

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.2а. Аав, ээжийнхээ садан төрлийг жагсаан, ураг төрлийнхөө 3 үеийг зураглах	- Аав, ээжийнхээ төрөл садныг нэрлэж жагсаан бичнэ. - Угийн бичгийг хөтлөхөд хэрэглэдэг таних тэмдгүүд болон зураглал хийх аргачлалтай танилцаж, 3 үеийн зураглалыг хийнэ. - Өөрийн хийсэн бүтээлээ бусдад тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Өөрийн авга, нагацыг модны мөчир хэлбэрээр зурж танилцуулах аргыг хоёрдугаар ангид судалсан тул энэ удаа өмнөх агуулгыг бататган гүнзгийрүүлж, угийн бичгийн зураглал хийх тэмдэг, тэмдэглэгээг танилцуулж, аав ээж болон бусад хүмүүсийн тусламжтайгаар 3 үеийн зураглал хийх арга зүйг эзэмшүүлнэ.*	- Угийн бичиг хөтлөх загвар тэмдэг тэмдэглэгээ - Ажлын хуудас - Сурах бичиг
3.2б. Аав ээж болон гэрийнхнийхээ мэргэжил, ажлын газрыг ялган нэрлэх	- Аав, ээж, гэрийнхнийхээ мэргэжил, ажлын газрыг бичиж танилцуулна. - Хүмүүсийн эзэмшсэн мэргэжил, ажил хөдөлмөрийн үнэ цэнийн талаар ярилцана. - Зарим ажил мэргэжлийн онцлогийг таниж мэдэх үүднээс санхүүгийн тооцоо хийх зэрэг дасгал ажил хийж болно ***Багшийн анхаарах зүйл:*** - *Аав ээжийн эзэмшсэн мэргэжил, ажлын газрыг тэмдэглэх ажлын хуудас бэлтгэнэ.* - *Зарим эцэг эхийг зочин багшаар хичээлд урьж оролцуулж болно.*	- Ажил мэргэжлийн фото зураг - Албан байгуулагын танилцуулга, мэдээлэл, ил захидал гэх мэт. - Сурах бичиг

Миний гэр орон

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.2в. Гэр, болон ангийнхаа план зургийг таних тэмдэг ашиглан зураглах	- Ангийнхаа бодит зургийг түүний план зурагтай харьцуулж ярилцана. (Ярилцлагаас үндэслэн сурагчид план зургийн тухай ойлголттой болно) - Ангид байгаа эд юмсын байрлал, хэлбэр хэмжээг ажиглаад нэрлэж бичүүлнэ. Бичсэн зүйлүүдээс план зурагт дүрслэгдсэн ба дүрслэгдэж чадаагүй зүйлсийг ялгуулна. Ингэснээр план зурагт зарим эд зүйлсийг оруулахгүй байж болдог юм байна гэсэн ойлголтыг өгнө. - Хажууд сууж буй найзтайгаа хамтран ширээнийхээ план зургийг зурж, юуг, хэрхэн яаж дүрсэлснээ тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *План зурах цаасан дээр зуг чигийг тэмдэглэнэ.* - *План зурагт буулгахдаа дээрээс нь харсан байдлаар ямар дүрслэлийг сонгох вэ? гэдгийг тайлбарлана.* - *4-5-р ангийн Хүн ба байгаль, Математикийн хичээлээр агуулгыг гүнзгийрүүлэн судлах тул энэ ангид биетийг дээрээс нь харсан байдлаар дүрслэх чадвар эзэмшүүлэхэд түлхүү анхааараарай.*	- Гэр, ангийн план зураг - Харандаа, дэвтэр, шугам - Сурах бичиг

3.2г. Гэрээс сургууль хүрэх орчин тойрны зүйлсийг ажиглан, аюултай зүйлсийг тэмдэглэх	- Багшийн өгсөн план зурагт гэрээс хамгийн богино хугацаанд сургууль хүрэх замыг тэмдэглэнэ. - Тэр замд “аюултай зүйлс” байгааг ялгаж, өнгийн цаас наана. Яагаад “аюултай” гэж үзснээ тайлбарлана. - Хичнээн “аюултай” газар байгааг тооцож гаргана. - Аюулгүй явах боломжтой өөр замыг план зураг дээр сонгож тэмдэглэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *4-р ангийн математикийн хичээлээр план зураг маршруттай холбогдох асуудал шийдвэрлэх агуулга гүнгийрч судлах тул багш агуулгын залгамж холбоог нягт уялдуулах үүднээс план зураг зуруулах биш урьдчилан хялбар план зургийг бэлтгэсэн байна.* - *Сурагчид план зургийн тухай ойлголттой болсон тул гэрээс сургууль хүрэх план зурагт “аюултай” гэж үзсэн обьектыг тэмдэглэнэ. Ангийн бүх сурагчид хичээн обьектыг тэмдэглэсэн болохыг нэгтгэж, сурагчдын аюулгүй байдалд анхаарал хандуулаарай.* - *Богино хугацаанд, гэрээсээ сургууль хүрэх дөт замыг сонгох нь цаг хугацаа хэмнэх сайн талтай боловч хамгийн гол нь аюулгүй байх нөхцлийг харгалзах ёстойг тайлбарлана.*	Гэрээс сургууль хүрэх план зураг Сурах бичиг. 36-р хуудас

БҮЛЭГ 3.3. МАНАЙ СУРГУУЛЬ

Энэ бүлэгт сурагчид “Сургуулийн гадаад, дотоод орчин” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Замын хөдөлгөөний дүрмийг баримталж, болзошгүй аюулаас өөрийгөө сэргийлэх
- Ангид ургаж буй ургамлын өсөлт хөгжлийг ажиглан тэмдэглэх, туршилт хийх зэрэг болно.

Бүлгийн нэр томьёо*:* Замын хөдөлгөөний дүрэм, ургамлын өсөлт, хөгжил

Сургуулийн гадаад, дотоод орчин

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.3а. Сургуулийн гадаад орчны аюулгүй байдлыг үнэлж цэгнэх	- Замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг ялган таних дасгал ажиллана. - “Ногоон гэрэл-цагаан шугам” дүрд тоглоно. - Сургуулийн гадаад орчны замын хөдөлгөөнийг ажиглан, сурагчид замын хөдөлгөөний дүрмийг хэрхэн баримталж байгаа болон хаана эрсдэл өндөр байгааг тогтооно. - Дүү нартаа болон найз нартаа зориулж замын хөдөлгөөнд соёлтой оролцох зөвлөмж бичнэ.	- Замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ - Ажлын хуудас - Дүрд тоглох баг - Сурах бичиг

	Багшийн анхаарах зүйл: - *Сургуулийн гадаа гарч сургууль орчмын замын хөдөлгөөнийг ажиглах боломж бүрдүүлээрэй. 5 минутад хэдэн машин өнгөрч байгааг тоолж, цагт, өдөрт хэдэн машин өнгөрч болох тооцоолол хийлгээрэй. Ажиглалтын үр дүнд үндэслэн замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлыг эрхэмлэх ойлголтыг эзэмшүүлэхэд анхаарна.*	
3.3б. Ангид ургаж буй ургамлын өсөлт хөгжлийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх	- Ургамал хэрхэн өсөж хөгждөг талаар тамааглал дэвшүүлэн ярилцана. - Ангид ургаж буй тасалгааны ургамлаас сонгоно. - Хэн, хэзээ, хэрхэн ажиглаж хэмжихийг хамтран төлөвлөнө. Үүнд ургамлыг усалж арчлах үйл ажиллагаа ч хамаарна. - Сонгосон ургамлынхаа өсөлт хөгжлийг ажиглах, илрүүлэх, санаа гаргана. Ургамлын ишний тоо, өндөр, навчны тоо, уртыг (хамгийн том болон, жижиг навчны урт) ажиглаж хэмжиж болно. Шинээр үрслүүлсэн эсвэл шинэ залуу навчны өсөлтийг ажиглах нь илүү хялбар байдгийг анхааараарай. - Сонгосон ургамлаа ажиглаж, хэмжилт хийх, үр дүнг ажлын хуудаст зурж тэмдэглэнэ. - Ажиглалт тэмдэглэлийн үр дүнг бусдадаа танилцуулна ***Багшийн анхаарах зүйл:*** - *Хэмжилт хийхээр сонгосон иш, навчийг бусдаас ялгахын тулд утсаар сулхан уяж тэмдэг тавьж болно.* - *Гэрэл дутагдахад тасалгааны ургамлын иш уртсаж сунах, навчны тоо цөөрөх, ус чийг дутагдахад навч шарлах, хатаж унах зэрэг өөрчлөлт гардаг болохыг ажиглуулах, сорил туршилтыг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан төлөвлөх хэрэгтэй*	- Ургамлын үр - Хөрс - Ургамал суулгах сав, шилэн аяга - Шугам - Дэвтэр - Үзэг - Ажиглалтын хуудас - Сурах бичиг

БҮЛЭГ 3.4. МИНИЙ НУТАГ

Энэ бүлэгт сурагчид “Орон нутаг ба хүмүүс”, “Орон нутаг ба байгаль” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадлыг эзэмших агуулгыг судална. Үүнд:

- Орон нутгийнхаа нийтийн эзэмшлийн газарт баримтлах дэгийг судлах ба хүмүүсийн аж амьдрал, уламжлалт зан үйл, ёс заншлаар бахархах
- Эргэн тойрноо ажиглах, орон нутагтаа ургадаг ургамлыг ургах байдлаар нь ангилах, ялган таних, зөв ашиглаж хамгаалах чадварт суралцах зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* нийтийн эзэмшлийн газар, модлог ургамал, сөөг ургамал, өвслөг ургамал, ойн амьтад, тал хээрийн амьтад, говь цөлийн амьтад, усны амьтад

Орон нутаг ба хүмүүс

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.4а. Орон нутгийнхаа нийтийн эзэмшлийн газар, ашиглалтын талаар мэдээлэл цуглуулж, төрөлжүүлэн бүлэглэх	- Орон нутгийнхаа цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, гудамж, малын бэлчээр, автобусны зогсоол, нийтийн бие засах газрыг нийтийн эзэмшлийн газар гэж нэрлэх болсны учрыг тайлбарлах дасгал ажил хийнэ. - Нийтийн эзэмшлийн газар гэсний учрыг ойлгож, хүмүүс түүнийг хэрхэн хайрлан хамгаалж буй талаар мэдээлэл цуглуулна. - Аялал хийж, өөрсдийн мэдэх цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, гудамж, малын бэлчээр, тариалангийн талбай, тэдгээрийн байршил, зориулалт, ашиглаж, хамгаалж ирсэн мэдээллийг төрөлжүүлэн тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш хичээлдээ орон нутгийн нийтийн эзэмшлийн газруудын үйл ажиллагааг харуулсан бичлэг, зурагт үзүүлэнгүүдийг бэлтгэн ашиглаж болно.* - *Орон нутагт байгаа нийтийн эзэмшлийн газрууд, тэдгээрийн байрлал, ашиглах зориулалт хэрхэн яаж ашиглаж, хайрлан хамгаалж ирсэн цаг хугацааны талаарх ойлголтыг таниулахад аль болох өөрсдийн биеэр очиж үйл ажиллагаатай танилцах аялал экскурсыг зохион байгуулах нь илүү үр дүнтэй гэдгийг багш тооцоолон эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд анхааараарай*	- Нийтийн эзэмшил газруудын нэр байршлыг харуулсан зураг, тэдгээрийг хэрхэн ашигладаг талаарх үйл явдлыг харуулсан бичлэг, фото зураг, аялалын маршрут - Сурах бичиг
3.4б. Нийтийн эзэмшлийн газруудад баримтлах дүрэм, журмыг жишээгээр тайлбарлах	- Нийтийн эзэмшил газарт ямар дүрэм, журам баримталдаг талаар ярилцаж, мэдээлэл цуглуулна. - Нийтийн эзэмшлийн газарт хандаж байгаа хүмүүсийн зөв буруу хандлагын талаар бодит жишээ болон зураг, бичлэг үзэж, зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай дүрэм журмыг жагсаан бичнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Сургалтыг зохион байгуулахдаа дараах үе шатуудыг төлөвлөнө. Үүнд:* o *Сурагчид тухайн агуулгын талаар юуг мэддэг, хэрэгжүүлдэг болохыг тандах асуулт асууна.* o *Тухайн газруудаар аялал хийж танилцуулга хийж болно.* o *Зочин багшийг урьж ярилцлага хийнэ.* o *Дүрэм журмыг ойлгомжтой биелэгдэхүйц байдлаар боловсруулж, хэрхэн дагаж мөрдөх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.*	- Нийтийн эзэмшил газруудын зураг - Тэнд баримтлах дүрэм журмыг харуулсан бичлэг, зурагт үзүүлэн - Сурах бичиг

Орон нутаг ба байгаль

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.4в. Орон нутагт ургадаг ургамлыг харагдах байдлаар нь ангилах, ялган таних	- Орон нутагт ургадаг ургамлыг харагдах байдлаар нь ангилна (мод, сөөг, өвслөг ургамал). - Шилмүүст ба навчит модыг харагдах байдал болон навчны онцлогоор нь ялган таних дасгал ажиллана. - Ногоон ургамлын ач тусыг мэдэж, мод, сөөг, өвслөг ургамлыг усалж арчилахад оролцож, хувь нэмрээ оруулна. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Багш сургалтыг танхимын ба танхимын бус хэлбэрээр зохион байгуулж болно.* - *Анги танхимд ургамлын навчны хатаадас ашиглан ялган таних дадлага ажил явуулж, танхимын бус цагаар байгалийн нөхцөлд ажиглалт хийлгэх хэрэгтэй.* - *Сурагчдад хамгийн ойр байгаа ургамал бол сургуулийн гадаа ургаж байгаа мод, сөөг байдаг тул тэдгээрийг ялган таниулах, услах, арчлах аргад сургахад анхааараарай.* - *Сурагчдыг хичээлээс гадуур үйл ажиллагаанд оролцуулах нь бусадтай хамтарч ажиллах, бие биеэ хүндлэх, ойлгох, туслах зэрэг хамтын үйл ажиллагаанд сургах сайн талтай.*	- Шилмүүст ба навчит модны зураг - Шилмүүст ба навчит модны навч - Мод ургамлыг услах энгийн багаж хэрэгсэл - Сурах бичиг
3.4г. Өөрийн мэддэг амьтдыг ойн, тал хээрийн, усны гэж ангилан бүлэглэж, амьдрах орчны ялгаатай байдлыг жишээгээр тайлбарлах	- Амьтдыг амьдрах орчны ялгаатай байдлаар нь ангилна (ойн, тал хээрийн, говь цөлийн, усны гэх мэт). - Янз бүрийн орчинд амьдардаг амьтдын ашиг шимийн талаар хэлэлцэнэ. - Амьтдыг хайрлах, хамгаалахад өөрийн оруулж чадах хувь нэмрээ тодорхойлж бичнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхээс өмнө сурагчдын сонирхол (гэртээ амьтан тэжээдэг, амьтны тухай ном унших, кино үзэх дуртай, түүнийгээ бусдад ярих сонирхолтой гэх мэт)-ыг тандаж, янз бүрийн сонирхол бүхий сурагчдын холимог баг бүрдүүлэн, багаар ажиллуулах арга зүйг төлөвлөөрэй.* - *Сурагчдад амьд амьтныг хайрлах, ойр байж өсгөж үржүүлэх, үүр оромж барих, арчлах, амьтнаас өөрийгөө хамгаалах дадал хэвшил сургах арга зүйг төлөвлөж хэрэгжүүлэхэд анхааараарай.*	- Ойд, усанд, говь цөлд, тал хээрт амьдардаг амьтдын зураг - Амьтдын ашиг шимийг харуулсан зураг - Сурах бичиг

БҮЛЭГ 3.5. МАНАЙ ДЭЛХИЙ

Энэ бүлэгт сурагчид “Эх орон, эх дэлхий” гэсэн дэд сэдвүүдийн хүрээнд юмс үзэгдлийг сонирхон судлах; хэм хэмжээ, дэглэм сахих; үнэт зүйлийг эрхэмлэх чадвар, дадалд суралцах агуулгыг судална. Үүнд:

- Глобус болон дэлхийн газрын зураг дээр Монгол орон болон түүнтэй хиллэдэг улс орнуудыг зааж нэрлэх
- Монгол орны газрын зурагт томоохон уул нуруу, гол мөрнийг ялган таних зэрэг болно.

***Бүлгийн нэр томьёо**:* Глобус, газрын зураг, тив, улс, арьс өнгө

Эх орон, эх дэлхий

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
3.5а. Глобус, газрын зургийг харьцуулан ялган таних	- Газрын зураг нь газар нутгийг хавтгай цаасан дээр дүрслэн буулгасныг, глобус нь дэлхийг багасган харуулсан загвар гэдгийг ялган таних дасгал ажиллана. - Монгол орныг глобус ба газрын зураг дээр зааж чаддаг болно.	- Глобус - Монгол орны газрын зураг - Сурах бичиг
3.5б. Газрын зургаас тэмдэг, тэмдэглэгээ (хилийн зурвас, нийслэл)-г ялган таньж тайлбарлах	- Газрын зурагт хилийн зурвасыг ямар тэмдэглэгээгээр тэмдэглэсэн болохыг зурна. - Улс орнуудын нийслэлийг ямар тэмдгээр тэмдэглэсэн болохыг ялган таньж, зарим улсын нийслэлийг зааж нэрлэнэ.	- Глобус - Дэлхийн газрын зураг - Зурж тэмдэглэх өнгийн харандаа
3.5в. Глобус ба газрын зурагт далай ба хуурай газрыг өнгөөр ялган тэмдэглэдэг болохыг жишээлэн үзүүлэх	- Ус (далай, нуур, гол мөрөн)-ыг цэнхэр өнгөөр, хуурай газар (нам дор газар, тал газар, өндөр уул)-ыг ногоон, шар, бор, улаан хүрэн гэх мэт өнгөөр ялган тэмдэглэдэг болохыг мэдэж глобус, газрын зурагт зааж тайлбарлах дасгал ажиллана.	- Глобус - Монголын газрын зураг - Дэлхийн газрын зураг - Сурах бичиг
3.5г. Глобус ба газрын зураг дээр дэлхийн тивүүд болон зарим улсуудыг зааж, нэрлэх	- Дэлхийн тивүүд (Африк, Австрали, Америк)-ийг ялгаж, нэрлэн газрын зураг ба глобус дээр заах дасгал ажиллана. - Газрын зурагт Монгол орноос баруун ба зүүн, хойд, өмнө зүгт орших улсуудыг зааж нэрлэнэ. (Жишээ нь: Хятад улс өмнө зүгт, Орос улс хойд зүгт, Япон, Солонгос зүүн зүгт оршино гэх мэт) ***Багшийн анхаарах зүйл:*** - *Зүг чигийн тухай өмнө эзэмшсэн чадварыг хөгжүүлэхийн тулд газрын зураг дээр баруун, зүүн, хойд, өмнө зүгийг ялгах дөрвөн зүгийн зургийг байрлуулсан байна.* - *Зэргэлдээ улс, сум, баг, хот айл (хөдөөд) юмуу орон сууц (хотод) зэргийг тодорхойлох дасгал ажиллуулж болно.*	- Глобус - Монголын газрын зураг - Дэлхийн газрын зураг - Сурах бичиг

3.5д. Дэлхийн хүмүүсийн амьдрал, арьс өнгө ялгаатай байдгийг таньж тодорхойлох	- Тохиолдол, зураг ашиглан хар, шар, цагаан арьстан хүүхдүүд аль тив, ямар улсын иргэн болохыг тодорхойлох дасгал ажиллана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Хар, шар, цагаан арьстныг амьдардаг улс орон ба тивээр нь ялган тодорхойлно. Ингэхдээ:* o *Нэрд гарсан тамирчин, дуучин, жүжигчин зэрэг хүмүүсийн талаарх мэдээллийг ашиглаж болно.* o *Ямар хүмүүсийг хүүхдүүд сайн мэдэж байгааг урьдчилан тандах ба тэр хүмүүсийн талаарх мэдээллийг интернэт болон бусад сонин, сэтгүүлээс авч сургалтад хэрэглэж болно. (алдартай дуучин, кино жүжигчин гэх мэт) алдартай хүмүүсийн жишээн дээр ярилцах*	- Глобус - Хар шар, цагаан арьстай хүмүүсийн зураг (сэтгүүлийн хайчилбар), нэрд гарсан хүмүүсийн талаарх мэдээлэл - Сурах бичиг

ХҮН БА БАЙГАЛЬ

IV-V анги

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Энэхүү суралцахуйн удирдамжид сургалтын хөтөлбөрийн агуулгыг суралцахуйн зорилтоор тодорхойлж, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх сурагчдын сурах үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэглэгдэхүүнийг санал болгосон.

4.1. АМЬДРАЛ

Өсөлт хөдөлгөөн
Энэ бүлэгт хүн ба амьтны хөдөлгөөний мөн чанар, араг яс, мах булчингийн үүрэг, булчингийн ажиллах зарчмын талаар ойлголттой болно.

Бүлгийн нэр томьёо: Араг яс, гавлын, их бие, мөчдийн яс, сарвуу, үе, тулгуур хөдөлгөөний эрхтэн, булчин, шөрмөс, булчин агших, сулрах.

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.1а. Хүний биеийн араг ясны толгой, их бие, мөчдийн хэсгүүдийг зургаас ялган таних, үүргийг жишээгээр тайлбарлах	- Хүний араг ясны хэсгүүдийг харуулсан загвар, зураг дээр ажиллаж араг ясны хэсгүүдийг ялгаж, нэрлүүлэх боломжтой. Эсвэл бичлэг үзүүлж болох юм. Хүний биеийн хэлхээ араг ясыг урдаас болон араас нь харуулсан зураг дээр ажиллуулна. Учир нь дал, сээр, нуруу, бүсэлхий, ахар сүүлний хэсгүүд нь араас харуулсан зургаас сайн харагдана. - Араг ясны хэсэг бүрийн хэлбэр, хэмжээг харьцуулах, хэсэг бүр өөр өөр хэлбэр хэмжээтэй болохыг судлах даалгавар өгч болно. Тэдгээр хэсэг бүр өөр хоорондоо хэрхэн холбогддог тухай хэлэлцүүлэг өрнүүлээрэй. - Сурагчдаар доорх загварыг холбуулж хэлхээ араг ясыг бүтээлгэж болох юм.	Араг ясны зурагт үзүүлэн, макет Туршилтын хэрэглэгдэхүүн: савх, баримлын шавар, скоч, гялгар бээлий, үетэй хэсгийг тэмдэглэх цавуутай цаас Араг ясны үүргийг харуулсан бичлэг

	- Араг яс нь үетэй хэсгээрээ хөдөлдөг болохыг гарын хуруун дээр туршина. Араг ясны үүргийг хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж, жишээ гаргана. - Араг яс, булчинг хамтад нь тулгуур, хөдөлгөөний эрхтэн болохыг баримлын шавар, саваа мод зэрэг гарын доорх материал ашиглан судална. - Хэрэв цаг байвал хүн ба адууны араг ясны үндсэн хэсгүүдийг харьцуулж төсөөтэй ба ялгаатай талуудыг ярилцах боломжтой. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчдаар араг яс нь, тулгуурын үүрэг гүйцэтгэхээс гадна дотоод эрхтэнүүдийг хамгаалах, мөн үетэй хэсгээрээ хөдөлгөөний үүрэг гүйцэтгэж байгааг жишээгээр тайлбарлуулахад анхааараай. Сурагчийн гаргаж буй жишээ, араг ясны хэсгүүдийг ялган таньж буй байдал, зураг дээр араг ясны үетэй хэсгүүдийг зөв тэмдэглэж, тайлбарыг оновчтой бичиж байгаагаар нь үнэлж болох юм.* ***Тайлбар:*** - *Хүний өсөлт, хөгжилтөд нөлөөлөх хүчин зүйлс болон буруу зуршлын (бөгтийж явах, цүнхээ нэг мөрөнд үүрэх, буруу суух гэх мэт) тухай агуулгыг 3-5 дугаар ангийн эрүүл мэндийн хичээлээр (3-р ангийн эрүүл мэндийн хичээлийн "Хувийн ариун цэвэр, эрүүл ахуй, өсөлт хөгжил" сэдвийн "Биеийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйл" суралцахуйн зорилт, 4, 5-р ангийн "Хооллолт ба хөдөлгөөн" бүлэг сэдвүүдэд хамаарна) үзнэ. Тиймд багш та хичээл хоорондын уялдааг хангаж хичээлээ төлөвлөөрэй.*	
4.1б. Булчингийн агшилт, сулралтын зарчмыг бугалганы хос булчингийн загвар дээр тайлбарлах	- Бугалганыхаа хос булчинг барьж тэмтэрч бугалганы өмнөх болон арын булчинг зураг дээр заан нэрлэнэ.  - Бугалганы хос булчингийн ажиллах зарчмыг судлахын тулд сурагчдыг хосоор ажиллуулж болох юм. Нэг сурагч гартаа 1кг орчим ачаа өргөж буулгана. 2-р сурагч 1-р сурагчийн бугалганы хос булчинг 2 гараараа зэрэг барьж (баруун гарын алгаараа бугалганы өмнөх булчин, зүүн гарын алгаар бугалганы арын булчинг мэдрэх) ямар өөрчлөлт мэдрэгдэж байгааг хэлэх. Энэ үйл ажиллагааг 2 сурагч ээлжлэн гүйцэтгэснээр булчингийн ажиллах зарчмыг хамтран тайлбарлаж болно.	Хүний биеийн булчингийн зураг, бугалганы булчингийн зурагт үзүүлэн Сурах бичиг

Сурагчийн хариултыг багш самбарт бичиж чиглүүлнэ. Тодруулбал*: Самбарт бичих санаа*

Туршилтын загвар зураг-1 *Гараа тохтойгоороо дээш өргөж буй*	Туршилтын загвар зураг-2 *Гараа буулгасан*

Сурагчийн хариулт

-	-
-	-
-	-

↓ **Агших** ↓ **Сулрах**

- Самбарын бичиглэлээс сурагчдын ахуйн үг хэллэг шинжлэх ухааны үг хэллэгээр солигдох учиртай.
- Бугалганы булчингийн ажиллах зарчмыг харуулсан зургийг тайлбарлах. Тайлбарлахдаа булчин агших, сулрах гэсэн үг ашиглаж байгаа эсэхэд багш анхаарлаа хандуулна.
- Мөн сурагч зургаас юуг ажиглах вэ гэдгийг багш чиглүүлж өгөөрэй. Тухайлбал, бугалганы ясанд бэхлэгдсэн хос булчин нь агшиж, сулрахад гараа тохойгоороо нугалж тэнийлгэж байна. Энэ үед ямар өөрчлөлт гарсан бэ гэх мэт. Агшилт, сулралтын ялгааг харьцуулна.

Багшийн анхаарах зүйл:
Сурагчийн дэвтэр, самбар хоёрын бичиглэл ижил байхад багш анхаарна уу. Сурагчдын хийсэн туршилтыг загвар зургаар илэрхийлэх, тэрхүү зураг нь сурагчийн дэвтэрт мөн адил буух. Энэ нь хүүхэд хичээлээ эргэн санахад дэмжлэг үзүүлэх юм.

- Хос булчингийн агшилт, сулралтаар араг яс хөдөлгөөнд ордог болохыг загварчлан туршина.

Туршилтын санаа:
Бугалга болон шууны ясыг 10 см урттай 2 см өргөнтэй хатуу цаасаар орлуулах ба 2 ясны холбогдож буй хэсэгт цаас цоологчоор нүх гаргаж холбох. Булчинг шааараар (нэхмэлийн утсаар) орлуулж бугалга, шууны ясанд бэхлэх. Загвараа багш урьдчилан туршиж хичээлд ашиглах. Туршилтын загварыг хийхдээ булчин нь бугалга шууны ясны хаана нь хэрхэн холбогдсоныг зургаас сайтар ажиглуулах хэрэгтэй. Ажиглах хэсгийг зурагт өнгөөр (дүрсээр) ялган үзүүлэв.

4.1в. Булчин араг ясанд бэхлэгддэг, булчин, араг яс, үе холбоос нь хөдөлгөөнд оролцдог болохыг илрүүлэх	 - Бүтээсэн загварын ажиллаж буй зарчмыг 4.1б дүгээр суралцахуйн зорилтын туршилттай холбоно. Бүтээсэн загвар дээр булчин, араг яс, үе холбоос нь хөдөлгөөнд оролцож байгааг хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчдын бүтээх загварын бэлдэцийг багш урьдчилан бэлтгэвэл цаг хэмнэх боломжтой.* Энэхүү суралцахуйн зорилтын хэрэгжилтээр 4.2б суралцахуйн зорилтын хүрээнд судалсан зүр дүнгээрээ загвар бүтээж буй бололвч нөгөө талаас булчин араг ясанд юугаар хэрхэн, хаана бэхлэгдэж буйг олж харах учиртай тул зургийг ажиглуулахдаа багш дээрх асуудалд анхаарлаа хандуулж асуултаа төлөвлөөрэй.	Туршилтын хэрэглэгдэхүүн: Хатуу цаас, шаар, нэхмэлийн утас, цавуу, хайч (Бугалганы булчингийн ажиллах зарчмыг үзүүлсэн загвар) Сурах бичиг

Амьд бие ба амьдралын орчин

Энэ бүлэгт сурагчид амьд бие бүхэн өөрийн амьдрах орчинд зохицсон байдаг, нэг орчинд хамт оршин амьдрагч амьтан, ургамал идэш тэжээлээрээ харилцан холбоотой байдгийг ухаарч ойлгох, хүний зүгээс хүрээлэн буй орчинд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг тодорхойлох зэрэг чадвартай болно.

Бүлгийн нэр томьёо: Амьдралын орчин, орчны хүчин зүйлүүд, дасан зохицол, идэш тэжээлийн хэлхээ, байгаль орчин, хог хаягдал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
	- Өгсөн амьтан, ургамлын амьдрах орчны нөхцөлүүдийг нэрлэнэ. Жишээлбэл, гэрэл, дулаан, агаар, ус, чийг Дээрх амьтан, ургамлын амьдрах орчиндоо зохицсон онцлог шинжүүдийг ажиглана. Жишээлбэл, загасны амьдрах орчиндоо зохилдсон шинжийг ажиглуулахын тулд гарын доорх материалаар жижиг аквариум бэлтгэн загасаа хийж өнгө, хөдөлгөөн, хооллох үйл ажиллагааг ажиглуулж болох юм. Мөн зурагт хуудас, бичлэг ажиглуулж болно. - Нэмэлтээр амьд бие сонгож, амьдрах орчиндоо зохицсон онцлог шинжүүдийг нь харьцуулан ижил шинжээр нь бүлэглэнэ. Энэ нь дараагийн суралцахуйн зорилтыг судлах холбоос болно.	- Төрөл бүрийн орчин дахь амьтдын амьдралын тухай зураг, бичлэг - Төрөл бүрийн амьтан, ургамлын зурмал ба фото зургаар бэлтгэсэн гар карт - Гарын доорх материал

4.1г. Зарим амьтан, ургамлын онцлог шинж нь амьдрах орчиндоо зохилдсон болохыг илрүүлэх	***Аквариум хийх хэрэглэгдэхүүн, аргачлал:*** *CD-ий хатуу пластик хайрцаг, 4ш бичгийн хавчаар, 1 см диаметр бүхий 40 см урттай уян хоолой. CD-ий хайрцгийг салгаж гадна талаар нь дотогш харуулж хооронд нь уян хоолойг байрлуулна (3 талд). 2 талаас нь бичгийн хавчаараар (доод талд 2ш, хоёр хажуу талд нэг нэг хавчаар) хавчина.* *Мөн амьтдын өнгө зүс, шувууны хөлийн сарвуу зэрэг шинж тэмдгээр тухайн амьтны амьдрах орчныг таамаглуулах, зургийг оноон байрлуулах, харьцуулсан хүснэгт зуруулах зэргээр бүтээлч ажлуудыг сонгон хэрэглэж сурагчдаа үнэлээрэй.* ***Багшийн анхаарах зүйл:*** *Ус, түүний ойр орчим, хээр, ой, говь гэх мэт амьдралын орчинд амьдардаг амьтдаас сонгоно.* *Хүүхдийн ойр орчимд байдаг, өөрийн орон нутгийн амьтан, ургамлын жишээн дээр судлуулахыг хичээгээрэй.*	- Сурах бичиг
4.1д. Тухайн орчин дахь амьд биес идэш тэжээлээрээ холбогддог болохыг тайлбарлах	- 4.1г-д судалсан нэг орчинд амьдардаг амьтан ургамлын хоол, хооллох аргын талаар судлах - Тухайн амьдралын орчин дахь амьд биеийн хоол тэжээлийн хэлхээг зурган картаар бүтээх, эсвэл зурах - Багшийн өгсөн, эсвэл өөрсдийн бүтээсэн идэш тэжээлийн хэлхээг үгээр илэрхийлэх, тайлбар бичих - Идэш тэжээлээрээ холбогдож буй амьтдын аль нэг бүлэг нь үгүй болбол тухайн хэлхээнд ямар асуудал үүсэхийг тодруулан хэлэлцэж болох юм. Үүнээс тухайн орчин дахь амьд биес бие биеэсээ хамааралтай болохыг эргэцүүлэх боломжтой. ***Багшийн анхаарах зүйл:*** *Идэш тэжээлийн хэлхээг орохдоо бүтээгч, задлагч, хэрэглэгчийн тухай дурдахгүй болохыг (суурь боловсролын 6-р ангид үзнэ) анхаарна уу. Харин өвсөн, махан идэштэн гэх мэт үг хэллэгийн хэрэглэж болно.*	- Хөдөлгөөнт үзүүлэн, эвлүүлдэг карт, бичлэг - Янз бүрийн орчин дахь амьд биеийн идэш тэжээлийн хэлхээний зураг - Сурах бичиг
4.1е. Хүрээлэн буй орчинд нөлөөлж буй хүний үйл ажиллагаанаас жишээлэн тайлбарлах	- Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хүрээлэн буй орчинд үзүүлэх хор хохирлын талаар мэдээлэл цуглуулах боломжтой. Жишээлбэл, агаар, ус, хөрс, хоол хүнсний бохирдол гэх мэт. - Өөрсдийн амьдарч буй орчны (гэр, байр, сургуулийн орчин, сургуулийн нийтийн эзэмшлийн талбай гэх мэт) бохирдлын талаарх холбогдох хүмүүсээс ярилцлага авч баримт, материал цуглуулж, хэлэлцэнэ. - Хүрээлэн буй орчноо хамгаалах арга замуудыг дэвшүүлж, хэлэлцэнэ. Орчиндоо эерэгээр нөлөөлөх арга хэмжээ төлөвлөн зохион байгуулж болно. Мөн орон нутаг, сургууль орчмын хог хаягдал, түүнийг багасгах арга замуудын (хог хаягдлыг багасгахын тулд өөрийн оруулах хувь нэмэрийг гаргах, хог хаях аргыг хэлэлцэх) талаар санал, санаачлага гаргах, зурагт хуудас, шаардах хуудас, уриалга, ханын сонин гаргах зэргээр нийтэд сурталчилгаа хийх боломжтой.	- Хүрээлэн буй орчноо бохирдуулж буй гэрэл зураг, бичлэг - Хог хаягдлыг багасгах арга замуудыг харуулсан зурагт хуудас - Хүүхдийн бүтээлүүд - Амьдрах орчинд үзүүлж буй хүний үйл ажиллагааны бодит кейс - Сурах бичиг

	Багшийн анхаарах зүйл: *Амьтан бүхэн өөрийн амьдрах орчиндоо дасан зохицсон байхын дээр тухайн орчинд хамт амьдрагч бусад амьтан, ургамалтай нарийн холбоо хамааралтай байдаг. Харин хүний шууд ба шууд бус нөлөөний улмаас байгалийн тэнцвэрт байдал алдагдан дээрх холбоонд асуудал үүсч хохирол учирдаг болохыг ойлгуулахад сургалтын гол үйл ажиллагаа чиглэнэ.*	

4.2. ЮМС ҮЗЭГДЭЛ

Гэрлийн шинж чанар

Энэ бүлэгт сурагчид гэрлийн шинж чанартай холбоотой туршилтуудыг шинжлэх ухааны арга барилаар гүйцэтгэнэ.

Бүлгийн нэр томьёо: Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц, сүүдэр, гэрэл тархах, толь, ойлт, гэрлийн цацраг

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2а. Гэрэл үүсгэгч ашиглаж биеийн сүүдэр үүсгэх нөхцөлийг тодорхойлох	- Гэрэл ямар биеэр нэвтэрч, ямар биеэр нэвтэрч чадахгүйг таамаглана. - Дэвшүүлсэн таамаглалаа шалгах төлөвлөгөө зохиож, туршилт хийх биетээ сонгоно. - Гэрэл биеийг нэвтэрч гарч байгаа эсэхийг хэрхэн илрүүлэх талаар хэлэлцэнэ. - Тунгалаг биш биет гэрэл нэвтрүүлэхгүйг, тунгалаг биет ихэнх гэрлийг нэвтрүүлж байгааг ажиглаж, тэмдэглэл хөтөлнө. - Тунгалаг биш бие тод сүүдэр үүсгэж байгааг ажиглана. - Сүүдэр үүсгэхэд гэрэл үүсгэгч, тунгалаг биш бие, дэлгэц хэрэгтэйг тодорхойлж, биеийн болон сүүдрийн хэлбэрийг холбон тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Гэрэл биеийг нэвтэрч байгаа эсэхийг илрүүлэх үед сүүдрийн тухай ярилцах боломжтой. Сүүдрийн хэлбэр биетийн хэлбэрээс хамаарч байгааг туршуулж, суралцагчид хэрхэн тайлбарлаж байгаагаар нь үнэлж болно.*	Гэрэл үүсгэгч, тунгалаг (нимгэн шил, хүнсний скоч, скоч гэх мэт) болон тунгалаг биш биетүүд Ажиглалтын хуудас Дугуй, дөрвөлжин, гурвалжин хавтгай биет Сурах бичиг
4.2б. Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хамаардаг болохыг тайлбарлах	- Сонирхолтой үзүүлбэрийг суралцагчидтай хамтран хийж, сүүдрийн хэлбэр, хэмжээ нь ямар үед ихсэж багасахыг таамаглана. - Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хэрхэн хамаарахыг судлах ажиглалт, туршилтын алхмуудыг хамтран төлөвлөнө. - Ажиглалт туршилтын явц, үр дүнг тэмдэглэх хуудсыг хамтран боловсруулна. - Төлөвлөсний дагуу туршилтаа гүйцэтгэж, ажиглана. - Ажиглалт туршилтын үр дүнг баганан диаграммаар илэрхийлж болно. - Гэрэл үүсгэгч, бие, дэлгэц гурвын харилцан байрлалаас сүүдрийн хэмжээ хамаардаг болохыг туршилтын үр дүнгээс жишээ гарган тайлбарлана.	Гэрэл үүсгэгч, бие, сүүдрийн хэмжээг хэмжих хуваарьтай цаас, дэлгэц, шугам

	Багшийн анхаарах зүйл: *Туршилтын явцад гэрэл үүсгэгч ба дэлгэцийн хоорондох зайг тогтмол байлгаж, биеийг холдуулж ойртуулах; дэлгэц ба биеийн байрлалыг өөрчлөхгүйгээр гэрэл үүсгэгчийг холдуулж ойртуулах байдлаар сүүдрийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлуулахад үйл ажиллагааг чиглүүлэх нь зүйтэй.* *Ажиглалт, туршилтын үр дүнг илэрхийлсэн диаграммын алдаа (ялгаатай байдал)-г сайжруулах, алдаагаа өөрсдөө олж харах, засах боломж олгоорой.* *Багш туршилтын хэрэглэгдэхүүнүүдийг урьдчилан бэлтгэсэн байна.* *Дүрс тод байхын тулд чийдэн аль болох жижиг байх шаардлагатайг анхааараарай.*	
4.2в. Гэрлийн цацраг шулуун тархдаг чанарыг ашиглан дүрс байгуулах	- Гэрлийн цацраг гаргах аргуудыг нэрлэж, тайлбарлана. - Нүхтэй хайрцаг дотор чийдэн суурилуулж хайрцгаас гарах гэрлийн цацрагийг ажиглана. - Лазерын туяагаар цацрагийг үзүүлж, сумаар гэрэл тархах чиглэлийг дүрсэлнэ. - Цацрагийн тухай ойлголтоо ашиглаад хавтгай биеийн дүрс дэлгэцэд хэрхэн дүрслэгдэхийг ажиглаж хэлэлцэнэ. Уг санаагаа ашиглаж биеийн дүрс хэрхэн дүрслэгдэхийг зурна. ***Багшийн анхаарах зүйл:*** *Цацрагийн тухай ойлголтыг бэлэн өгөхгүйгээр гэрлийн замд утаа, усны уур, сарниулагч шингэн орчин үүсгэж гэрэл шулуун замаар тархдаг болохыг ажиглуулна.* *Үүний дараа цацрагийн тухай санааг хэлэлцэнэ. Гэрэл үүсгэгч ба биеийн захын цэгийг дайруулан цацраг татаж дүрс байгуулах аргад сургана.*	Нүхтэй хайрцаг, чийдэн, ус цацдаг сав, утаа гаргах хүж, лазерын гэрэл
4.2г. Гэрлийг ойлгодог, ойлгодоггүй материалыг ялган таних	- Гэрэл ямар биеэс сайн ойж, ямар биеэс бага ойж байгаа талаар таамаглал дэвшүүлнэ. - Дэвшүүлсэн таамаглалаа шалгах төлөвлөгөө зохиож, туршилтад хэрэглэх биетээ сонгоно. - Барзгар болон толин гадаргатай бие дээр гэрэл тусгаж ойлтыг харьцуулан ажиглуулах боломжтой. - Материалыг гэрэл ойлгодог, ойлгодоггүйгээр нь ялгаж, тайлбарлуулна. - Хар өнгийн бие гэрэл хамгийн бага ойлгож, их шингээдэг болохыг ялган танина. - Хар бие гялгар биеэс гэрэл шингээсний улмаас илүү халдаг болохыг туршиж, энэ шинж чанарыг юунд ашиглаж болох талаар хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Хар ба цагаан цаасыг цонхны гэрэлд тавьж температурыг термометрээр хэмжүүлэх боломжтой.* *Туршилтыг хийлгэхдээ биеийн хэмжээ, наранд байлгах хугацаа, тусгалын өнцөг зэрэг нөхцөлийг адилхан байлгаж, зөвхөн өнгө нь ялгаатай байлгахад анхааараарай.*	Төрөл бүрийн гадарга бүхий бие, хар ба цагаан бие, гэрэл үүсгэгч, термометр

4.2д. Хавтгай толиноос ойсон тусгалын хэлбэрийг толины хэлбэртэй холбож тайлбарлах	- Толиноос ойсон тусгалын хэлбэрийг ажиглана. - Толиноос ойсон гэрлийн тусгалын хэлбэрийг толины хэлбэртэй холбоотой эсэх талаар таамаглал дэвшүүлэх боломжтой. - Толины өмнө янз бүрийн хэлбэр бүхий нүхтэй цаас тавьж толины хэлбэрийг өөрчлөх замаар тусгалын хэлбэрийг өөрчилнө. - Өмнө нь судалсан сүүдэр үүсгэх аргатай харьцуулан ижил ба ялгаатай талыг хэлэлцэнэ. - Хавтгай толиноос ойсон тусгалын хэлбэрийг толины хэлбэртэй холбож тайлбарлуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** *Толиноос ойсон тусгал болон гэрлийг нүд рүүгээ тусгахгүй байхыг анхааруулж, аюулгүй ажиллагааны талаар ярилцах хэрэгтэй.* *Сүүдэр гэдэг нь гэрэлтэй харанхуйн зааг учир гурвалжин тунгалаг биш биеийн сүүдэр, гурвалжин нүхний үүсгэх гэрэлт толбо хоёр зарчмын ялгаа байхгүй, нэг зүйлийн хоёр тал гэдгийг анхааараарай.*	Янз бүрийн хэлбэртэй дүрс үүсгэн хайчилсан цаас, хавтгай толь, дэлгэц, гэрэл үүсгэгч (гар чийдэн) Сурах бичиг дэх туршилт даалгавраас санаа авах
4.2е. Толь ашиглаж гэрлийг хуримтлуулж болохыг тодорхойлох	- Зөвхөн толь ашиглаж гэрлийг хэрхэн хуримтлуулах вэ, улам тод гэрэл хэрхэн үүсгэх вэ гэсэн асуудал дэвшүүлнэ. - Гэрлийн цацраг хуримтлуулах багаж хийх санааг хэлэлцэнэ. - Багаж ашиглан гэрлийн тусгалын цэгийн температурыг гараар нь мэдрүүлнэ. - Термометр ашиглан температурын ихсэлтийг тоогоор харуулна. - Цааш гүнзгийрүүлэн хэд хэдэн толь ашиглан гэрлийн тусгалыг давхцуулан толины тооноос температурын өөрчлөлтийг хамааруулан судлуулах боломжтой. - Гэрлийг хуримтлуулж болох эсэх талаар дүгнүүлж, юунд ашиглаж болох талаар хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Аюулгүй байдлыг хангах зорилгоор туршилтад хэрэглэж байгаа толины ирмэгийг скочоор нааж хүрээлсэн байх шаардлагатай.* - *Термометрийн хуваарь унших, аюулгүй ажиллагааны заавар тайлбарлаж өгөх, термометрийн заалтыг унших дадлага ажил хийлгэсний дараа туршилтын үйл ажиллагаанд шилжих хэрэгтэй.* - *Толио хөдөлгөөнгүй байрлуулах, чиглэлийг нь удирдах хэрэгсэл урьдчилан бэлтгэсэн байна.* - *Толийг гялгар хөнгөнцагаан цаасаар орлуулан туршилтад хэрэглэж болно.*	Хөнгөнцагаан цаас, хатуу цаас, термометр, толь - Сурах бичиг
4.2ж. Ойсон гэрлийн тусламжтай биеийг хардаг болохыг зурж харуулах	- Хүн хэрхэн хардаг талаар асуудал дэвшүүлж, таамаглуулна. - Нүднээс гэрэл гарч хараад байна уу, биеэс ойсон, гарсан гэрлийг нүд мэдрээд байна уу гэдгийг ялгах туршилтын санаа гаргана. - Хүний харах үйл явцыг гэрэл үүсгэгч эсвэл ойлгогч, гэрлийн цацраг, гэрэл хүлээн авагч (нүд) гэсэн гурвалаар холбон зуруулж болно.	Гэрэл үүсгэгч, биет, харандаа

	Багшийн анхаарах зүйл: *Судалгаанаас үзэхэд бага насны хүүхэд нүднээс гэрэл гардаг, нүдээ анихдаа өөрийгөө бусдад харагдахгүй болно, гэрэл унтраахад эргэн тойрны юмс аймшигтай зүйлс болж хувирна гэсэн ойлголттой байх нь элбэг. Иймд үүнийг зөв талаас нь ухааруулах, мэдрүүлэх нь чухал.* 	

Соронзон

Энэ бүлэгт сурагчид соронзонд ямар материал татагдах, татагдахгүйг, соронзон хоорондын таталцах, түлхэлцэх харилцан үйлчлэл, соронзон биш биеийг соронзон шинжтэй болгох туршилтуудыг гүйцэтгэх замаар шинжлэх ухааны арга барилд суралцана.

Бүлгийн нэр томьёо: Хүч, соронзон, түлхэлцэл, таталцал, шулуун соронзон тах, соронзон зүү, материал, металл

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2з. Соронзон ашиглах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг тайлбарлах	- Ахуйд соронзон хэрэглэдэг жишээ гаргаж, тайлбарлана. - Соронзонтой ажиллах, түүнийг хадгалах, хамгаалах талаар хэлэлцэнэ. - Соронзонг ижил туйлаар нь (улааныг улаантай, хөхийг хөхтэй) давхарлаж хадгалбал соронзон чанар нь сулардаг болохыг туршиж, тайлбарлуулах боломжтой. - Соронзон ашиглах үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг гаргана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Соронзонг гар утас, компьютер, мэдрэмтгий самбар, телевизор зэрэг электрон хэрэгсэлд хүргэхгүй байх, хүчтэй соронзон цахим хэрэглэгдэхүүний үйлдлийн системийг гэмтээх аюултай байдгийг, товчин соронзонг залгиж болзошгүй учир амандаа хийж болохгүй, соронзонтой ажиллахад зарим хүүхдийн толгой эргэж, дотор муурхайрч болзошгүйг, мөн эрхтэндээ ган суулгацтай хүүхэд соронзонтой ажиллаж болохгүйг анхааруулах шаардлагатай. Иймд туршилтын дараа соронзон бүрэн байгаа эсэхийг заавал тоолж тэмдэглэл хөтлүүлнэ.*	Аюулгүй байдлын зурагт танилцуулга Сурах бичгийн анхаарулга

№	Хүлээн авсан зүйл	Хүлээлгэн өгсөн эсэх
1		
2		
3		

4.2и. Соронзонд татагддаг, татагддаггүй материалыг таньж тодорхойлох	- Соронзонд татагддаг, татагддаггүй материалыг илрүүлэх туршилтын санаа гаргуулж, хэлэлцэх боломжтой. - Таамаглал дэвшүүлнэ (ийм бие/материал татагдана, татагдахгүй учир нь ...). - Соронзонд татагддаг, татагддаггүй бие/материалыг ялгаж, таамаглал зөв эсэхийг туршилтаар шалгана. - Соронзонд татагддаг, татагддаггүй бие/материалыг харьцуулан судалж, бие нь чухал биш, биеийг хийсэн материал чухал болохыг ялгана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Баг тус бүрт янз бүрийн материалаар хийсэн сонирхолтой биет ба соронзон бүхий сагс өгнө. Дэвтэрт бие/материал, таамаглал (татагдах/татагдахгүй), ажиглалтын үр дүн (татагдсан, татагдаагүй, түлхэгдсэн) гэсэн гурван хэсэгтэй хүснэгт хийнэ. Эхний хоёр баганыг бөглөнө. Туршилтын үр дүнг 3-р баганад бичнэ. Дараа нь дүгнэнэ. Бодисын дотоод бүтэцтэй холбож тайлбарлах хэрэггүй. Соронзонд татагддаг, татагддаггүйг нь макро түвшинд ангилж ялгахад л хангалттай.* ***Хэрэглэгдэхүүний санаа:*** *Хичээлээ сонирхолтой болгохын тулд соронзон ашиглаж төрөл бүрийн хэрэглэгдэхүүн бүтээж болох юм. Тухайлбал хөөсөнцөр болон гялгар цаасаар төрөл бүрийн загас хийж соронзон болон соронзонд татагддаг, татагддаггүй материалыг бэхлэх, загасны уургын үзүүрт соронзон уяна. Хэрэглэгдэхүүнийг ашиглан загасчлах тоглоом тоглох явцад соронзонд татагддаг, татагддаггүй материалыг ялгуулах боломжтой.*	Янз бүрийн металлуудын бэлдэц, түүгээр хийсэн биет Сурах бичиг
4.2к. Соронзны үйлчлэлийг татах, түлхэх хүчид үндэслэн тайлбарлах	- Төрөл бүрийн соронзны харилцан үйлчлэлийг ажиглана. - Соронзонгууд хоорондоо таталцдаг, түлхэлцдэг гэдгийг туршилтаар илрүүлнэ. Энэ туршилтад махчин амьтдын загвар хийж дээд, доод эрүүний дотор талд 2 соронзонг ижил туйлаар нь харуулан тогтоон (ам нь ангайсан байдалд байна) хэрэглэж болно. Харин идэш болох амьтны аль нэг газар нь эсрэг туйлтай соронзон, соронзонд татагддаг материал (бичгийн хавчаар гэх мэт) байрлуулах, харин идэш болохгүй амьд биеийн аль нэг хэсэгт ижил туйлтай соронз байрлуулах зэргээр амьтдын идэшээ олж идэх тоглоомыг тоглох замаар соронзон үйлчлэлийг судлуулж болох юм. - Соронзны татах, түлхэх үйлчлэлийг зургаар илэрхийлж, тайлбарлана.	Төрөл бүрийн соронзны цуглуулга (шулуун соронзон, тах хэлбэрийн соронзон, нүхтэй соронзон, дугуй соронзон) Сурах бичиг дэх дасгал даалгавруудыг хичээлд ашиглах

4.2л. Соронзны татах, түлхэх үйлчлэлийг туйлтай холбон зурж үзүүлэх	Дараах ажиглах туршилтыг сурагчдаар гүйцэтгүүлж болно. - Шулуун соронзонг асгасан бичгийн хавчаарт хүргэж соронзны хаана нь олон хавчаар татагдаж байгааг ажиглана. - Шулуун соронзонг босоо тэнхлэг тойрон эргэх боломжтой байдлаар утаснаас зүүх, хөвүүлэх замаар хаашаа харж зогсохыг ажиглана. Энэ санаанд түшиглэж луужинг бүтээсэн гэдгийг хэлнэ. Луужинг хэвтээ чиглэлд, янз бүрийн газарт байрлуулж, зөвхөн нэг зүгт зааж байгааг ажиглалтаар тогтоох. Эндээс соронзны туйлын талаарх асуудал дэвшүүлж болно. - Хоёр “туйл”–ыг тэмдэглэсэн шулуун соронзонд өөр өнгөгүй, тэмдэггүй соронзонг ойртуулж таталцаж, түлхэлцэж байгаа хэсгийг ажиглаж туйлын тухай, туйлуудын үйлчлэлийн талаар таамаглал дэвшүүлүүлнэ. - Таамаглалаа шалгах туршилт төлөвлүүлнэ. - Туйлын тэмдэглэгээтэй соронзонг ашиглаж туйлын тэмдэглэгээгүй соронзны туйлын (улаан, хөх өнгийн цаас нааж) тэмдэглэгээ хийлгэнэ. - Соронзны ямар туйлууд түлхэлцэж, ямар туйлууд таталцаж байгаа талаар хэлэлцэж, дүгнэлт хийлгэнэ. - Туршилтын явцыг ажиглаж соронзны татах, түлхэх хүч ямар зайд үйлчилж байгааг тэмдэглэж, үр дүнг зурж үзүүлнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Соронзон өмнөд хойд туйлтай, батарей эерэг сөрөг туйлтай. Үүнийг хүүхэд андуурч хольдог. Соронзны нэмэх хасах туйл, батарейн хойд өмнөд туйл гэж ярих нь элбэг. Соронзон үйлчлэл зарим зүйлийг нэвтэлдэг болохыг туршилтын явцад ажиглана (Цаасны 2 талаас харилцан үйлчлүүлэх гэх мэт).*	- Туйлын тэмдэглэгээгүй соронз - Туйлын тэмдэглэгээтэй соронзон -Соронзонд татагддаг материалаар хийгдсэн эд юмс -Төмөр бичгийн хавчаар -Ажлын хуудас  Сурах бичиг
4.2м. Төмөр (бичгийн хавчаар)-ийг соронзон чанартай болохыг соронзон ашиглаж тодорхойлох	- Соронзон биш биеийг соронзон шинжтэй болгох туршилтын санаа гаргуулж, төлөвлүүлэх боломжтой. - Туршилтыг гүйцэтгэх, үр дүнг хэлэлцэх, зургаар илэрхийлэх үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно. - Төмөр бичгийн хавчаарыг соронзон чанартай болохыг туршилтын үр дүнд үндэслэн тодорхойлно. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Соронзонд татагдсан бичгийн хавчаар өөр хавчаарыг татах чадвартай болж байгааг ажиглуулна. Соронзон чанартай болсон эсэхийг өмнөх мэдлэгээ ашиглан туршилтыг давтан хийж шалгуулж болно.* - *Соронзон бидний ахуй амьдралд хэрхэн хэрэглэгддэг талаар ярилцахуулахад анхаараарай.* - *Таамаглал дэвшүүлэх, туршилт төлөвлөх, туршилт гүйцэтгэж буй байдал, үр дүнг бичиж тэмдэглэх, дүгнэж байгаа байдалд ажиглалт хийж сурагчдын ахиц өөрчлөлтийг үнэлээрэй. Мөн энэхүү суралцахуйн зорилтын хэрэгжилтээр сурагчдын багаар ажиллах нягт нямбай байдлыг төлөвшүүлэх боломжтой.*	Соронз, бичгийн хавчаарууд, Сурах бичиг дэх туршилтын даалгавар, дүгнэлтийн хэсгийг ашиглах

Цахилгаан дамжуулагч ба тусгаарлагч

Энэ бүлэгт сурагчид ямар материал цахилгаан дамжуулдаг, тусгаарладаг талаар танин мэднэ.

Бүлгийн нэр томьёо: Цахилгаан хэлхээ, дамжуулагч, тусгаарлагч, цахилгааны утас

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2н. Энгийн цахилгаан хэлхээний элементийн үүрэг зориулалтыг ялган таних, нэрлэх	- Энгийн цахилгаан хэлхээний янз бүрийн холболтын зургийг ажиглаж, аль холболтын чийдэн асахыг ярилцана - Асна гэж үзсэн холболтын зургийг ялгаж, зурагт дүрсэлсэн холболтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ. - Зураг дахь холболтын дагуу туршилтыг гүйцэтгэж, үр дүнг тэмдэглэнэ (ассан эсэх). - Чийдэн ассан цахилгаан хэлхээний дэлгэрэнгүй зургийг зурж шалтгааныг тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Чийдэн асах, асахгүй хэлхээний зургаас чийдэн асна гэж үзсэн зургийг ялгах, шалтгааныг олох асуулт, нөхцөл өгнө. Богино холболт үүсгэх холболтоос сэргийлэх.* - *Асна гэж үзсэн зургийн дагуу туршилтаа гүйцэтгэхийг сурагчдад анхааруулах. Зурагт дүрслэгдсэнээс өөр чийдэн (гэрлэн диод) хэрэглэх бол нэмэлт тайлбар өгөх, эсвэл зурагт хуудаст туршилтад хэрэглэх чийдэнг зурж бэлтгэх. Энэ нь туршилтыг зааврын дагуу гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх юм. Эсвэл олон төрлийн чийдэнгээс сурагчид зурагт хуудаст дүрслэгдсэн чийдэнг сонгох байдлаар хичээлээ төлөвлөж ч болох юм.* - *Аюулгүй ажиллагааны мэдээлэл өгөх видео үзүүлж болно.*	Энгийн цахилгаан хэлхээний янз бүрийн холболтын зургууд, тараах материал, зай, чийдэн, холбох утас зэргийг хангалттай тоогоор бэлтгэх Сурах бичиг
4.2о. Цахилгаан хэлхээний элементийн тэмдэглэгээг ялган таних, бодит хэрэглэгдэхүүн дээр заах	- Зай ашиглан гэрлэн диодыг асааж, ажиглана. - Энгийн хэлхээний элементийн тэмдэглэгээг ажиглана. - Зайны (+), (-) тэмдэглэгээ, холбогч утас, гэрлэн диодын урт богино шонг ашиглаж, хэлхээний схемийг тайлбарлах, гэрлэн диодын туйлыг сольж залган цахилгаан тодорхой чиглэлд урсдаг болохыг тогтооно. ***Багшийн анхаарах зүйл:*** *Гэрлэн диодыг 100 Ом резистортой цуваа холбож 3В батарейд залгана. Шууд залгавал минутын дараа бүдгэрсээр асахаа болино. Өөрөөр хэлбэл шатна. Хэрэв 3В-оос өөр хүчдэлтэй батарейд гэрлэн диодыг залгах гэж байгаа бол диодоор 20 мА (миллиампер) гүйдэл гүйх үед хэвийн асна, диод дээр ойролцоогоор 2В хүчдэл унана гэж үзээд хэлхээний нэмэлт эсэргүүцлийг тооцоолж олдог.*	Энгийн хэлхээ үүсгэх зай, холбогч утас, гэрлэн диод, чийдэн болон гэрлэн диодын дотоод хэсгийг харуулсан зурагт хуудас (сурах бичиг дэх дүгнэлт хэсгээс санаа авах) Сурах бичиг дэх туршилт, даалгавар

4.2ө. Батарей, чийдэн ашиглан өгсөн материалуудын цахилгаан дамжуулах чадварыг таньж тодорхойлох	- Материалын цахилгаан дамжуулах эсэхийг илрүүлэх багажийн санаа гаргаж, хэлэлцэнэ. - Төрөл бүрийн материалуудын цахилгаан дамжуулах эсэхийг таамаглана. - Туршилтыг хамтран гүйцэтгэх боломжтой. - Материалыг цахилгаан “сайн”, “муу” дамжуулдгаар нь ангилна. - Цахилгаан дамжуулж буй материалын шинж чанарыг тодорхойлох замаар цахилгаан сайн дамжуулдаг чадварыг тодорхойлно. ***Багшийн анхаарах зүйл:*** - *Дэвтэрээ бие/материал, таамаглал (цахилгаан дамжуулах +/дамжуулахгүй -), туршилтын үр дүн +/- хэлбэрийн хүснэгт хийнэ. Ямар тэмдэгт (тийм/үгүй, +/-, 1/0) тавихаа өөрсдөө шийдэх хэрэгтэй.* - *Цахилгаан дамжих замыг зөв тодорхойлох дасгал, сонирхолтой туршилт хийлгэх боломжтой.* - *Цахилгаан сайн болон муу дамжуулдаг материалын талаар видео ашиглан нэмэлт мэдээлэл өгч болно. Сайн муу дамжуулагчийг ангилж ялгахад л хангалттай. Туршилтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэхдээ богино холболтоос сэргийлэх хэрэгтэй.*	Цахилгаан хэлхээ сайн, муу дамжуулдаг материал бүхий зүйлс. Металлын цуглуулга, янз бүрийн металлаар хийсэн биетүүд Сурах бичиг дэх дасгал даалгавар
4.2п. Металл (цахилгааны утас, кабельд), хуванцарын (утас болон залгуур, унтраалгын гэр бүрхүүлд) хэрэглээг нэрлэх	- Ажиллахгүй, ашиглагдахгүй болсон уртасгагч, залгуурыг задалж, ажиглана. - 4.2н-ө суралцахуйн зорилтын хичээлээс олж авсан мэдлэгээ ашиглан металл, хуванцарын хэрэглээг нэрлэж, тайлбарлана. - Амьдрал, ахуйдаа хэрэглэж буй цахилгаан хэрэгслийн онцлог, аюулгүй ажиллагаа, зөв хэрэглээг ярилцана.  - Цахилгааны аюул, аюулаас сэргийлэхийг үзүүлсэн үзүүлэн таниулах материал хийнэ.	Ажиллахгүй болсон уртасгагч, залгуур  Аюултай байж болох цахилгаан хэрэгслийн зураг

Хатуу, шингэн, хий

Шинжлэн судлах арга барилд суралцах замаар хатуу, шингэн, хийн төлөвт орших бодисын ялгаатай шинж (хэлбэр, шахагдах, урсах)-ийг тодорхойлж, тайлбарлаж чаддаг болно.

Бүлгийн нэр томьёо: Бие, материал, бодис, хатуу, шингэн, хий, жижиг хэсэг, урсах, шахагдах, хэлбэр, усанд уусдаг, усанд уусдаггүй

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2р. Түгээмэл тохиолдох хатуу, шингэн, хийг таньж тодорхойлох, нэрлэх, жишээ гаргах	- Бидний эргэн тойронд байгаа зүйлсээс хатуу, шингэн, хийн байдалтай биетийн жишээ гаргана (ангид байгаа зүйлсийг ч ашиглах боломжтой). Мөн хатуу, шингэн, хий байдалтай биет, бодисын зураг дээр ажиллуулж болно. - Байгаль дээрх хатуу, шингэн, хийн жишээ гаргана. Сурагчийн гаргаж буй жишээгээр хатуу шингэн хийг зөв таньж тодорхойлсон эсэхийг үнэлнэ.	Сурах бичиг
4.2с. Хатуу, шингэн, хийн ялгаа (хэлбэр, шахагдах, урсах)-г жижиг хэсгийн байрлал, хоорондын зайтай холбон тайлбарлах	- Хатуу биетийн хэлбэрийг шууд, шингэн биетийн хэлбэрийг туршихдаа усыг янз бүрийн хэлбэртэй саванд юүлэх замаар тодорхойлно. Энэ мэдлэг дээр суурилан хийн хэлбэрийг сурагчид өөрсдөө тодорхойлно. Сурагчдаар таамаглал дэвшүүлбэл илүү үр дүнтэй. - Шингэний урсах шинжийг налуу гадаргуу дээр урсгаж, шингэн ба хийн шахагдах чанарыг тариур ашиглан туршина. Яагаад шингэн, хий нь шахагдаж байна вэ? зэрэг асуулт тавьж, сурагчид шалтгааныг тайлбарлана. - Хатуу, шингэн, хий дэх жижиг хэсгүүдийн байрлалын ялгааг дүрсэлж, тэдгээрийн хоорондын зайтай холбож хэлэлцэнэ. - Хатуу, шингэн, хийн жижиг хэсгүүдийн байрлал, хоорондын зайг гарын доорх материал ашиглан дүрслэх боломжтой. - Хатуу, шингэн, хийн ялгаатай болохын шалтгааныг дүрд тоглох аргаар бататгаж болно. ***Багшийн анхаарах зүйл:*** *Бодис, материал жижиг хэсгээс бүрддэгийг сурагчдад ойлгуулна.* *Хатуу, шингэн, хийн шинж чанар нь жижиг хэсгийн байрлал, тэдгээрийн хоорондын зайнаас хамаарахыг ойлгуулахад нь энэ суралцахуйн зорилтын мөн чанар оршино. Энэхүү суралцахуйн зорилтын гол үнэлгээ нь хатуу, шингэн, хийн ялгааг бодисын жижиг хэсгийн байрлал, хоорондын зайтай холбон тайлбарлаж чадаж байна уу гэдэгт чиглэнэ.*	Жижиг хэсгийг дүрслэх цагираг, бичгийн хавчаар, тариур, налуу тавцан, янз бүрийн хэлбэртэй шилэн сав г.м Сурах бичиг
4.2т. Уусмал дахь бодисын жижиг хэсгийг дүрслэн тайлбарлах	- Давсыг усанд уусгахад гарах өөрчлөлт, ууссан давс нь хаана байгаа талаар ярилцаж, таамаглана. - Таамаглалаа шалгах туршилтыг төлөвлөж, гүйцэтгэнэ. - Давс усан дотор байгаа бол хэрхэн байрлах вэ? гэсэн асуултын хүрээнд туршилтын үр дүнг хэлэлцэнэ. - Савтай уусмал дахь ус ба давсны жижиг хэсгийг хоёр өөр дүрс ашиглан дүрсэлж, уусах үзэгдлийг тайлбарлана. - Эргэлзээтэй зүйл байвал бодитоор туршиж үзнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Хэрвээ сурагч давс нүдэнд харагдахгүй бол алга болсон гэж эргэлзэж байвал давстай болон элсэн* чихэртэй *уусмалын жишээн дээр тайлбарлах боломжтой.*	- Будгийн харандаа, зураг зурах цаас, хатуу бодисын жижиг хэсгийг дүрслэх гарын доорх материал -Сурах бичиг

	Хатуу бодис усанд ууссаны дараа жижиг хэсгүүд хэрхэн байрлахыг зуруулж, зургийг рубрик ашиглан үнэлж болно. *Уусах үзэгдлийг бодисын жижиг хэсгүүд өөр хоорондоо жигд тархан холилдох гэж тодорхойлно. Энэхүү тодорхойлолтыг хүүхэд өөрөө туршилтын үр дүндээ үндэслэн гаргах нь чухал юм. Тиймд багш үүнд гол анхаарлаа хандуулаарай.*  *Сурагчид уусмал дахь жижиг хэсгийг ихэнх тохиолдолд дээрх 6 янзаар илэрхийлдэг. Тиймд багш та сурагчдын ялгаатай үр дүнг самбарт байрлуулж хэлэлцүүлгээ хөтлөөрэй. Шаардлагатай бол сурагчдын зав гэж үзсэн үр дүнг туршиж үзэх хэрэгтэй. Энэ суралцахуйн зорилтын хэрэгжилтээр нягт нямбай байдлыг төлөвшүүлэх боломжтой.*	
4.2у. Хатуу бодисыг устай холиход гарах өөрчлөлтийг тодорхойлж, тэдгээрийг усанд уусдаг, уусдаггүйгээр нь ангилах	- Мод, төмрийн үртэс, элсэн чихэр зэрэг хатуу бодис, материалын усанд уусах туршилтыг төлөвлөж, гүйцэтгэнэ. - Туршилтын үр дүнд бодис, материалыг усанд уусдаг, уусдаггүйгээр нь ангилна. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчид хатуу бодисыг усанд уусдаг, уусдаггүйгээр нь ангилсны дараа багш яагад уусна гэж үзсэн бэ? гэсэн асуултаар чиглүүлж болно. Энэ асуултад хариулахын тулд сурагч 4.2т суралцахуйн зорилтоос сурсан мэдлэгээ ашиглах юм. Мөн энэхүү анхааруулж буй үйлдлүүд нь сурагчийг үнэлэх гол үзүүлэлт болно.* *Сурах бичгийн 47-78 дугаар хуудас дахь "Яагаад хурдан уусч байна вэ?", "Шингэнийг яаж хэмжих вэ?" гэсэн агуулгыг хассан. Мөн "Хатуу, шингэн, хийн өөрчлөлт" бүлгийг V анги руу шилжүүлсэн болохыг анхаарна уу. Хичээлийн дараа сурагчид өөрсдөө туршилтын материалаа цэвэрлэж, цэгцэлдэг бологоход багш анхааараарай.*	- Хатуу зүйл (мод, төмрийн үртэс, элсэн чихэр) -Шилэн сав, хутгуур, ус хэмжигч сав - Сурах бичиг

План ба газар зүйн зураг

План ба таних тэмдгийн талаар ойлгож, план зураг үйлдэх, газрын зурагт хэмжилт хийх, зүг чигийг тодорхойлох замаар орон зайн төсөөллөө хөгжүүлнэ.

Бүлгийн нэр томьёо: План зураг, таних тэмдэг, зүг чиг

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2г. Сургууль орчмын план зурахдаа юмсыг таних тэмдгээр дүрслэн зүг чигийг тэмдэглэх	- 3-р ангид зурсан ангийн план зураг дээрээ ярилцана. - Сургууль орчмын план зураг зурах төлөвлөгөө гаргах. Төлөвлөхдөө сургууль орчмын планд зурах зүйлсээ сонгоно. Жишээ нь: Биеийн тамирын талбай, ногооны талбай, цэцгийн мандал гэх мэт. - Дүрслэх зүйлсээ төлөөлүүлэх таних тэмдгийг сонгоно. Жишээ нь: Талбайг тэгш өнцөгт хэлбэрээр, моддыг жижиг дугуй дүрсээр илэрхийлэх гэх мэт. Сонгосон таних тэмдгээ ашиглан сургууль орчмын план зурах ба зүг чигийг тэмдэглэнэ. - Үйлдсэн план зураг дээр ямар зүйлс, хаана оршиж байгаа зэргийг зүг чигтэй холбож тайлбарлан ярилцана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагч өөрийн сурч буй сургууль орчмын планыг зурахыг анхаарна уу. Сургууль орчмын план зурагт орох зүйлийн жагсаалт гаргах тул багш арга зүйн төлөвлөлтөдөө эхэүү алхмыг нарийвчлан тооцох шаардлагатай. Зарим жижиг зүйлийг оруулахгүй байж ч болно. Зурсан план зураг нь энгийн, ойлгогдохуйц байх ёстой тул баг тус бүр хоорондоо зургаа солилцож, харилцан тайлбарлах нь үр дүнтэй байж болох юм. Сурагчдыг план зургаа зөв зурсан, тэмдэг тэмдэглэгээний тайлбарыг бичсэн эсэх, эд юмсын болон зүг чигийн тэмдэглэгээг ашиглан план зургийг зөв тайлбарлаж буй эсэхийг анзаарч үнэлээрэй. Мөн хичээлийн явцад сурагчид план зураг зурах ажлын төлөвлөгөө гаргаж байх үед тэд хэрхэн хамтран ажиллаж буйг анхааараарай.*	- 3-р ангид зурсан ангийн план зураг - Харандаа, өнгийн харандаа, том цаас - Гурвалжин, дөрвөлжин зэрэг геометрийн дүрс, тэмдэглэхэд ашиглах зориулалтын шугам - Амьтан, ургамал болон бусад дүрсэн тэмдгүүд -Сурах бичиг 
4.2х. Юмсын бодит хэмжээг өөрийн зурсан план зурагтай харьцуулах	- 4.2г суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид сургууль орчмын план үйлдсэн. Тэрхүү зургаа ашиглана. Үйлдсэн план дээр дүрслэгдсэн зүйлсийн талбайг хэмжинэ. Жишээ нь: Сургуулийн урт юм уу биеийн тамирын талбайн өргөн ба уртыг газар дээр хэд байгааг метрээр юмуу алхмаар хэмжиж болно. - Дараа нь эдгээр талбай план дээр (буюу цаасан дээр) хэдэн см зурагдсан болохыг шугамаар хэмжинэ. - Хэмжилт дээрээ үндэслэн газар дээрх зүйлсийн бодит хэмжээг цаасан дээр хэр зэрэг багасган буулгаснаа тооцоолж учрыг тайлбарлан ярилцана. Жишээ нь: Газар дээр биеийн тамирын талбайн урт 10 м байсан бол миний зурсан план дээр энэ нь 10 см болж дүрслэгдсэн байна. Бодит хэмжээнээс 100 дахин багасгаж зурсан. Учир нь газар дээрх зайг тэр чигээр нь цаасан дээр буулгах боломжгүй тул багасгаж дүрсэлнэ гэх мэт. - Бодит хэмжээг, планд дүрсэлсэн хэмжээтэй харьцуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэ суралцахуйн зорилтын үнэлгээ нь сурагч бодит зүйлийг, өөрийн зурсан юмстай харьцуулж буй арга, түүнийгээ хэрхэн илэрхийлж байгаад оршино. Мөн хэмжих чадвар ч үүнд хамаарна.*	-Метр, -Хуваарьтай шугам, харандаа -Хэмжигч юмуу гортиг, метр

4.2ц. Өгсөн газарзүйн зураг дээр хол, ойр зайг хэмжиж харьцуулах	- Монгол орны, аймгийн, сумын болон өөр улсын гэх мэт ямар нэг газарзүйн зураг сонгон цэгүүдийн хоорондох шулуун зайг шугамаар хэмжинэ. Жишээ нь: Аймгийн төвөөс сумын төв хүртэл ямар зайтай дүрслэгдсэн байна вэ? гэх мэт. - Энэ байдлаар хол, ойр янз бүрийн зайг хэмжиж харьцуулна. Харьцуулахдаа манай сумын төвөөс хамгийн ойр орших сум, хамгийн хол орших сум гэх мэт. Өөрийн амьдарч буй аймаг, сум, дүүргийн газарзүйн зургийг ашиглавал хичээл улам сонирхолтой болно. ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэ суралцахуйн зорилтоор сурагчийн хэмжилт хийх чадвар, таних тэмдэг хэр ашиглаж байгааг үнэлж болно.*	Төрөл бүрийн газарзүйн зураг шугам, харандаа, зүг чигийн ялгааг харуулсан дүрс, зураг
4.2ч. Өгсөн газарзүйн зураг дээр дүрслэгдсэн зүйлсийг таних тэмдэг ашиглан ялгах	- Өгсөн газарзүйн зургийн таних тэмдгийг (хил, гол, нуур, гадарга, хот, суурин газар, төмөр зам гэх мэт) ажиглана. - Таних тэмдэг ашиглан газарзүйн зурагт дүрслэгдсэн зүйлсийн ерөнхий байдлыг хэлэлцэн бичнэ. Жишээ нь: Монгол орны баруун зүгт өндөр уулс их байдаг гэх мэт. ***Багшийн анхаарах зүйл:*** *Багш та газарзүйн зураг сонгохдоо хэд хэдэн төрлийн зураг сонгохоос гадна өөрийн орон нутгийн онцлогийг харуулсан зураг байж болно. Үүнд ургамал, амьтан, ашигт малтмалын мэдээлэл бүхий зураг ч байж болно. Жишээ нь: Ашигт малтмалын зурагт нүүрс энд байдаг гэх мэт геометрийн дүрсээр тэмдэглэсэн зураг үзүүлж болох юм. Үнэлэхдээ жишээлбэл, зургаас Монгол орны газрын гадаргын төрх байдлыг өнгөний шатлал ашиглан тайлбарлан бичсэн байвал сурагчдын тайлбарт зүг чигийн тэмдэглэгээ ашигласан эсэхийг анхаарах гэх мэт.*	Монгол орны газрын гадаргыг харуулсан зураг (өнгөний шатлал бүхий тэмдэглэгээтэй), зүг чигийн тэмдэглэгээ, зураг 

ТАВДУГААР АНГИ

Бага боловсролын 5 дугаар ангийн “Хүн ба байгаль” хичээлийн суралцахуйн зорилтуудыг агуулгаар нь багцлан “бүлэг”-үүдэд хуваасан болно. Агуулгыг судлах дараалаар нь эрэмбэлэн арга зүй, үйл ажиллагааг санал болгосон хэдий ч дараалал, арга зүй нь та бүхэнд нээлттэй, уян хатан байх болно. Сурагчдынхаа суралцах хурд, судлах цагтаа багтаан та бүхэн уг хөтөлбөрт тусгасан агуулгыг илүү дэлгэрүүлж, эсвэл нэмэлт агуулгыг сонгон оруулж болно. Гэхдээ суралцагчдын нас, сэтгэхүйн онцлог, агуулгын залгамж холбоог харгалзан хэт ачаалалтай ажиллуулахгүй байх нь зүйтэй.

5.1. ГАРАГ, ДЭЛХИЙ

Одот тэнгэр

Энэ бүлэгт сурагчид орчлон ертөнцийн талаар судалж, багаар хамтран ажиллаж, одод эрхэсийн байрлал, хөдөлгөөнийг ажиглах, судалгаа хийж төлөвлөгөө боловсруулснаар сурах арга барилаа хөгжүүлэх юм.

Бүлгийн нэр томьёо: Нар, сар, дэлхий, тэнхлэг, эргэх хөдөлгөөн, байрлал, зүг, чиг, өнцөг, өдөр, шөнө, од, долоон бурхан, алтан гадас

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1а. Сүүдрийн чиг ба уртын өөрчлөлтөөр нарны байрлалыг тодорхойлох	- Нарны үзэгдэх хөдөлгөөний талаар таамаглал дэвшүүлэн ярилцах - Нарны байрлалыг сүүдрийн чиг, уртын өөрчлөлтөөр илрүүлэх туршилтын төлөвлөгөө боловсруулах (туршилт гүйцэтгэх өдөр, хэрэглэгдэхүүн, сүүдрийн өөрчлөлтийг хэмжих хугацаа, хэмжих арга, ажлын дараалал гэх мэт), хэлэлцэнэ. - Туршилтын үед анхаарах зүйлийг тодруулна - Туршилтын үр дүнг тэмдэглэх ажлын хуудсыг хамтран боловсруулж, сайжруулна. - Туршилтыг гүйцэтгэх: Сүүдрийн чиг болон уртын өөрчлөлтийг ажиглаж, хэмжих, туршилтын үр дүнг тэмдэглэнэ. Энэ суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд хичээлийн 1 цаг хангалтгүй байвал төлөвлөгөөний дагуу туршилтаа гүйцэтгэх үйлийг гэрийн даалгаварт өгч болох юм. - Туршитын үр дүнг илэрхийлэх тохиромжтой аргыг сонгох, илэрхийлэх (зураг, хүснэгт, диаграмм гэх мэт) - Туршилтын үр дүнг хэлэлцэнэ. - Туршилтаа төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж чадсан эсэхээ үнэлэх (өөрийн үнэлгээ). Хэрэв чадаагүй бол шалтгааныг тайлбарлана. - Нарны байрлалыг тодорхойлохдоо туршилтын үр дүнгээс жишээ, баримт татах ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэхүү суралцахуйн зорилт нь сурагчдын өдөр тутмын амьдралд тохиолддог үзэгдэл тул багш та сурагчдаар бодит туршилт хийлгэхэд анхааараай. Зохиомлоор гэрэл үүсгэгч ашиглавал туршилтын үр дүн харилцан адилгүй болно. Мөн тус суралцахуйн зорилтын хэрэгжилтээр сурагчдын сорил туршилт төлөвлөх, ажиглалт хэмжилт хийх, үр дүнг диаграммаар илэрхийлэх чадварыг үнэлэх боломжтой.* *Туршилтыг төлөвлүүлэхэд таны анхаарах зүйл:* 1. *Туршилт бодитоор хийгдэх тул нартай цэлмэг өдрийг сурагчдаар сонгуулахад (ирэх 7 хоногийн цаг агаарын мэдээг илэрхийлсэн зураглалыг сурагчдад харуулж туршилт хийх тохиромжтой өдрийг сонгох) анхаарна уу.* 2. *Өдрийн турш сүүдрийн чиг, хэмжээ өөрчлөгддөг. Энэхүү өөрчлөлтийг бид яаж турших вэ? Хэдэн удаа хэд, хэдэн цагт туршилтыг гүйцэтгэх вэ? Гэх мэт асуултаар дэмжлэг үзүүлэх* *Туршилтын үр дүнг тэмдэглэхэд анхаарах зүйл:* *Саваа модны сүүдрийн байрлалыг зурахдаа зөвхөн сүүдэр туссан хэсэг дээгүүр зурахыг анхааруулах. Энэ нь сүүдрийн уртын өөрчлөлтийг хэмжихэд хэрэгтэй (сүүдрийн уртыг зургаас хэмжих боломж бүрдэнэ) ба нэг туршилтаар 2 өөр үр дүнг нэгэн зэрэг тэмдэглэх боломж олгох юм.* *Ажиглалтын үр дүнг багшийн номын 8-р хуудасны “ажиглалтын тайланг бичих, хэлэлцэх” сэдэвт хамаарах чиглэлээр удирдаж болох юм.*	Жижиг саваа мод, суурь, балын харандаа, хэмжилт хийх шугам Сурах бичиг дэх дасгал даалгаврыг туршилтын төлөвлөгөө боловсруулахад ашиглах боломжтой. 

	Сурагчдаар өөрийн үнэлгээ хийлгэхэд анхаарах зүйл: *Хэрэв туршилтын үр дүнг диаграммаар илэрхийлсэн бол сурагчдын диаграмм алдаагүй зөв зурагдсан эсэхийг сурагчдаар үнэлүүлэх (өөрийн үнэлгээ ашиглах). Сурагчдаар өөрийн үнэлгээ хийлгэхэд диаграмм байгуулахад анхаарах зүйл, шалгуурыг тодорхой өгөх шаардлагатай.* *Сурагчид туршилтын үр дүнгээр нарны байрлалыг тодорхойлно. Тэрхүү тодорхойлолт нь шинжлэх ухааны ойлголттой зөрчилдөж болох ч багш та зөв ойлголтыг шууд хэлэхээс татгалзаарай. Учир нь хариулт нь 5.1б дүгээр суралцахуйн зорилтын хэрэгжилтээр тайлагдах юм.* *Туршилтын үр дүнд нарны байрлалыг тодорхойлон хэлсэн сурагчдын хариултын жишээ: Сүүдрийн байрлалын өөрчлөлтөд үндэслэсэн хариулт: Нар зүүнээс баруун зүгт шилжиж байна. Нар байнга хөдөлгөөнд оршдог. Учир нь сүүдрийн байрлал баруунаас зүүнд шилжиж байсан гэх мэт.*	
5.1б. Дэлхий тэнхлэгээ тойрон эргэсний улмаас нар хөдөлж байгаа мэт харагддагийг загварчлах	- Нар, сар, дэлхийн хөдөлгөөнт загвар (бичлэг)-аас юу ажиглахаа (хөдөлгөөн) төлөвлөнө. - Нар, сар, дэлхийн хөдөлгөөнийг ажиглана. - Дэлхий, нар ба сарны хөдөлгөөнийг сумаар зураглаж үзүүлнэ. - Нар, сар, дэлхийн хөдөлгөөнийг тоглоомын аргаар биечлэн үзүүлж болох юм. - Дэлхий тэнхлэгээ тойрон эргэсний улмаас нар хөдөлж байгаа мэт харагддагийг тодорхойлох ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэ суралцахуйн зорилт нь 5.1а дугаар суралцахуйн зорилтын эргэлзээг тайлах юм.* *Нарыг тойрох дэлхийн хөдөлгөөний кино үзүүлэх, дэлхий тэнхлэгээ тойрон эргэсний улмаас нар хөдөлж байгаа мэт харагддагийг ажиглуулж болно.* *Дэлхийн хөдөлгөөн:* *-Тэнхлэгээ эргэх хөдөлгөөн* *-Нарыг тойрох хөдөлгөөн.* 	Нар, сар, дэлхийн хөдөлгөөнт загвар, бичлэг Нар голчоороо дэлхийгээс 100 гаруй дахин том учир дэлхийг одон бөмбөг гэвэл 3-4 м голчтой бөмбөг хэрэгтэй.
5.**1в**. Өдөр, шөнө ээлжилж буй үзэгдлийг дэлхий тэнхлэгээ эргэх хөдөлгөөнөөр тайлбарлах	- Глобус (дэлхий) дээр гар чийдэнгээс (нарнаас) гэрэл (глобусын тал хэсэгт гэрэл тусахаар тохируулах) тусгаж ажиглах - Бөмбөрцгийн тал хагаст гэрэл тусч байгаа нь өдөр, эсрэг талд сүүдэртэй харанхуй байгааг ажиглах, ажигласнаа зурж үзүүлэх. Сурагчийн ажиглах гол зүйл бол дэлхийн загвар дээр тусч буй гэрэл сүүдрийн зааг юм. Үүнээс сурагчид дэлхийн бөмбөрцгийн тал нь гэрэлтэж, эсрэг тал нь сүүдэртэж байгааг олж харна.	

	- Ажиглалтын үр дүнг самбарын маркераар глобус дээр тэмдэглэж ч (гэрэл, сүүдрийн заагийг дагуулан зурах) болно. Энэ нь сурагч үндэслэлтэйгээр тайлбар хийхэд дэмжлэг үзүүлнэ. - Баримт нотолгоог харуулсан видео үзэж, загвар туршилтаар ажиглсан үр дүнгээ харьцуулах - Хүүхдүүд бие биедээ олсон санаагаа ярих, дүрслэх - Өдөр, шөнө ээлжилж буй шалтгаан нь дэлхийн тэнхлэгээ эргэх хөдөлгөөнөөс хамаарч буйг баримт татаж тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Дэлхийн эргэлтийг загварчлан судлах боломж бүрдүүлэх хэрэгтэй.* *Өдөр шөнө хэрхэн солигддог болохыг сурагчид өөрсдөө гаргаж ирвэл сайн. Ингэхийн тулд сурагчдын ажиглах зүйл нь глобус дээрх гэрэл, сүүдрийн заагийг ажиглаж тэмдэглэсэн байх шаардлагатай.* *Планетар буюу одон орны төвд зочлох, эсвэл stellarium программ ашиглаж дэлхийн эргэлтийг харуулж болно.*   *Дээрх 2 зургийг багш та анхаарч туршилтын бэлтгэлээ сайтар базаагаарай. Үүнд ангийн орчин, мөн дэлхийн загвар дээр тусах гэрлийг тохируулах шаардлага гарна.*	Глобус, чийдэн, маркер, ажлын хуудас -Сурах бичиг
5.1г. Сар (хоногийн)-ны хөдөлгөөнийг тодорхой биеттэй харьцуулах	- Сарны талаар бид юу мэдэх вэ? Асуултын хүрээнд ярилцаж өмнөх төсөөллийг тандах боломжтой. - Сарны байрлал ба хөдөлгөөнийг судлах ажлын төлөвлөгөөг боловсруулах (үйл ажиллагааны дараалал, анхаарах зүйл, өнцгийг тодорхойлох арга, зэргийг боловсруулах). - Сарны харагдах өнцөг тодорхойлох туршилт хийх, туршилтаар сарны байрлал, хөдөлгөөнийг ажиглаж зурж, тэмдэглэнэ. Дараагийн ажиглалтыг өмнөх ажиглалт хийсэн газраасаа хийнэ гэдгийг анхааруулна. - Туршилтын үр дүнг харьцуулан хэлэлцэх (30 минутын зайтай хэмжсэн 1, 2, 3 дугаар хэмжилтүүдийн үр дүнгийн ялгааг харьцуулах) - Сар зүүн зүгээс баруун тийш шилжин хөдөлж буй шалтгааныг тайлбарлуулна. Сурагч тайлбарлахдаа дэлхийн танхлэгийн хөдөлгөөнтэй холбож ч болох юм. ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэ хичээлээр сурагчдыг сарны хоногийн хөдөлгөөнийг ажиглах аргад суралцуулахад чиглүүлнэ.*	Сарны хэлбэр байршилыг харуулсан зураг хуудас Багшийн ном дахь “Тэнгэрийн эрхсийн ажиглалт” сэдэв дэх “Хоногийн ажиглалт” 

	Цэлмэг үдэш сарны хэлбэр, хөдөлгөөнийг ажиглуулах, ажиглалт хийхэд том хүнтэй гүйцэтгэхийг анхааруулах, туршилт гүйцэтгэхэд анхаарал болгоомжтой ажиллах заавар, зөвлөмж өгөх. Ажиглалтыг хийхдээ тэнгэр чөлөөтэй харагдах талбайг сонгох. Сарыг харьцуулах зүйлсийг урьдчилан сурагчиддаа хэлсэн байна. Туршилтыг 30 минутын зайтай хэд хэдэн давтамжтай хийх тул бэлтгэлээ сайтар хангах. Үүнд ажлын хуудас чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн багш та тухайн сарын хэдний өдөр, хэдэн цагийн орчимд туршилт хийж болохыг урьдчилан төлөвлөөрэй.	
5.1д. Сарны үзэгдэх хэлбэр (сарын турш-өдрөөс өдөрт) өөр өөр байдгийн шалтгааныг нар, сар, дэлхийн байрлалтай холбон эргэцүүлэх	- Сурагч бүр өөрийн харсан, сайн мэдэх сарны үзэгдэх хэлбэрийг гар картан дээр зурах - Анги нийтээрээ сарны ялгаатай хэлбэр бүхий зургуудийг илрүүлж самбарт байрлуулж болох юм. - Таамаглах: Сар бидэнд яагаад ийм өөр өөр хэлбэртэй харагдаж буйг багаараа хэлэлцэж бусдадаа тайлбарлах (5.1б сурлцахуйн зорилтын хичээлээр ойлгосон санаагаа ашиглаж магадгүй) - Сарны үзэгдэх хэлбэр өөр өөр байгаа шалтгааныг загвар дээр хийх туршилтаар илрүүлэх (бичлэг үзэх, загвар харах, мэдээлэл унших гэх мэт) - Ажиглалт, туршилтын үр дүнг хэлэлцэх (Нар, сар, дэлхийн хөдөлгөөнийг ажигласан үр дүнгээ эргэн санах, холбох) - Үр дүн, дүгнэлт: Сарны хэлбэрүүдийг, нар, дэлхийн байрлалтай холбон тайлбарлах - Сарын турш сарны хэлбэрийг ажиглаж, ажиглалтын хуудаст зурж, тэмдэглэл хөтлөх ***Зурахдаа:*** *Тухайн сар нь баруун талаасаа гэрэлтсэн тал сар уу, зүүн гар талаасаа гэрэлтэж буй тал сар уу гэдгийг сайтар ажиглаж зурна. Энэ нь сарны хөдөлгөөнийг ойлгоход чухал баримт болно.* - Сарны үзэгдэх хэлбэрийн өөрчлөлтийг (сарын эхэн, дунд, сүүл, эсвэл шинийн 7, 15, 22-ны сарыг ажиглуулж болох юм) сарын хугацаатай холбон тайлбарлуулна. Ингэхийн тулд сурагчийн ажиглалт хийх ажлын хуудаст сар зурах хэсэг, сарыг ажигласан сар, өдөр, мөн нар нь сарны аль талд байсан бэ зэрэг мэдээлэл оруулах хэсгүүдийг төлөвлөөрэй. Эдгээр үр дүнгийн мэдээлэлд үндэслэн сурагч сар өдөр бүр өөр өөр хэлбэртэй харагддаг шалтгааныг тайлбарлана. - Сурагч бүр сарны тухай зурагт тайлан гаргаж болно. Жишээлбэл, баруун гар талаасаа гэрэлтсэн тал сар сарын эхэнд үзэгдсэн, сарын дундуур тэргэл сар, харин сарын сүүлд зүүн гар талаасаа гэрэлтсэн тал сар ажиглагдсан. Үүнээс үзэхэд сар дэлхийг цагийн зүүний эсрэг тойрдог юм байна гэх мэт ойлголт тайлангаас харагдахаар сурагч зурагласан байж болох юм. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчдад сарыг хэрхэн зурах заавар өгнө.* *Сурагчдын зурсан сарыг самбарт байрлуулахдаа тэргэл, бөгтөр, тал, хавирган, шинэ сар, эсвэл шинэ сар, хавирган, тал, бөгтөр, тэргэл сар гэсэн дараалаар байрлуулаарай.* *Энэ нь сарны мөчлөг дэх харагдах хэлбэрийн дараалал юм. Мэдээж сар аль талаасаа гэрэлтэж байгаа вэ гэдгийг мартаж болохгүй.*	Гар карт, нар сар, дэлхийн хөдөлгөөнт загвар, загвар туршилтын хэрэглэгдэхүүн, ажиглалтын хуудас, Сурах бичиг

	Мөн хичээлийн үед сурагчдад сарны хэлбэрт анхаарч ажиллахад чиглүүлэх. Өөрөөр хэлбэл шинийн 2-ны, 7-ны сар гэж ярихаар бага ангийн сурагчдад хүндэддэг. Хэлбэрийн өөрчлөлтийг (сарын эхэн, дунд, сүүл) сарын хугацаатай холбон тайлбарлана. *Тус хичээл нь танхим болон танхимаас гадуур ажиглалтаар нэг сар үргэлжилж ч болох тул сарын турш хийх ажиглалтын аргачлалыг тодорхой гаргаж, сурагч бүрд ажиглалтын хуудас бэлтгэж өгөөрэй. Энэ нь сурагчдын хувьд танхимын хичээлээр ойлгосон зүйлээ бодит үзэгдэлтэй холбож зорилготой ажиглалт хийх боломжийг бүрдүүлж байгаа явдал юм. Энэ суралцахуйн зорилт нь 4-р ангийн гэрлийн шинж чанар бүлэгтэй шууд хамааралтай. 4-р ангидаа гэрлийн шинж чанарыг тааруу судалсан хүүхэд энэ хичээлийн явцад бэрхшээлтэй тулгарч болзошгүй тул багш сурагчдынхаа өмнөх мэдлэг ойлголтыг илрүүлсний үндсэн дээр хичээлээ төлөвлөөрэй. Сурагчдын ажиглах, туршилтын үр дүнг зургаар илэрхийлэх зэрэг чадварыг энэ суралцахуйн зорилтоор дэмжинэ.*	
	 *Багш та дараах сайтруу зочлоорой.* *http://www.arvindguptatoys.com/toys/Flipit!moon.html*	
5.1е. Алтан гадас ба Долоон бурхан оддын байрлалыг зураглаж, зүг чигээ тодорхойлох	- Алтан гадас ба Долоон бурхан оддыг таних, нэрлэх - Оддыг ажиглах туршилтын төлөвлөгөөг багштайгаа хамтран боловсруулах, хэлэлцэх - Төлөвлөгөөний дагуу туршилтаа гүйцэтгэнэ. Цэлмэг үдэш тэнгэрийг ажиглах, ажиглалтаар Алтан гадас, Долоон бурхан оддын байрлалыг тогтоож зураглах. Зураглахдаа зүг чигийн тэмдэглэгээ ашиглана. - Алтан гадас, Долоон бурхан оддын байрлалыг ертөнцийн зүг чигтэй холбож тайлбарлана. Энэ нь тус суралцахуйн зорилтын гол агуулга болно. ***Багшийн анхаарах зүйл:*** *Суралцахуйн зорилтын тохируулгаар агуулгын хүрээг багасгаж энэ хичээлээр зөвхөн Долоон бурхан, Алтан гадас оддыг судлахаар төлөвлөсөн. Үүнд хамаарахгүй зарим дасгал даалгаврын ажиллуулах шаардлагагүй. Тухайлбал оддын өнгө, гэрэлтэлт гэх мэт.* *Оддын талаар судлахад орой гэртээ ажиглахаар даалгаврыг өгөх хэрэгтэй. Тэнгэрийн хойд хагасыг ажиглуулна. Ажиглалтын хуудаст зүг чигийн тэмдэглэгээг заавал зурсан байна.*  	Одот тэнгэрийн зураг, тэмдэглэл хийх ажлын хуудас, бичлэг, Долоон бурхан, Алтан гадас одны тухай мэдээлэл, зурагт хуудас, видео бичлэг 

	Планетар буюу одон орны төвд зочлох, эсвэл stellarium программ ашиглаж одны ордыг өдрийн цагт харж, дэлгэц дээр томруулан одот тэнгэрийг харуулж болно. Багш та сурах бичиг дэх бүх агуулгыг заах бус хичээлийн агуулгаа суралцахуйн зорилтоор тодорхойлоорой.	

Голдож, зэргэдээр зүг чиг олох

Сурагчид өмнөх бүлэгт үзсэн дэлхийн хөдөлгөөн, өдөр шөнө болох, нар ба одоор зүг чиг олох тухай чадвартаа үндэслэн голдож, зэргэдийн тухай ойлголтыг эзэмшинэ. Мөн голдож, зэргэдээр дэлхийн гадарга буюу глобус дээр баруун, зүүн ба хойд, өмнө зүгийг ялган байрлал тодорхойлохдоо ашигладаг болно.

Бүлгийн нэр томьёо: Глобус, голдож, зэргэд, анхны голдож, экватор, хойд туйл, өмнөд туйл, газарзүйн солбицол, цэгийн байрлал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1ж. Глобус болон дэлхийн газарзүйн зураг дээр ус (далай) ба хуурай газрыг ялган нэрлэж, хэмжээг харьцуулах	- Дэлхийн газарзүйн зураг, глобусыг ажиглаж ус далай) ба хуурай газрыг зааж нэрлэнэ. - Глобус ба газарзүйн зураг дээр хуурай газрын хэсгүүд (тивүүд)-ийг зааж нэрлэнэ. Ус болон хуурай газрын хэмжээг харьцуулна. ***Багшийн анхаарах зүйл:*** *Томоохон далай тэнгис, тивүүдийн талаарх ерөнхий мэдээлэл бэлтгэх*	Глобус, дэлхийн газар зүйн зураг, томруулдаг шил, дэлхийн гадарга дахь ус ба хуурай газрын харьцаа
5.1з. Глобус болон дэлхийн газарзүйн зураг дээр голдож ба зэргэдийг ялган харьцуулах	- Глобусыг бөмбөгтэй харьцуулан төстэй ба ялгаатай талыг хэлнэ. - Зүг чигийн тэмдэглэгээ ашиглан глобус дээр хойд, өмнөд туйлыг олж заана. - Голдож ба зэргэдийн **ялгааг** нотлох туршилт хийнэ. Туршилтын санаа: 1. Глобус дээр голджийн дагуу утас юмуу тууз нааж (хойд туйлаас өмнөд тул хүртэл) хайчилна. Дараа нь утсуудыг эгнүүлэн тавьж уртыг хэмжиж болно. 2. Зэргэдийн дагуу утас болон тууз наана. Дараа нь утсуудыг эгнүүлэн тавьж уртыг хэмжиж тэмдэглэнэ. Урт нь ялгаатай байгааг ажиглана. 3. Хэмжилтийн үр дүнд үндэслэн голдож ба зэргэдийн ялгааг харьцуулна. 4. Зарим голдож (анхны голдож) ба зэргэд (экватор, матрын ба мэлхийн зам) бусдаас онцлог дүрслэгдсэнийг ажиглаж, хаагуур татагдсан байгааг ярилцана. - Глобус болон газарзүйн зураг дээр голдож ба зэргэдийг ялгаж, зааж үзүүлнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Хойд, өмнөд туйл ба голдож зэргэд зэрэг шугамыг дэлхий дээр "татагдсан" байдаг хэмээн буруу ойлгож магадгүй. Иймд эдгээрийг глобус болон газарзүйн зураг дээр тодорхойлно гэдгийг ойлгуулах мэдээлэл бэлдээрэй.*	Глобус, дэлхийн газарзүйн зураг, бөмбөг, нэхмэлийн утас, шугам, хайч Сурах бичиг

5.1и. Голдож, зэргэдийг ашиглан дэлхийн өмнөд ба хойд хагас, баруун ба зүүн хагасыг ялгах	- Анхны голджоор дэлхийн бөмбөрцгийг баруун ба зүүн тал болгон хуваадаг болохыг тайлбарлан, зурж үзүүлнэ. - Глобус дээр экваторын шугамыг олж бусад зэргэдээс хэрхэн ялгаж болохыг ажиглана. - Дэлхийг экваторааар нь хоёр тийш хойд ба өмнөд тал бөмбөрцөг болгон хуваадаг болохыг зураглаж ойлголтоо гүнзгийрүүлэх, бататгах дасгал ажиллаж болох юм.  1. Монгол улс болон зарим томоохон улсууд дэлхийн аль хагаст оршиж байгааг тодорхойлно. 2. Голдож, зэргэд ашиглан зүг чиг тодорхойлох туршилт хийнэ. Жишээ нь: Улаанбаатар хотоос хойш, урагш, баруун зүүн аль зүгт ямар аймаг оршиж байна вэ? Эсвэл манай аймгийн хойд, өмнө, баруун, зүүн талд ямар аймаг оршиж байна вэ гэх мэт. 3. Монгол улсаас хойш, урагш, баруун зүүн аль зүгт ямар улс оршиж байна вэ? гэх мэт ***Багшийн анхаарах зүйл:*** *Голдож, зэргэд ашиглан зүг чиг тодорхойлох үйл ажиллагаа нь 2 үе шаттай байгааг анзааараарай. Нэгд, эхлээд нэлээд ерөнхий авч үзэж байна. Жишээ нь: дэлхийн хойд хагаст, өмнөд хагаст юмуу баруун хагаст, зүүн хагаст гэх мэт.* *Хоёрт, дараа нь ойлголтоо гүнзгийрүүлэн бататгах дасгал ажиллаж байна. Жишээлбэл, Улаанбаатар хотоос хойш, урагш, баруун зүүн тийш гэх мэтээр тодорхойлох нь арай нарийсган авч үзэж буй хэлбэр болохыг анхаарна уу.* *Хойд ба өмнөд тал бөмбөрцөг гэсэн нэршлийн оронд хойд ба өмнөд хагас гэсэн нэршил хэрэглэж болно.*	Глобус, сурах бичиг, самбарын маркер, зүг чигийн тэмдэглэгээ Сурах бичиг 
5.1к. Голдож, зэргэдийг ашиглан цэгийн байрлалыг тодорхойлох	- Голдож, зэргэдийг ашиглан дэлхийн гадарга дээр газар орны байрлалыг хэрхэн тодорхойлох вэ? гэсэн асуултын хүрээнд ярилцана. - Голдож ба зэргэдийг илэрхийлсэн тоог уншиж, тэмдэглэнэ. - Цэгийн байрлалыг голдож зэргэдийн огтлолцол буюу голдож, зэргэд ашиглан тодорхойлох дасгал хийнэ. - Глобус болон газарзүйн зураг дээр голдож, зэргэдийг ашиглан цэгийг тодорхойлох аргыг дэвтэртээ бичиж, ярилцана.	Глобус, газарзүйн зураг

	Багшийн анхаарах зүйл: *Хэрэв глобус болон газарзүйн зураг байхгүй бол урьдчилан бэлдсэн үзүүлэн байж болно. Жишээлбэл, дөрвөлжин нүднүүдийг тодруулаад эгнээг нь үсгээр, баганыг нь тоогоор тэмдэглэсэн хэрэглэгдэхүүн бэлдэн ашиглаж болно. Цэгийн байрлалыг голдож, зэргэдийн огтлолцол ашиглан тодорхойлох дасгал ажил хийлгэнэ.* *<u>Нэмэлт:</u> 5-р ангийн STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно. Жишээлбэл: Загвар угсардаг хар тавцан. Энэ тавцаны эгнээ нь A-Q хүртэл үсгээр, багана нь 1-12 хүртэл тоогоор дугаарлагдсан байдаг. Тиймд багш та STEM сургалтадаа энэ суралцахуйн зорилтоор сурагчдын эзэмшиж буй чадварыг бататган ашиглаарай. Багш хичээл хоорондын агуулга, арга зүйн уялдааг сайтар судлах шаардлагатай.*	

5.2. ЮМС ҮЗЭГДЭЛ

Бодисын төлөвийн шилжилт

Хатуу, шингэн, хий, тэдгээрийн шилжилт болон ууршилтад нөлөөлөх зүйлсийг туршилтаар тодорхойлж, тайлбарлаж чаддаг болно.

Бүлгийн нэр томьёо: Хайлах, хөлдөх, ууршиx, ууршихын эсрэг үзэгдэл (конденсаци), бодисын жижиг хэсэг, усны эргэлт

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2а. Ус хатуу, шингэн, хийн төлөвт шилжих үзэгдлийг нөхцөлтэй нь холбон илэрхийлэх	- Мөсийг ус, усыг уур болгох туршилтыг хийж төлөв байдлын шилжих үеийн температурыг хэмжих боломжтой. Тухайн орон нутгийн байршил, даралтаас хамаарч усны буцлах цэг бага зэрэг зөрүүтэй гарна. Жишээлбэл, Улаанбаатарт 97 орчин градуст буцалдаг. - Иймд мөс ус (0ºC-аас дээш)-д, уснаас уур (100ºC)-д, уурнаас ус (100ºC-аас доош)-д, ус мөс (0ºC)-д харилцан шилждэг нөхцөлтэй болохыг хэлэлцэж ойлгоно. - Мөс, ус, уурын жижиг хэсгийг дүрслэн ялгааг тайлбарлах боломжтой. - Хайлах, ууршиx, шингэрэх, хатуурах үзэгдлийг ялгаж, нэрлэнэ. - Хувцас яагаад хатдаг вэ?, борооны дараах ус яагаад хэсэг хугацааны дараа алга болдог вэ? зэрэг асуултын дагуу дээрх үзэгдлүүдийг ахуй амьдралтай холбож ярилцана. - Ууршилттай холбоотой бидний өдөр тутам тохиолддог үзэгдлийн жишээ гаргаж тайлбарлах боломжтой. Жишээлбэл, данхны цоргоноос буцалсан усны уур гарах гэх мэт	Усны хатуу, шингэн, хийн шилжилтийг харуулсан зураг IV ангийн сурах бичгийн 50-р хуудас
5.2б. Хайлах, хөлдөх үеийн өөрчлөлтийг бодисын жижиг хэсгээр дүрслэн үзүүлэх		- Халаах, хөлдөх үзэгдлийн ялгааг харуулсан зураг - Жижиг хэсгийг илэрхийлэх, зурах хэрэгслүүд
5.2в. Ууршиx, шингэрэх үеийн өөрчлөлтийг бодисын жижиг хэсгээр зурж харуулах		- Ууршиx, шингэрэх үзэгдлийг турших багаж хэрэгсэл - Шингэрэх үзэгдлийг харуулсан зураг Жижиг хэсгийг илэрхийлэх гарын доорх материал IV ангийн сурах бичгийн 50-53 дугаар хуудас

5.2г. Байгаль дахь усны эргэлтийг хатуу, шингэн, хийн төлөвийн шилжилтээр тайлбарлах	- 5.3а-д явуулсан туршилтын талаар ярилцаж байгальд энэ үзэгдэл явагддаг жишээг гаргаж ярилцана. Ус хий, шингэн болохыг туршилттай холбох (сурах бичгийн 31-р тал дахь туршилт) - Гаргасан жишээнүүдийг нэгтгэн байгаль дахь усны эргэлтийг бүдүүвчээр илэрхийлнэ. Байгаль дахь усны эргэлтийг харуулсан бичлэг үзүүлж сурагчдын үр дүнг харьцуулж сайжруулах үйл ажиллагааг хийж болно. - Байгаль дахь усны эргэлтийн үед явагдах үзэгдэл, төлөвийн шилжилтийг нэрлэж тайлбарлана. - Байгаль дахь усны эргэлт нь ургамал амьтны амьдралд ямар үүрэгтэй вэ? зэрэг асуултаар үзэгдлийн ач холбогдлыг тодруулж болох юм.	-Байгаль дахь усны эргэлтийг харуулсан зураг Туршилт хийх багаж хэрэгсэл Сурах бичиг

Эргэх ба үл эргэх өөрчлөлт

Эргэх, үл эргэх өөрчлөлтийг ялган таньж, ангилж чаддаг болно.

Бүлгийн нэр томьёо: Эргэх, үл эргэх өөрчлөлт, холимог, шүүх арга, соронздох арга

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2д. Үзэгдлийг эргэх, үл эргэх гэж ангилах, жишээ гаргах	- Байгальд болон бидний эргэн тойронд явагддаг бодис, материалын хувирал өөрчлөлтийн талаар жишээ гаргана. - Гаргасан жишээнүүдийг хувирал, өөрчлөлтийн үр дүнд үндэслэн эргэх (ус, шоколад хайлах, масло хөлдөх зэрэг), үл эргэх (өндөг шарах, төмөр зэврэх, цаас шатах зэрэг) гэж ангилна. - Яагаад ийнхүү ангилсан шалтгаанаа хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Эргэх, үл эргэх гэдэг шинжлэх ухааны үг хэллэг хэрэглүүлэхэд анхаарч ахуй амьдрал дахь түгээмэл тохиолддог жишээ гарган тайлбарлуулахад анхааараарай.*	Сурах бичиг
5.2е. Лаа шатах нь үл эргэх үзэгдэл болохыг тодорхойлох	- Лаа шатах үзэгдлийн туршиж, шаталт явагдах нөхцөл, шаталтаар үүсэх бүтээгдэхүүнийг тодорхойлно. - Шаталт нь яагаад үл эргэх өөрчлөлтийн жишээ болж буйг тайлбарлана. - Шатах үзэгдлийг амьдрал дээрх жишээтэй холбож үл эргэх үзэгдэл гэдгийг гүнзгийрүүлж болох юм. ***Багшийн анхаарах зүйл:*** *Лаа шатах үзэгдлийг сайтар ажиглуулан, үүсэх бүтээгдэхүүнийг нэрлүүлэхэд анхаарна уу. Өмнөх хичээл дээр судалсан эргэх, үл эргэх үзэгдэл гэсэн ухагдахууныг гүнзгийрүүлэн тэдгээрийг жишээгээр тайлбарлаж чаддаг болгохыг зориорой.*	- Лаа, шилэн сав, шилэн таг, зомгол Сурах бичиг
5.2ж. Төмөр, элс, модны үртсийг холимгоос нь ялгаж, эргэх үзэгдэл болохыг тодорхойлох	- Мод, элс, төмрийн үртсийг яаж салгах вэ? гэсэн асуултаар сэдэлжүүлэн хичээлээ эхлэх боломжтой. - Мод, төмрийн үртсийг уснаас хэрхэн ялгаж болох аргын талаар таамаглал дэвшүүлнэ. - Таамаглалаа батлах туршилтыг төлөвлөж, гүйцэтгэнэ.	- Элс ба ус -Төмрийн үртэс ба ус -Модны үртэс ба ус Юүлүүр, шүүгч цаас, шилэн аяга, соронз, шилэн хутгуур

	- Холимгийг ялгасан аргын үндэслэл болон энэ холимгыг ялгах өөр арга байгаа эсэх талаар хэлэлцэнэ. - Холимгийг ялгасны дараа энэхүү үзэгдэл нь эргэх, үл эргэхийн аль нь болохыг хэлэлцэнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Төмөр, мод, элсийг хольж, холимгоос тэдгээрийг салгах нь эргэх үзэгдэл болохыг тайлбарлана. Эргэх, үл эргэх үзэгдлийн тухай судалж, шатах урвалын жишээн дээр үл эргэх, холимгоос төмөр, мод, элсийг ялгах нь эргэх үзэгдэл болохыг жишээлэн тайлбарлаж байгаа логик дараалыг багш та сайтар анхаарна уу.*	Сурах бичиг

Цаг агаар ба уур амьсгал

Температур, салхи, тунадасны өөрчлөлтөөр цаг агаарыг тодорхойлох. Тунадас, салхины зүг, чиг хүчийг тодорхойлох замаар шинжлэн судлах арга барилд суралцана.

Бүлгийн нэр томьёо: Мэлхийн зам, матрын зам, температур, халуун ба сэрүүн, хүйтэн орон

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2з. Хоногийн агаарын температурын өөрчлөлтийг тэмдэглэж, шалтгааныг илрүүлэх	- Хоногийн туршид агаарын температур ижил байдаг уу, үгүй бол яагаад гэсэн асуултын хүрээнд ярилцана. - Хоногийн туршид өөрчлөгдөх агаарын температурыг хэмжих, шалтгааныг тодруулах туршилтын төлөвлөгөө (туршилтыг хэзээ, хэрхэн, яаж хийх, туршилт хийх орчноо сонгох) гаргана. - Туршилтаа хийхэд анхаарах зүйлийг тодруулан (хэмжилт хийж буй орчин нэг байх, нэг газраа термометрээ байрлуулах, хөдөлгөхгүй байх гэх мэт) хэлэлцэнэ. - Туршилт, хэмжилт хийж, тэмдэглэлийг үнэн зөв, нямбай хөтөлнө. 1. Температурыг хэмжилт болон хэмжсэн цагаа ажлын хуудаст тэмдэглэнэ. 2. Хэмжилт хийсэн тухайн цагт цаг агаарын байдал ямар байсан тухай ажиглаж, мэдэрснээ (нартай, үүлтэй, салхитай, хуртай, өглөө, өдөр, орой эсэх гэх мэт) тэмдэглэнэ. 3. Туршилт хийсэн өдрийн цаг агаарын дэлгэрэнгүй мэдээг уншиж судална. - Ажиглалт, туршилтын үр дүнг нэгтгэн харьцуулна. - Агаарын температурын өөрчлөлтийн шалтгааныг тодорхойлно. ***Багшийн анхаарах зүйл:*** *Агаарын температур байнга өөрчлөгдөж байдаг гэдгийг сурагчдад ойлгуулахад анхаарах. Мөн туршилтыг ангид бус гадаа гүйцэтгэх тул туршилт төлөвлөх үед сурагчдад бэлтгэл ажлаа сайн төлөвлөхийг анхааруулах. Багш та хичээлээ бэлтгэхдээ баталгаатай эх сурвалжаас тухайн өдрийн (сурагчдын туршилт хийх өдөр) цаг агаарын мэдээг судалсан байх шаардлагатай.*	Термометр (агаарын температур, чийгийг үзүүлдэг электрон термометр байж болно), цаг агаарын мэдээ, туршилтын төлөвлөгөө, ажлын хуудас *http://tsag-agaar.gov.mn/*

	Энэ нь хичээлийн бэлтгэлийн гол зүйлийн нэг болно. Эсвэл цаг агаарын мэдээг сурагчдад харуулж туршилт хийх өдрөө хүүхдүүдтэйгээ ярилцаад сонгож ч болно.	
	Дараах зурагт өдрийн цаг агаарын мэдээг гурав, гурван цагийн давтамжтайгаар үзүүлсэн байна. Үүнээс санаа авч сурагчдын гүйцэтгэсэн туршилтын үр дүнг энгийн зурган мэдээгээр бэлтгүүлж болох юм.  Эх сурвалж: *http://tsag-agaar.gov.mn/forecast/forecast3hours*	
5.2и. Агаарын тунадасыг энгийн аргаар хэмжиж, дүрслэх	- Агаарын тунадас хэр зэрэг их орохыг хэмжиж болох эсэх талаар ярилцана. - Агаарын тунадас хэмжих туршилтын төлөвлөгөөг бие даан боловруулж, (цаг агаарын мэдээнд үндэслэн туршилт хийх хугацааг товлох, хаана, хэзээ, хэрхэн зохион байгуулах, туршилтын дараалаа тогтох, туршилтын үр дүнг тэмдэглэх хуудас бэлтгэх гэх мэт) хэлэлцэнэ. - Туршилтын үед анхаарах зүйлийг тодруулж, туршилтын төлөвлөгөөгөө сайжруулна. - Туршилтын хэрэглэгдэхүүнээ хамтран бэлтгэж туршилтаа гүйцэтгэнэ (Тунадас хэмжигч хийж, орсон хур тунадасыг хэмжинэ). - Туршилтын үр дүнд боловсруулалт хийж, үр дүнг илэрхийлнэ. **Нэмэлт дасгал ажиллах**: 1. Сурах бичгийн 42 дугаар хуудас дахь 1-12 дугаар сарын тунадасны хэмжээг харьцуулах 2. Тодорхой хугацаанд (сар болгон, эсвэл хоногийн аль нэг цагт гэх мэт) орсон тунадасны хэмжээг дүрсэлсэн график уншиж, асуултад хариулна. Жишээ нь: Хамгийн их тунадас хэзээ орсон бэ? гэх мэт. ***Багшийн анхаарах зүйл:*** *Температур ба тунадасны хэмжээг сар бүрээр юмуу тодорхой хугацаанд үзүүлсэн графикаас харьцуулах (өмнөх хичээлийн агуулгатай холбоход анхаарах).*	Ундааны том, жижиг хоосон сав (тунадас хэмжигч хийхэд хэрэглэнэ) Хуваарьтай шугам, Наадаг тууз, шугам Хайч, мм-ийн хуваарьтай цаас гэх мэт. *http://tsag-agaar.gov.mn/* Сурах бичиг
5.2к. Салхины зүг чиг, хүчийг хялбар аргаар тодорхойлон ялгааг тэмдэглэх	- Салхины чиг, хүчийг тодорхойлох туршилтын санааг гаргаж хэлэлцэнэ. Тодруулбал сурагчид салхины чигийг яаж мэдэх вэ? Юу ашиглах вэ, хэрхэн турших вэ? *(Савааа модны үзүүрт тууз уяад гадаа гарч хийсгэе...)*, юуг ажиглах вэ? *(Тууз аль зүгээс аль зүгрүү хийсч буйг ажиглая гэх мэт)* зэрэг асуултын хүрээнд ярилцаж болох юм.	Дарцаг, зүг чигийн тэмдэглэгээ, зурагт хуудас, бичлэг, цаг агаарын мэдээ *http://tsag-agaar.gov.mn/*

	- Салхины хүч ба зүг чигийг тодорхойлох туршилтын төлөвлөгөө *(цаг агаарын мэдээнд үндэслэн туршилт хийх хугацааг товлох, хаана, хэзээ, хэрхэн зохион байгуулах, туршилтын дараалаа тогтох, туршилтын үр дүнг тэмдэглэх хуудас бэлтгэх гэх мэт)* гаргаж, хэлэлцэнэ. - Хялбар аргаар салхины чиг болон хүчийг хэмжих туршилт хийнэ. Юмсын шинж байдлаар салхины хүчийг тодорхойлж болох юм. Жишээ нь: Яндангийн утааны чиглэл, дарцаг хийсэх гэх мэт. - Туршилтын үр дүнг тэмдэглэж зураглана. - Салхины зүг чиг, хүчийг хэмжих хялбар арга, аргын үр дүнг тайлбарлана.	
	Багшийн анхаарах зүйл: *Багш хичээлээ бэлдэхдээ цаг агаарын урьдчилсан мэдээг харсан байх шаардлагатай. Мөн сурагчдын туршилт хийх төлөвлөгөөгөө гаргах үед ирэх долоо хоногийн цаг агаарын мэдээг харуулж тохирох өдрийг хамтдаа сонгож болох юм.* *Дараах зургаас өдөртөө салхина зүг чиг хэрхэн өөрчлөгдөж буйг харах боломжтой.*  Эх сурвалж: *http://tsag-agaar.gov.mn/forecast/forecast3hours*	
5.2л. Дэлхий дээр өөр өөр уур амьсгалтай газар орон байдгийг байрлалтай нь холбож тайлбарлах	- Халуун, сэрүүн, хүйтэн орны хүн, амьтны зураг хуудас, бичлэг ажиглана. - Тухайн газар орныг дэлхийн бөмбөрцөг дээр зааж нэрлэнэ. - Дэлхий дээр халуун, сэрүүн, хүйтэн орон (уур амьсгалын үндсэн 3 ялгаа) хаана оршдогийг матрын ба мэлхийн зам, экватор зэрэг онцог зэргэдээр баримжаалан тодорхойлно. - Уур амьсгалын ялгаа үүсэх шалгааныг газар орны байрлалтай холбон тайлбарлана.	Халуун, сэрүүн, хүйтэн орны төрх байдлыг үзүүлсэн зургууд глобус, термометр халуун ба сэрүүн, хүйтэн орны хүмүүс, амьтдын зураг (цагаан баавгай, заан гэх мэт), халуун орны ой, туйлын мөсөн бүрхэвчийн зураг

Хөшүүрэг, хялбар механизм

Хөшүүрэг түүний тулах цэг, хөшүүргийн тэнцвэр, хөшүүргийн мөрийг ялган таних, хөшүүргээр хүчийг хувиргах аргад суралцах, хөшүүргийн тэнцвэрийн дүрэм нөхцөлийг мэдэх, жишээгээр тайлбарлаж мэдлэгээ гүнзгийрүүлнэ.

Бүлгийн нэр томьёо: Хөшүүрэг, үйлчлэх цэг, тулах цэг, тэнцвэрийн нөхцөл, хүч хувиргах, хөшүүргийн мөр

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
	- Хадаасны лоом, хаалганы бариул, хумсны хутга, хайч, бахь, цаас цоологч, ундааны бөглөө онгойлгогч гэх мэт хэрэгслүүдээс сонгож, хэрхэн ажиллаж байгааг ажиглана.	Зурагт танилцуулга Төрөл бүрийн хөшүүрэг ашигласан жишээ

5.2м. Өгсөн хэрэгслүүдээс хөшүүргийн зарчмаар ажилладгийг нь ялган таних, ажиллах зарчмын учрыг олох	- Ерөнхийлөн загварчлах, хөшүүргийн хялбар загварыг урт саваагаар төлөөлүүлэн гаргана. - Жишээ туршилтаас хөшүүргийн тулах цэг, хүн ба ачааны үйлчлэх цэг, хөшүүргийн мөрийг ялган нэрлэж, хариултаа үндэслэнэ. - Хөшүүрэг бүхий өгөгдсөн хэрэгслүүдийн хувьд тулах цэг ба хүчний үйлчлэх цэгүүдийг ялгаж тодруулна. Амьдрал ахуйд хэрэглэдэг хөшүүргийн жишээг гаргаж, хөшүүргийн ажиллах зарчмыг тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Ахуй амьдралын бодит жишээнээс шинжлэх ухааны хийсвэр загварыг гаргах нь эрэл хайлтын чухал хэсэг юм. Гэхдээ эсрэгээр хийсвэр загвараас бодит зүйлд шилжих зам байж болно. Хэт олон багажаас ижил шинжийг нь олох нь хэцүү байж болох юм. Харин нэг багажийг сайтар судалж гол шинжийг нь олох нь хялбар байх талтай. Багш бүтээлчээр хувилбартай хандаж, хөшүүргийн хэрэглээний талаар ярилцах, амьдрал техникээс хөшүүргийн жишээг бодитоор харуулахыг хичээгээрэй. Зураг, схемээр төлөөлүүлэн оромдож болохгүй шүү.*	Амьдрал дээрх жишээг харуулах бодит биет туршилтын хэрэглэгдэхүүн Сурах бичиг
5.2н. Хөшүүрэг (саваа мод) ашиглаж хүчийг ихэсгэж, багасгаж болохыг тодорхойлох	- Хүнд ачааг хялбархан хэрхэн өргөх санааг дэвшүүлнэ. - Турших ажлын төлөвлөгөө боловсруулж, туршилт хийн тэмдэглэл хөтөлнө. - Туршилтын үр дүнд үндэслэн харьцуулалт хийж (хаана нь дарахад хялбар байгаа эсэх гэх мэт), хэлэлцэнэ. - Хүчийг ихэсгэж багасгаж болохыг туршилтын үр дүнд үндэслэн тайлбарлах боломжтой. - Туршилтын хэрэглэгдэхүүнийхээ тулах цэг, хөшүүрэгт үйлчлэх хүч, хөшүүргийн мөрний хэмжээтэй холбож илэрхийлнэ. ***Багшийн анхаарах зүйл:*** *Энэхүү суралцахуйн зорилтын туршилтыг баг бүр хийх боломж хомс тул хэд хэдэн сурагчийг туршилтын даалгавар гүйцэтгэгчээр томилж, бусад сурагчдыг ажиглалт, тэмдэглэл хөтлүүлэх байдлаар зохион байгуулж болох юм. Ачааг өргөх оролдлого бүрийн дараа туршилт гүйцэтгэсэн сурагчийн мэдэрсэн зүйлийг асууж тэмдэглэхэд анхааралтай. Жишээлбэл өргөхөд хэцүү байна, арай амархан болж байна гэх мэт.* *Физикийн үүднээс хүч ямагт хосоороо илэрдэг. Хөшүүргийг хүн дарвал хөшүүрэг хүний гарт эсрэг чигт хүчээр үйлчилнэ. Хөшүүрэг ачааг өргөвөл эсрэгээр ачаа хөшүүргийг дарна. Иймд аль биед аль биеэс үйлчлэх хүчийг ярьж байгааг ялгаж тодорхой ярих нь чухал.*	Саваа мод, тэмдэглэгээ хийх өнгийн туузан хуулга, метр, ачаа, тулгуур гэх мэт, тэмдэглэл хөтлөх ажлын хуудас, зурагт хуудас, бичлэг, бодит кейс Сурах бичиг

5.2о. Хөшүүргийн (урт мөрт бага хүч оногддог) тэнцвэрийн зарчмыг тайлбарлах, жишээ гаргах	- Хөшүүрэг ямар үед тэнцвэртэй байх талаар таамаглал дэвшүүлэх. Тодорхой жишээ өгч ачааг хаана өлгөвөл хөшүүрэг тэнцэх талаар даалгавар өгч болно. - Таамаглалаа шалгах туршилтыг төлөвлөж, хэлэлцэнэ. Зүүн талд өлгөсөн ачааны тоо (хэмжээ), хөшүүргийн мөрний хэмжээ ба баруун талд өлгөсөн ачааны тоо (хэмжээ), хөшүүргийн мөрний хэмжээг ялгахад анхаарна. - Туршилт гүйцэтгэх, хөшүүргийн тэнцвэрийн нөхцлийг тодорхойлох боломжтой. Хөшүүргийн тэнцвэрийн нөхцөлийг ачааны тооны харьцаа, мөрний харьцаагаар; ачааны тоо ба мөрний үржвэрээр гэх мэтээр олон хувилбараар илэрхийлж болно. - Хөшүүргийн тэнцвэрийн зарчмын тайлбарлах ***Багшийн анхаарах зүйл:*** *Хөшүүргийг голчлон тодорхой үйл (ачаа өргөх, бөглөө онгойлгох, хадаас сугалах гэх мэт) хийхэд ашигладаг. Эндээс үйлийг хийж "чадах", "эсэх" гэсэн зааг гарч ирнэ.* *Энэ заагийг хөшүүргийн тэнцвэр илэрхийлдэг. Иймд хөшүүргийн тэнцвэрийн тухай ярьдаг гэдгийг санах.* *Туршилтыг гүйцэтгэж байгаа байдал, шинжлэх ухааны үг хэллэг хэрэглэж байгаа байдал, туршилтын үр дүнг хэрхэн зургаар дүрсэлж үгээр илэрхийлж байгаад анхаарч тэдний хөгжлийг дэмжинэ. 5-р ангийн STEM сургалтын зарим загваруудыг энэхүү хичээлтэй уялдуулж орох бүрэн боломжтой. Тухайлбал, өргөгч цамхаг, хавчигч бахь, жинлүүр гэх мэт. Загвар угсрах хичээлийг STEM сургалтын цагаар, угсарсны дараах хичээлийг байгалийн ухааны хичээлтэй уялдуулж болно.*	Төрөл бүрийн хөшүүргийн жишээг үзүүлэх багаж (жинлүүр, өмнөх хичээлийн туршилтын хэрэгсэл, зураг гэх мэт) Сурах бичиг

5.3. АМЬДРАЛ

Ургамлын амьдралын эргэлт

Энэ бүлэгт сурагчид ургамлын үржлийн талаар ойлгож, түүний амьдралын эргэлтийн үе шатуудыг судлах, ургамлын амьдралын эргэлтийг загварчлах замаар төсөөллөө хөгжүүлнэ.

Бүлгийн нэр томьёо: Ургамлын үржил, ургамлын ургал эрхтэн, тасалгааны ургамал, үр, үндэс, иш, навч, амьдралын эргэлт

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.3а. Ургамлын ургал эрхтнүүдийг ялган таних, нэрлэх	- Ургамлын гадаад бүтцийг ажиглаж эрхтнүүдийг зааж нэрлэнэ. - Ургамлын ургал эрхтний (навч, иш, үндэс) гадаад бүтцийг ажиглаж зурна. - Ургал эрхтний ялгаатай байдлыг харьцуулж (хэд хэдэн ургамлын навч гэх мэт) тайлбарлана.	Тасалгааны ургамал, загвар, бичлэг, ургамлын хатаадас, өнгийн харандаа, том цаас, томруулдаг шил

	Багшийн анхаарах зүйл: *Дээрх үйл ажиллагааг аль болох бодитоор, тасалгааны ургамал ашиглан гүйцэтгүүлэхэд анхааараарай. Мөн нэг ургамлын навч зурж байгаа хэрнээ сурагчид ялгаатай зурсан байвал хэлэлцүүлэг өрнүүлж ургамлын навчыг дахин ажиглуулж болох юм. Томруулдаг шил ашиглавал сурагчид илүү сонирхдог.*	
5.3б. Зарим тасалгааны ургамлыг ишээр үржүүлж, үр дүнг хүснэгтэд тэмдэглэх	- Ургамлыг үржүүлдэг аргуудыг ярилцана. - Ургамлыг үржүүлдэг аргуудаас ишээр үржүүлэх аргыг сонгоно. - Ургамлыг ишээр үржүүлэх аргыг судална. Үржүүлэх ургамлаа сонгож, судална. - Ургамлыг ишээр үржүүлэх туршилтын төлөвлөгөө боловсруулж (ургамлаа сонгох, ургамлын орчин, нөхцөл, аль ишиг зүсэхээ шийдэх, хаагуур нь зүсэх, яаж зүсэх, ажиглалт, тэмдэглэл хийх хугацаа, аргачлал гэх мэт) хэлэлцэнэ. - Ургамлыг ишээр үржүүлэх туршилт хийж, ажиглалт, хэмжилтийн үр дүнг зурж тэмдэглэл хөтөлнө. Ургамлын ишэнд зүсэлт хийхдээ аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.  - Туршилтын үр дүнг тайлбарлана. Ургамлыг ишээр үржүүлэхэд анхаарах асуудал, ургалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тайлбарлуулж болно. Туршилтын явц, үр дүнгээс жишээ татвал сайн. ***Багшийн анхаарах зүйл:*** *Туршилтад орох тасалгааны ургамлыг багш урьдчилан сонгож бэлтгэсэн байна. Ишээр үржүүлэхэд үндэс нь богино хугацаанд гардаг ургамал сонгох. Ургамлыг үржүүлэх аргыг амьдрал ахуйдаа зөв сонгон хэрэглэхэд сургана.*	Бодит ургамал, ургамал үржүүлэх сав, цаасны хутга, ус (хоносон ус байх) ишээр үржүүлэх аргын тухай мэдээлэл, хаягийн цаас, утас, ажиглалтын тэмдэглэл хөтлөх хуудас, хэмжилт хийх шугам гэх мэт

5.3в. Ургамлыг үрээр үржүүлэх аргыг туршиж, үр дүнг хэлэлцэх

- Ургамлыг үрээр үржүүлэх аргыг (ямар ургамлыг энэ аргаар үржүүлж болдог, анхаарах гол зүйл гэх мэт) судална.
- Ургамлыг үрээр үржүүлэх туршилтын төлөвлөгөө боловсруулж (үрээ сонгох, үрийн ургах орчин, ажиглалт хийх хугацаа, үр дүнг зурах, тэмдэглэл хөтлөх хуудас боловсруулах, аргачлал гэх мэт), хэлэлцэнэ.

  Үр суулгах энгийн аргаас ...



- Сонгосон ургамлын үрээ суулгах, ажиглалт хэмжилт хийж тэмдэглэл хөтөлнө. Хэмжихдээ ургамлын үндэс, иш (өндөр), навчыг тус бүр хэмжинэ.

Ажлын хуудасны санаа:

Өдөр 1 (сар ... өдөр ...)	Өдөр 2 (сар ... өдөр ...)	Өдөр ... (сар ... өдөр ...)
Зураг	Зураг	Зураг
Үр ... см ... ... см	Үндэс ... см Иш ... см Навч ... см ... ... см	Үндэс ... см Иш ... см Навч ... см ... ... см
Тэмдэглэл	Тэмдэглэл	Тэмдэглэл

- Туршилтын үр дүнг зураг болон бичвэр, диаграммаар илэрхийлж болно.
- Ялгаатай үр дүнг харьцуулж туршилтын үр дүнг тайлбарлана. Ургамлыг үрээр үржүүлэхэд анхаарах асуудал, ургалтад нөлөөлж буй хүчин зүйлсийг хэлэлцэнэ.

Багшийн анхаарах зүйл:
Туршилтад ашиглах үрийг урьдчилан бэлтгэж багш өөрөө туршсан байх шаардлагатай. Тиймд богино хугацаанд соёолдог (вандуй, наранцэцэг ...) үрийг сонгоорой.

Ургамлын үр, үр суулгах сав, гялгар уут, хүнсний скоч, хөвөн, хөрс үрээр ургамлыг үржүүлэх аргын тухай мэдээлэл, бичлэг, хаягийн цаас, туршилтын явц, үр дүнг тэмдэглэх, утас, зурах хуудас, хэмжилт хийх гэх мэт

Сурах бичиг

	 Үрийг заавал тусгай саванд ургуулах шаардлагагүй ба эхний ээлжинд цаасан алчуурт чийг өгч үрээ тавиад, жижиг гялгар уутанд хийж болно. Цаасан алчуур сонгодгийн учир нь үр соёолсны дараа ургамлаа усанд булхуулж цаасан алчуурыг үндэснээс хялбархан салгаж болно. Хөвөн ашиглавал хөвөнг үндэснээс салгахад бэрх болно. Мөн туршилтын үр суулгасан хугацаа, хариуцсан сурагчийн нэр, арчилгааны төлөвлөгөө гэх мэт дэлгэрэнгүй хаяг хийхэд анхаараарай.	
5.3г. Үрээр болон ишээр үржүүлж буй ургамлаар жишээлэн ургамлын амьдралын эргэлтийг хэсэгчлэн зураглах	- 5.3б, в суралцахуйн зорилтын хүрээнд хийгдсэн туршилтын үр дүнд үндэслэн ургамлын амьдралын эргэлтийг загварчлан зурна. - Загвар зургаа ургамлын амьдралын эргэлтийг харуулсан зурагтай харьцуулан ажиглана. - Ургамлын амьдралын эргэлтийн үе шатуудыг нэрлэж, зураг дээр заана. - Ургамлын амьдралын эргэлтийг жишээгээр тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурах бичгийн 77-р хуудас дахь цэцэгт ургамлын амьдралын эргэлтийг ажиглуулбал ургамлын тоос хүртэх үеэс үр жимс боловсрох үеийг сурагчид туршаагүй тул нарийн тайлбарлах шаардлагагүй ба суурь боловсролын түвшинд судлах юм. Харин төрөл бүрийн жимсний үрийг харуулж болно.*	Ургамлын амьдралын эргэлтийг харуулсан үзүүлэн, үе шатуудыг харуулсан зурган карт, өмнөх хичээлүүдэд хийсэн туршилтын үр дүнгийн зураглал Сурах бичиг

Амьтдын үржил, хөгжил

Сурагчид амьд амьтан үр төлөө гарган үржиж тоо толгой нь нэмэгддэг, хүн хүүхэд төрүүлэн үр удмаа үлдээдэг тухай ойлголттой болно. Суралцагчид төрөл бүрийн амьтны амьдралын эргэлтийн талаар таамаглах, үе шатуудыг нэрлэх, хөгжлийн үеүдийн дараалыг мэдэх, тэдгээрийн онцлогийг тайлбарлах, амьтны амьдралын төстэй ба ялгаатай байдлыг мэдэх, зураг схем дээр зааж, тайлбарлах, туршилт хийх, хэмжих, дүгнэлт гаргах, тайлбарлах зэрэг чадварыг эзэмшинэ.

Бүлгийн нэр томьёо: Өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцсэн шавж , өндөг төрүүлэгч бүрэн ба бүрэн бус хувирал, шавж, эрвээхэй, царцаа, загас, мэлхий, тахиа, амьд зулзага төрүүлэгч, ураг, өсөлт, хүйс, үр төл амьдралын эргэлт, хөгжлийн үе шат, хоол тэжээл, үржил

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.3д. Шавж ба аалз ялгаатай болохыг зарим онцлог шинжид нь үндэслэн ялган таних	- Зурагт үзүүлсэн амьтдын ижил болон ялгаатай шинжийг ажиглана.  Өөрийн орон нутагт элбэг байдаг амьтад ч байж болох юм. - Ажигласан зүйлээ дэвтэртээ бичнэ. Ижил тал | Ялгаатай тал Ажигласан зүйлээ дэвтэртээ бичих хугацааг багш сурагчдадаа олгох хэрэгтэй. Сурагчийн дэвтэрт үлдсэн тэрхүү бичвэрээс бид сурагч ажиглаж чадаж байна уу үгүй юу гэдгийг олж харах боломж бүрдэнэ. - Ажиглалтын үр дүнг ангиараа нэгтгэн хэлэлцэнэ - Зааварт тусгаагүй зүйлийг ажигласан үр дүнг (нисдэг, нисдэггүй, амьдрах орчин өөр гэх мэт) хасна. - Амьтдыг ялгаатай шинжид нь (хөлийн тоо) үндэслэн ангилж тэдгээр амьтдаас зөвхөн шавжийг ялгана. - Ялгасан амьтдаа ажиглаж, шавжийг хэрхэн таньж болохыг судалж, өөрсдийн шавж гэж үзсэн амьдыг дахин ажиглана. - Хэдэн хөлтэй амьтан нь шавж болохыг багш таниулна. Шавжийн тухай мэдээлэл ашиглаж болох юм. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчдын ажиглах зурагт эрвээхэй, царцаа, хавч хэлбэртэн, бүүрэг, аалз, цох гэх мэт амьтдыг оруулах. Учир нь эдгээр амьтдыг ихэнх сурагчид бүгд шавж гэж андуурдаг.* ***Мэдээлэл:*** *Эдгээр амьтад бүгд үет хөлний хүрээнд хамаарах хэдий ч энэ хүрээнд хамаарах гурван ангид хуваагддаг. Аалз хэлбэртэн, хавч хэлбэртэн, шавжийн ангид тус тус хамаарна. Амьтдын хөл нь бүгд үетэй байдаг тул тэрхүү ижил шинжээр нь үет хөлтний хүрээнд хамааруулдаг Харин хөлийн тоогоороо ялгаатай тул энэ шинжид нь үндэслэн дээрх 3 ангид хуваадаг. Аалз хэлбэртэн-4 хос буюу 8 хөлтэй, хавч хэлбэртэн-5 хос буюу 10 хөлтэй, шавж-3 хос буюу 6 хөлтэй байдаг.*	Үет хөлтний хүрээний амьдын төлөөлөл бүхий зурагт хуудас, слайд, маркер, боломжтой бол бодит амьтад сонгох

	Сурагчид 2 өөр хэсэгт ангилсан амьтдыг ч шавж гэж үзэж магадгүй. Энэ нь багшийн хувьд хичээлээ цааш хөтлөн явуулахад дэвшүүлэх нэг асуудал болно. Учир нь нэг бүлэгт хамаарч буй амьтад ямар нэг шинжээрээ ижил байх учиртай. Энэхүү хичээл нь онолын мэдлэгээс гадна сурагчдын ажиглах чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах тул сурагчдын гаргаж буй алдааг тухай бүр шууд засахгүйгээр ялгаатай үр дүнг хэлэлцэх замаар шинжлэх ухааны ойлголттой болгоход анхааараарай. Мөн тус суралцахуйн зорилтын онцлог нь сурагчийн ажиглах чадварыг хөгжүүлэхэд оршино.	
5.3е. Бүрэн ба бүрэн бус хувиралтай шавжийн амьдралын эргэлтийг бүдүүвч ашиглан харьцуулах	- Бүрэн хувиралтай шавж буюу эрвээхэйн амьдралын эргэлтийг судлахын тулд байцааны эрвээхэйн амьдралын өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцсэн гэсэн үеүдийг ажиглаж нэрлэнэ. - Бүрэн бус хувиралтай шавж буюу царцааны амьдралын эргэлтийг зурагт үзүүлэн дээр тайлбарлана. Царцааны амьдралын эргэлт: Өндөг-авгалдай- бие гүйцсэн шавж - Царцаа болон эрвээхийн амьдралын эргэлтийг харьцуулан ажиглана. - Амьдралын эргэлтийн ялгааг гаргах, бүрэн ба бүрэн бус хувиралтай шавжийг тодорхойлно. ***Багшийн анхаарах зүйл:*** *“Амьтдын амьдралын эргэлтийг судлах” гэсэн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд сурагчид харилцан ярилцах, ажиглах, турших, харьцуулах, дүгнэх замаар мэдлэг бүтээнэ. Иймээс суралцагчдын өмнөх мэдлэгт тулгуурлан асуудал дэвшүүлэн амьтдын үржил хөгжлийн үеийн онцлогийг тайлбарлах, ялгаатай байдлыг олуулах, дүгнэлт гаргуулах, тайлбарлуулах зорилгоор хичээлийн хэрэглэгдэхүүнээ бэлтгэх.* *Бүрэн хувиралтай шавжийн амьдралын эргэлтийн талаар туршилт хийн ойлгуулж болох ч хөгжлийн үе шатыг харуулах туршилт нь цаг хугацааны хувьд харьцангуй урт байх тул багшаас урьдчилсан бэлтгэл зайлшгүй шаардана. Ногооны талбайгаас байцааны эрвээхэйн хөгжлийн үе шатыг харуулж болохуйц өндөг, авгалдай хүүхэлдэйг цуглуулан бэлдэх ба эрвээхэйн хатаадсыг ашиглах хэрэгтэй болно.* *Ажиглалт, судалгааг хийхдээ нарийн төлөвлөж хэрхэн яаж ажиглалт хийх аргачлал, ажиглалтын тэмдэглэлийг хэрхэн бичих болон багаж хэрэгсэл хүүхэд бүрт хүртээмжтэй эсэхийг нягтлах шаардлагатай.*	Эрвээхэй, царцааны амьдралын эргэлтийг харуулсан бүдүүвч зураг, бичлэг. Хэрэв туршилт хийх хувилбарыг сонгосон бол нүхэлсэн таглаа бүхий хуванцар сав, жижиг хэмжээтэй цэвэр цаас, эрвээхэйн өндөг бүхий байцааны навч, шугам, өсгөгч шил, зургийн аппарат
5.3ж. Өндөглөгч амьтдын үржлийн онцлог, амьдралын эргэлтийг загварчлан тайлбарлах	- Мэлхийн амьдралын эргэлтийг бичлэг үзэж, схем дээр тайлбарлана. - Шувууны амьдралын эргэлтийн талаар мэдээлэл цуглуулж өндөг-ангаахай-дэгдээхэй-бие гүйцсэн амьтан гэсэн хөгжлийн үеийг тайлбарлана. Үр төлөө хамгаалан арчилж өсгөх зөн совингийн талаар нэмэлт мэдээллийг сурагчдад өгч болох юм. - Амьтдын (загас, мэлхий, шувуу) үржил хөгжлийн онцлогийг үр тогтох орчин, гаргах үр төлийн тоо хэмжээ, гаргах өндөгний хэмжээ үр төлөө өсгөх хамгаалах зохилдолгоог харьцуулан тайлбарлана.	Загас, мэлхий, шувууны амьдралын эргэлтийн үе шатуудыг харуулсан зураг, шувууны өндөг, нэг удаагийн таваг, хутга бичлэг үзүүлэх багшийн номд зааж өгсөн.

	Багшийн анхаарах зүйл: *Хичээлийг багаар зохион байгуулах үед багийн дотоод зохион байгуулалтыг онцгой анхаарч багийн гишүүн бүрийн үүргийг сурагчдаар өөрсдөөр нь гаргуулахад анхаарах.* *Хичээлд өндөглөдөг амьд биеийн амьдралын эргэлтийг харуулсан дүрс бичлэгийг ашиглаж болно.* *Мөн багш өндөглөгч амьтдын өндөгний бодит хэмжээгээр хэрэглэгдэхүүн бэлтгэвэл хичээл улам сонирхолтой болно.*	
5.3з. Амьд үр төл төрүүлэгч амьтдын үржил хөгжлийн онцлогийг харьцуулан тайлбарлах	- Өгсөн амьтдаас амьд зулзага төрүүлдэг амьтдыг ялгана. - Хөхтөн амьтдын амьдралын хөгжлийг зураг, бичлэгээс ажиглаж тэмдэглэл хөтөлнө. - Амьтдын үр төлийн ялгаатай байдлыг ярилцана. Ярихдаа үр төлөө тээх хугацаа, хэрхэн ямар орчинд төрүүлдэг, яагаад гэх мэт ялгаа болон онцлогийг харьцуулан тайлбарлана. ***Багшийн анхаарах зүйл:*** *Сурагчдын хамгийн сайн мэдэх амьд зулзага төрүүлдэг амьтдыг жишээ болгон авч шинжлэн судлах үйлийг төлөвлөөрэй. Сурагчдын ялгаатай байдлыг харгалзан үзэж хичээлийг төлөвлөх хэрэгтэй. Хөдөө мал төллөх явцыг ажигласан сурагчдаар яриулах, хотын сурагчдад аквариумын загасны үржил хөгжлийг ажиглуулж зарим онцлог шинжийг ялган таних, амьтдын үр төлийн ялгаатай байдлын талаар ярилцуулахад анхаарах нь зүйтэй.*	Бичлэг, зураг Сурах бичиг
5.3и. Хүний төрөхийн өмнөх ба төрсний дараах өсөлт, хөгжлийг харьцуулах	- Хүний амьдралын үе шатуудыг харуулсан зураг ажиглаж, судлахыг хүссэн үеийг сонгоно. - Хүний үр хөврөл, ургийн хөгжлийг зураг, бичлэгээс ажиглаж, сонирхсон зүйлээ асууна. - Хэвлийд хүүхэд бойжих үе шатанд гардаг томоохон өөрчлөлтүүдийг судлах төлөвлөгөө гаргана. - Төлөвлөгөөний дагуу сурвалжлага ярилцлага хийнэ /нярай хүүхэдтэй ээж, эцэг, эхийн төлөөлөл байж болно, эх барих эмэгтэйчүүдийн эмч гэх мэт/. - Эхийн хэвлийд хүүхэд өсч торних үйл явцыг үзүүлэн, загвараас тайлбарлана. - Эхээс төрсний дараах өсөлт хөгжлийг онцлогийг судлах, хөгжлийн ялгааг (нярай, бага, өсвөр) харьцуулах - Хүний төрөхийн өмнөх ба төрсний дараах үед гарах гол ялгааг харьцуулан ярилцах. ***Багшийн анхаарах зүйл:*** *Шинж тэмдэг эцэг эхээс үр төлд удамшдаг анхны ойлголт төсөөллийг хүний үржил хөгжил буюу үр төлөөр дамжуулан ойлгуулна. Тухайлбал:* - *Хүнээс зөвхөн хүүхэд, нохойноос гөлөг, ямаанаас ишиг төрнө гэх мэт зүйлийн шинж хадгалагдах зүй тогтол* - *Чи аав, ээжийнхээ хэнтэй нь адилхан бэ? гэх мэт асуулт асууж хичээлийн агуулгыг сонирхолтойгоор баяжуулж болох юм.* - *Хүүхэд эхийн хэвлийд яаж хөгжих вэ? Чи хэдэн настай вэ? зэрэг сонирхолтой асуулт асууж монголчуудын би 6 настай, хий настайгаа 7 настай гэж хариулдгийн учрыг эхийн хэвлий дэх ургийн хөгжилтэй холбон ойлгуулах гэх мэт* - *Суралцагчдын ойлгох чадвар, тайлбарлан ярих чадвар харилцан адилгүй байгааг харгалзан үзэж ялгаатай даалгавраар хүүхэд бүрт хүрч ажиллах боломжтой.*	Ургийн хөгжлийн 3 үе шатны зураг, бичлэг, муляж, зурагт хуудас, 3 үе тус бүр дэх мэдээлэл, ээжүүдийн яриа, эмчийн яриа эх мэт Сурах бичиг

ХҮН БА НИЙГЭМ

IV-V анги

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ

Удиртгал

Энэхүү суралцахуйн удирдамж нь “Хүн ба нийгэм” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн төлөвлөлт юм.

Тус суралцахуйн удирдамжид “Хүн ба нийгэм” сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэхийг суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, багшид зөвлөмж гэсэн хэсэгтэйгээр төлөвлөн боловсруулсан бөгөөд сурагч болон багшид суралцахуй хийгээд багшлахуйгаа төлөвлөхөд дэмжлэг, туслалцаа болно.

Мөн бүлэг бүрийн суралцахуйн зорилтуудыг агуулгыг нь нягтруулах, цомхотгох, багш төлөвлөх, гүйцэтгэлийг нь үнэлэхэд дөхөм болгох үүднээс жишээ нь, 4 дүгээр ангийн 1 дүгээр хам сэдвийн 1 дүгээр суралцахуйн зорилтыг 4.1а., 2 дугаар суралцахуйн зорилтыг 4.1б. гэх мэт кодолсон. Кодын 4 нь ангийн дугаар, бусад нь суралцахуйн зорилтын дугаар юм.

Суралцахуйн зорилт бүрийн хүрээнд суралцахуйн үйл ажиллагааг санал болгосон нь жишиг гэдгийг анхаарч, багш нар өөрсдөө, сурагчдынхаа хэрэгцээ, туршлага, чадвар, хандлагыг харгалзан бүтээлчээр хөгжүүлэх боломжтой юм.

4.1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.1а Гэр бүлийн орчинд өөрийн бодол санаа, хүсэлтээ илэрхийлэн харилцах	-Гэр бүлийнхэндээ өөрийн бодол, хүсэлтээ илэрхийлэн хариулт авах зорилго бүхий асуултуудыг тавина. Жишээ нь: Зуны амралтын хугацаанд ямар түүхэн дурсгалт газартай танилцах вэ? Манай гэр бүлийн хамгийн үнэ цэнэтэй 3 хүртэлх зүйл юу вэ? Миний бодол санааг та мэдэх үү? Миний нэг хүслийг биелүүлнэ гэвэл та зөвшөөрөх үү? г.м. -Гэр бүлийн гишүүд, хэн хэн болох, тэдний үүрэг, оролцоо, хувь нэмэр ямар байдгийг өөрийн гэр бүлийн амьдралын жишээгээр тайлбарлана. -Гэр бүлийн гишүүд, тэдний үүрэг, оролцоо, хувь нэмэр зэрэг үг хэллэг, ойлголтуудыг жагсаан бичиж, товч тайлбар толь хөтөлнө.	-Сурах бичиг дэх тохиолдол - “Хөдөөгийн баясгалан,” “Сайн аав” зэрэг киноны тухайн сэдэвт холбогдох хэсгээс үзүүлж болно.
4.1б Сургууль, анги дахь өөрийн оролцоог тодорхойлох	-Сургууль, ангийнхаа үйл ажиллагаанд сурагч ямар, ямар хэлбэрээр оролцох талаар багаар ярилцана. Жишээ нь, сурагч бүр сургууль, ангийн хамт олны үйл ажиллагаанд хэрхэн оролцох төлөвлөгөө боловсруулна. -Аливаа үйл явдалд оролцсоноор юу сурч, мэдсэн хэрхэн ахисан тухайгаа эргэцүүлэн бичнэ. -Сургуульд ямар дугуйлан, секц, клуб, номын сан, интернэт болон сурагчдын байгууллага, заах аргын нэгдэл ажилладагийг мэдэж, тэдгээр дэх өөрийн оролцооны арга, хэлбэрүүдийг (хувийн, нийтийн г.м.) тодорхойлно.	-Үүрэг, амлалт, оролцоог хэрхэн ялган, танихыг харуулсан зурагт хуудас - Суралцахуйн зорилт 1-ийн хүрээнд мэдлэг, ойлголт, чадварыг үнэлэх ажлын хуудас

Багшийн анхаарах зүйл:
Сурагч өөрийгөө гэр бүлийн, сургууль болон анги, хамт олны гишүүн гэдгээ мэдэрч аливаа үйл ажиллагаанд идвэхтэй оролцоноор хөгжих, төлөвших боломжтойг ойлгуулах, багаар хамтран суралцахад нь үйл ажиллагааг чиглүүлнэ. Сурагч бүрийн идэвх, оролцоог хангах, хянах цагаан самбар болон 2 од, 1 хүсэл ажлын хуудас зэрэг явцын ба үр дүнгийн үнэлгээний арга хэрэгслийг ашиглахын зэрэгцээ сурагчийн өөрийн үнэлгээг чухалчлаарай. Сурагч өөрийн бодол санал, оролцоо, хувь нэмрийн талаар сурагчдын нас, сэтгэхүйн түвшинд тохирсон жишээ баримт, тохиолдол шинжлэх, асуулт тавих, хариулах, ярилцах зэрэг бүтээлчээр суралцах аргуудыг эзэмшихэд анхаарч, чиглүүлж ажиллаарай. Энэ ангийн сурагчдыг идвэхтэй оролцоотой, өөрийн бодол санаа, байр суурыа чөлөөтэй илэрхийлдэг, бусдад тусалдаг, хамтран ажилладаг, өөрөөр хэлбэл, зөв хандлага, зан үйлтэй, өөрийн гэх үнэт зүйлтэй болоход нь багш нар ихээхэн анхаарах хэрэгтэй. Жишээ нь, сурагч сургууль, анги дахь өөрийн оролцоог тодорхойлохын тулд оролцоо гэж юу болох, түүний ач тусын талаар ойлгож, ухамсарлах, хариу үйлдэл үзүүлэх (ханын сонин гаргахын ач тусыг ойлгож, зөвшөөрч, гаргахад оролцох), уг ажлыг зохион байгуулалцах, сонины зураг чимэглэл хийхийг онцгойлон сонирхох, зан үйл болгох гэсэн үе шатуудаар тухайн сурагчийн оролцоо төлөвшиж, хувь нэмрээ оруулах юм.

4.2. Нутгийн хүмүүс, нийгэм, аж ахуй, соёлын амьдрал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.2а Нутгийн хүмүүсийн ахуй, амьдралын онцлог, соёлын талаар тайлбарлах	-Нутгийнхаа байрлалыг газрын зурагт зөв зааж, хиллэдэг газруудыг нэрлэнэ. -Нутгийн хүмүүсийн ахуй, амьдралын өвөрмөц онцлог, бусдаас ялгаатай байдалтай холбогдох тохиолдол шинжилнэ. -Нутгийн хүмүүсийн соёлд багтах зүйлүүдийг музей үзэх, хууч яриа сонсох, домог, түүх унших зэргээр хамтран судлаж, “Манай нутгийн түүх, соёл” бүтээлийн сан хийж, ярилцана. Гэр бүлийн соёлын дурсгалт зүйлийн талаар гэр бүлийнхэнтэйгээ хамтран мэдээлэл бэлтгэж, танилцуулна. -Нутгийнхаа соёлыг судлах аяллын зураглал гаргаж, хэлэлцэнэ.	-Өөрийн нутгийн газрын зураг -Нутгийн түүх, соёлын дурсгалт газруудын лавлах, танилцуулга -Нутгийн ёс заншлын холбогдолтой зураг, домог, хууч ярианы цуглуулга
4.2б Нутгийн аж ахуй, үйлдвэрлэлийн газруудын үйл ажиллагааны ялгааг мэдэж, бүдүүвчээр харуулах	-Орон нутгийнхаа үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас нэгийг сонгон байршил, үйл ажиллагааны чиглэл, ялгааг илэрхийлсэн танилцуулга бэлтгэж, ярилцана. -Нутгийн аж ахуй, үйлдвэрлэлийн газруудын үйл ажиллагааны ялгааг харуулсан бүдүүвч зохиож, давуу болон сул талыг тайлбарлана.	-Үйлдвэрлэл, соёл, үйлчилгээний байгууллагуудаас сурвалжилсан мэдээлэл, танилцуулга
4.2в Нутгийн соёлын болон үйлчилгээний газруудын үүрэг, үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, нэгтгэн танилцуулах	-Нутгийн соёл, үйлчилгээний газруудын үүрэг, үйл ажиллагаатай танилцаж, тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл цуглуулна. -Цуглуулсан мэдээллээ тухайн газруудын үйл ажиллагааны чиглэлээр ангилж, чиглэл бүрийн мэдээлэлд өөрийн төвшинд боловсруулалт хийж, танилцуулна.	
4.2г Сурагч нутгийнхаа нийгмийн амьдралд өөрийн хувь нэмэр оруулах	-“Нутгийн амьдрал дахь миний хувь нэмэр" сэдвээр эргэцүүлэмж бичин, хосоор ярилцаж, өөрийн үнэлэлт өгнө. -Хамтын ажиллагаа болон орон нутгийн тэмдэглэлт үйл явдалд өөрийн оруулах хувь нэмрийг жагсаан бичнэ. -Сурагчид нутгийнхаа нийгмийн чиглэлийн өөр өөр үйл ажиллагаанд оролцох замаар орон нутгаа хөгжүүлэхэд оруулах хувь нэмрийг зураглалаар харуулж, ярилцана.	-Хүүхдийн бүтээлч бүлгэм, сайн дурын байгууллагын тухай мэдээлэл

Багшийн анхаарах зүйл:
Багш үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллаг (газар)-ын ялгааг орон нутгийн байгууллагын жишээгээр тайлбарлах. Сурагчдыг эдгээр байгууллагатай танилцуулах, хүмүүстэй ярилцлага хийлгүүлэх зэргээр оролцоог нь хангахад суралцахуйг чиглүүлнэ үү. Нутгийн үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг харуулсан бичлэг, кино үзүүлэн ярилцах, зочинтой хичээл зохион байгуулах зэрэг арга зүйн санааг зөвлөж байна. Үнэлгээний хувьд: Сурагч бүрийн идэвх, оролцоо болон судалж буй хам сэдвийн хүрээнд ойлголт, нэр томьёог жишээгээр тайлбарлах, мөн багаар ажиллах зэрэг чадварыг явцын болон өөрийн үнэлгээний хуудас, бусад арга хэрэгслээр үнэлэхэд анхаараарай. Хүн ба нийгэм хичээл 7 хоногт 1 цагаар орно. 1-2 улиралд эхний 1-2 дахь хам сэдвийн хүрээнд, 3-4 улиралд 3 дахь хам сэдвийн хүрээнд хичээлүүдээ төлөвлөж ажиллавал агуулгын залгамж чанар, уялдаа холбоог улам хангана. Тухайн хам сэдвийн хүрээнд сурагчдын мэдлэг, ойлголтыг өргөжүүлэх, явцын болон үр дүнгийн үнэлгээг оновчтой хийхэд анхаараарай.

4.3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх үүрэг, хариуцлага

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
4.3а Хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох	-Сургууль, хамт олны дундуус жишээ авч хувь хүний хүлээх үүрэг, хариуцлагыг илэрхийлэн, дүрийн тоглолтоор харуулж болно. -Хүмүүсийн үзэл бодол, мэдлэг чадвар, авьяас өөр өөр байдаг тухай ойлголтой болоход чиглэсэн асуултуудаар ярилцана. Үүнд: -Хичээлийн хуваарийг бусдаас хамааралгүй ялгадаг, ангийн жижүүрийн хуваарийг багшийн оролцоогүй гаргадаг, хийдэг байх зэрэг өөрийн оролцооны хэлбэрийг жишээ болгон ярилцаж, өөрөө болон үе тэнгийнхний хийж хэвших зүйлүүдийн жагсаалт гаргана. -Өөрийн сайн, сайхан чанарыг мэдэж, хүмүүстэй хэрхэн харилцах аргад суралцах -Сурагчид нийгмийн сайн сайхан тусын тулд өөрийн оролцооны жишээ гаргаж, тайлбарлана.	-“Цасан гоо ба 7 одой” киноны хэсгээс үзүүлж болно -Өөрийн давуу талыг мэдүүлэх “Энэ бол би тоглоом” -Хүний эерэг, сөрөг харилцаа, хандлагыг тодорхойлох тохиолдол бүхий ажлын хуудас
4.3б Хүмүүсийн харилцаа, хамтын амьдралыг ойлгох, тайлбарлах	-Сургуулийн болон ангийн дүрэм боловсруулах, мөрдөхийн ач холбогдлыг ярилцана. -Хүмүүстэй харилцахдаа (номын санд суух, нийтийн тээврээр зорчих) баримтлах дүрэм зохиож, ангийхандаа танилцуулна. -“Харилцаж, хамтран ажиллаж, бие биедээ тусладаг хүмүүсийн нэгдлийг нийгэм хэмээнэ” гэсэн энгийн ойлголтыг сурагчдад сурах бичгийн дасгал, даалгавар ажиллуулах,жишээ баримт дээр тулгуурлан замаар, харилцан ярилцах, ойлголтоо нэгтгэх зэргээр эзэмшүүлнэ.	Хүмүүсийн хамтын амьдралын тухай киноны хэсэглэл, дүрс бичлэг Хүмүүсийн харилцаа, хамтын ажиллагааг харуулсан дүрийн тоглолтыг сурагчид хийж болно. (жишээ, баримт)
4.3в Сурагч өөртөө үүрэг, хариуцлага хүлээхийг ойлгох, биелүүлэх	-Хувь хүн өөртөө ямар үүрэг хүлээх, үүргээ хэрхэн биелүүлэхийн ач холбогдлыг ойлгуулах жишээ тохиолдол шинжилнэ. -Хариуцлагатай хүүхэд гэж хэн бэ? Би мөн үү? асуултаар ярилцлага хийнэ. Ярилцлагын явцад асуудлыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаас суралцана. -Сурагчийн хүлээх үүрэг, хариуцлага гэж юу болох, түүнийг хэрхэн биелүүлэх талаар ангид хэлэлцүүлэг зохион байгуулна.	Үүрэг амлалтаа бүрэн биелүүлдэг сурагчийн үзэл бодол болон эс биелүүлэхийн хор уршгийг харуулсан бичвэр, зурагт хуудас

4.3г Өөрийн нийгэм, соёлын орчны талаар ойлгох, үнэлэлт өгөх	-Сургуулийнхаа түүхтэй танилцаж, холбогдох мэдээлэл бэлтгэнэ. -Нийгэм, соёлын орчинд сурагчийн ойрын хүрээлэл, найз нөхөд, ангийн хамт олноос эхлээд багш, ажилчдын хамт олон, номын сан, цахим мэдээллийн танхим, багш, сурагчийн бүтээлүүд зэрэг багтахыг тодруулж, ярилцана. -Сурагчид "Миний амьдрал, соёлын орчин" сэдэвт зураг зурж, түүнд юу юу дүрсэлсэн талаар ярилцана. -Сурагчид нийгэм, соёлын орчин хүмүүст хэрхэн нөлөөлдөг талаар сэтгэгдлээ бичиж, харилцан санал солилцоно.	Зурагт үзүүлэн Даалгаврын хуудас
4.3д Өөрийн аюулгүй байдлыг хангах талаар мэдэх, шийдвэр гаргах	-Өөрийн оршин суугаа үйлдвэр, үйлчилгээний газруудын аюулгүй байдлыг хангах дүрэм журамтай танилцана. -Аюулгүй байдлаа хангах гэж юу болох, эрсдэлгүй орчин гэж юу вэ? Үүнд хувь хүний оролцоо ямар байх талаар ярилцаж, дүгнэлт гаргана. Өөрийн аюулгүй байдлаа хангах, хамгаалах энгийн аргуудыг жагсаан бичиж, тайлбарлана. -Гэр бүлийн болон ангийн орчинд хүүхдэд аюултай, эрсдэлтэй ямар зүйл байгааг тоочиж, аюулгүй болгох талаар санал, шийдвэр гаргана. -Үдийн цайны эрүүл, ахуйн шаардлага,түүн дэх өөрийн оролцоог илэрхийлсэн дүрийн тоглолт хийнэ. -Нийгмийн болон байгалийн давагдашгүй хүчин гэж юу болох талаар мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийнэ. Хэрхэн урьдчилан сэргийлж болдгийг харуулсан танилцуулга, мэдээлэл боловсруулж гаргана.	Сурагч хувь хүний аюулгүй байдлыг хангах, хамгаалах ойлголтыг илэрхийлсэн бүдүүвч, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай санамж

Багшийн анхаарах зүйл:

"Хүмүүсийн хамтын амьдрал, эрх, үүрэг, харилцаа" хам сэдвийн хүрээн дэх эдгээр суралцахуйн зорилтууд нь сурагчид хүмүүсийн хамтын амьдрал, харилцаа, нийгэм, соёлын талаар анхны ойлголттой болох, тэдгээрт сурагч бүр идэвхтэй оролцох, өөртөө үүрэг, хариуцлага хүлээн биелүүлэх мэдлэг, хандлага төлөвшихэд чиглэсэн тул тэдний сайн төсөөлөх жишээ баримт, тохиолдолд тулгуурлаж, холбогдох ойлголтуудыг цэгцлэж өгөхөд анхаарч ажиллаарай. Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах энгийн аргуудад хэрхэн суралцаж буйд багш анхаарлаа хандуулахын зэрэгцээ сурагчдын өөрийн үнэлгээ, мэдлэгээ хэрэглээ болгон, хэрхэн ашиглаж байгааг ажиглаж, үнэлэхийг чухалчилна уу.

Ер нь үнэлгээ бол сурагч хэрхэн суралцаж байгаа, ямар мэдлэг,чадварыг амжилттай эзэмшиж байгаа, юун дээр алдаж байгаа болон багш заах арга, багшлахуйгаа хэрхэн боловсронгуй болгох, дээшлүүлэх талаар мэдээлэл олж авах, багш, сурагч мэдээлллээ харилцан солилцох, улмаар хамтран суралцахуйгаа сайжруулахад чиглэсэн үйл явц юм. Үнэлгээний арга нь суралцахуйн цогц зорилтын хэрэгжилтийг илрүүлэхүйц байх ба мөн хэд хэдэн аргыг шүтэлцүүлэн хэрэглэх нь багшийн үнэлгээний үндэслэлтэй байдлыг илүү нотлон харуулдаг. Жишээ нь, зөв хариултыг сонгох даалгавар нь тухайн сурагчийн сэргээн санах, мэдлэг, баримтыг таних, ялгах чадварыг хэмжиж байгаа бол эргэцүүлэл бичүүлэх нь тогтоосон хугацаанд бодол санаагаа цэгцлэн бичих чадварыг хэмжих ба хугацаа бүхий бичил төсөлт ажил нь нөөцийг хязгааргүй сонгож авах тохиолдолд тухайн сурагч хэрхэн дүн шинжилгээ хийж байна вэ? гэдгийг хэмжих боломжийг харуулж өгдөг. Сурагчийн өөрийн үнэлгээ болон багшийн үнэлгээ зэрэгцүүлэн авч үзэх нь явцын хийгээд үр дүнгийн үнэлгээг баримт, нотолгоонд тулгуурласан, бодитой болгоход чухал ач холбогдолтой юм. Үүний тулд дараах хүснэгтийг бүтээлчээр баяжуулан ашиглаж болно.

Сурагчийн өөрийн үнэлгээ болон багшийн үнэлгээний зэрэгцүүлэлт

Хам сэдэв: ..... *Сурагчийн нэр:*

Шалгуур	*Өөрийн үнэлгээ*	*Багшийн үнэлгээ*
-Мэдлэг, ойлголт (Хам сэдвийн хүрээн дэх хүн ба нийгмийн холбогдолтой үг хэллэг, нэр томьёо, мэдлэгийг сэргээн санаж буй болон түлхүүр ойлголтуудыг ухаарч эзэмшсэн байдал)		
-Мэдлэг, ойлголтоо хэрэглэх (Мэдлэг, ойлголтыг танил хийгээд шинэ нөхцөлд хүн болон нийгмийн холбогдолтой үйл явц, үзэгдлийг тайлбарлах, тодорхойлох, асуултаа төлөвлөх, асуулт тавих, асуултанд хариулах, мэдээлэл олж авах, боловсруулах, танилцуулах зэрэгтээ бүтээлч хэрэглэж буй байдал) • *Хандлага төлөвшсөн байдал (Сурагч ажил үйлдээ хэр зэрэг нямбай, хичээнгүй, эмх цэгцтэй, хариуцлагатай хандаж буй болон тухайн хичээл, сургалтыг сонирхож, итгэл үнэмшил, үнэт зүйл, зан үйлээ өөрийн түвшинд илэрхийлэн харуулж байгаа байдал)*		

ТАВДУГААР АНГИ

Удиртгал

Энэхүү суралцахуйн удирдамж нь “Хүн ба нийгэм” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үлгэрчилсэн төлөвлөлт юм.

Тус суралцахуйн удирдамжид “Хүн ба нийгэм” сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэхийг суралцахуйн зорилт, суралцахуйн үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн, багшид зөвлөмж гэсэн хэсэгтэйгээр төлөвлөн боловсруулсан бөгөөд сурагч болон багшид суралцахуй хийгээд багшлахуйгаа төлөвлөхөд дэмжлэг, туслалцаа болно.

Мөн бүлэг бүрийн суралцахуйн зорилтуудыг агуулгыг нь нягтруулах, цомхотгох, багш төлөвлөх, гүйцэтгэлийг нь үнэлэхэд дөхөм болгох үүднээс жишээ нь, 5 дугаар ангийн 1 дүгээр хам сэдвийн 1 дүгээр суралцахуйн зорилтыг 5.1а., 2 дугаар суралцахуйн зорилтыг 5.1б. гэх мэт кодолсон. Кодын 5 нь ангийн дугаар, бусад нь суралцахуйн зорилтын дугаар юм.

Суралцахуйн зорилт бүрийн хүрээнд суралцахуйн үйл ажиллагааг санал болгосон нь жишиг гэдгийг анхаарч, багш нар өөрсдөө, сурагчдынхаа хэрэгцээ, туршлага, чадвар, хандлагыг харгалзан бүтээлчээр хөгжүүлэх боломжтой юм.

5.1. Би, гэр бүл, сургуулийн амьдрал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.1а Ye тэнгийнхэн, сургуулийн ажилтнуудад өөрийгөө зөв илэрхийлж, харилцах	-Сургуулийн хүрээнд харилцдаг хүмүүсийн нэрсийг жагсаан, эдгээрээс нэг хүнийг сонгож, ямар асуудлаар хэрхэн харилцах талаар тайлбарлан бичиж, танилцуулна. -Эрүүл, зөв харилцааг илэрхийлсэн дүрс бичлэг үзэж, ярилцана. -Харилцаандаа хэрэглэдэг үгээ эерэг, сөрөг гэсэн 2 баганаар жагсаан бичиж, сөрөг харилцааг илэрхийлсэн үгээ хэрхэн багасгах төлөвлөгөө боловсруулна. -“Сургуулийн амьдрал дахь харилцаанд баримтлах дүрэм” -г зохиож, түүнийг хэрэгжүүлэх санамж бэлтгэнэ. -Сургуулийнхаа дотоод журмыг уншиж, харилцаатай холбогдох ямар заалт байгааг тэмдэглэн, хэрхэн биелүүлж буйд өөрийн үнэлгээ өгнө. -Мэхийн хүндэтгэх, гар барих, тэврэлдэх, эрхий хуруугаа гозойлгох гэх мэт хөдөлгөөнөөр харилцааг илэрхийлэх дүрийн тоглолт хийнэ.	-Дүрс бичлэг -Зураг -Өгүүллэг -Сургуулийн дотоод дүрэм -Харилцааны эерэг ба сөрөг нөлөөг илэрхийлсэн ажлын хуудас
5.1б Сургууль, хамт олны үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах арга замыг сонгох, хэрэгжүүлэх	-Сургууль, ангийн хамт олны зохион байгуулдаг үйл ажиллагааг жагсаан бичиж, өөрийн оролцоог “2 од, 1 хүсэл” үнэлгээний хуудсаар үнэлнэ. -Сургуулийн болон ангийнхаа хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, түүн дэх өөрийн оролцоог тодорхойлно. -Заяа охины тухай тохиолдол шинжилж, ямар сургамж авсанаа ярилцана.	-Хүмүүсийн харилцаанд гардаг зөрчил болон түүнийг зохистой шийдэх үйлдлүүдийг харуулсан зургууд -Дүрс бичлэг -Ажлын хуудас
Багшийн анхаарах зүйл: *Тус хичээлээр сурагч бүртэй ажиллахад ганцаарчлан хандах (сурлагын байдал, хэрэгцээ, сонирхол, авьяас, чадварын онцлогийг тооцох), дэмжлэг үзүүлэх, туслах, мөн хосоор, багаар, дэд багаар ажиллах арга, хэлбэрийг сонгон хэрэглэж болно. Сургуулийн амьдрал дахь харилцааны онцлогийн талаар суралцагч бүр дэвтэртээ бичих, хосоор ярилцах, зургаар илэрхийлэх, дүрийн тоглолт хийх зэргээр харилцааны эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн (гэр бүлийн гишүүд, найз нөхөдтэйгээ харилцах харилцаанаас яагаад өөр байгаа, сургуулийн ажилтнуудтай ямар асуудлаар, хэрхэн харилцах, өөрийгөө хэрхэн ойлгуулах талаар) суралцахуйг төлөвлөн удирдаарай. Сургуулийн дотоод дүрэм, ангийн дүрэм, дэгийг судлах, санал өгөх зэргээр сургуулийн амьдрал дахь харилцаанд идвэхтэй оролцох зан үйлд суралцуулахад анхаарах.*		

5.2. Нутгийн хүмүүс, нийгэм, аж ахуй, соёлын амьдрал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.2а Хүмүүсийн ялгаатай байдлыг (нас, хүйс, нийгэм, соёлын г.м) мэдэж, харилцах	-Хүмүүсийн ялгаатай байдлыг харуулсан зурагт ажиллаж, ямар, ямар шинжээр ялгаатай байгааг тодорхойлж, хэрхэн харилцах талаар ярилцана. -Өөрийн болон ангийн, сургуулийн дүрэм боловсруулахад ялгаатай байдлыг тооцож, ач холбогдлын талаар хэлэлцэнэ. -Сурах бичиг дэх “Хулгар шар” эхийг уншиж, амьтдын ялгаатай байдлыг харуулсан дүрийн тоглолт хийж, үнэлэлт өгнө. -Ялгаварлан гадуурхахгүй, элдэв нэр хоч өгөхгүй байх, бусдыг хүндэтгэх зэрэг нь харилцааг үр дүнтэй болгодог талаар ярилцаж, мөрдлөгө болгоно.	-Дүрс бичлэг, зураг

5.**2б** Нутгийн нийгэм, аж ахуй, соёлын амьдрал, хөгжилд гарамгай хувь нэмэр оруулсан хүмүүсийг мэдэх, үйл ажиллагааг нь тайлбарлах	-Багаараа ярилцан нутгийн алдартнуудаас сонгон, түүний амьдрал, үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, “Миний бахархан дуурайх хүн” танилцуулга бэлтгэнэ. -Сурагчдын төрөл, садан ямар, ямар алдар гавьяатай хүмүүс, байдаг, мөн сургууль, ангийн алдартнуудын талаар жишээ, баримтад тулгуурлан мэдээлэл бэлтгэж, хэлэлцэнэ. -Нутгийн алдартнуудыг тодруулах зорилгоор музейн аялал хийх төлөвлөгөө гаргаж, ярилцана.	-Сурвалжлага, ярилцлага хийх санамж -Нутгийн алдар цуутай хүмүүсийн тухай лавлах
5.2в. Нутгийн байгууллагуудын (үйлдвэрлэл, үйлчилгээ, удирдах зэрэг) үйл ажиллагааг ажиглах, танилцуулах	-Эцэг, эхийнхээ ажилладаг байгууллагын үйл ажиллагааг ажиглаж, удирдах байгууллагын талаар танилцуулга бэлтгэнэ. -Сурагч бүр ажигласан, судалсан байгууллагуудаа жагсаан бичиж, үүрэг, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилна. -Зочин багш урьж, нутгийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар асуух асуултуудаа төлөвлөнө. -Байгууллагууд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг зураглан танилцуулна.	-Нутгийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагааны ялгааг харуулсан бүдүүвч -Дүрс бичлэг
5.2г Хөрш нутаг, өөрийн улсын хөрш улсуудыг газрын зурагт зөв заах	-Нутгийнхаа хөрш орон нутгийг нэрлэж, газрын зурагт зөв заана. -Манай улс болон хөрш улсуудын байрлалыг газрын зурагт зөв зааж, хамтын ажиллагааны нь талаар өөрийн түвшинд тайлбарлана.	- Орон нутгийн газрын зураг -Монгол улсын газрын зураг -Монголын хөрш улсуудын тухай танилцуулга
Багшийн анхаарах зүйл: *Хүмүүс үндэс угсаа, соёл, зан заншлын хувьд ялгаатай байдгийг ойлгож, бусдыг хүндэтгэх, туслах, дэмжих болон нутгийн алдар гавьяатай хүмүүсээр бахархах, тэдний үйл хэргийг алдаршуулахын ач холбогдлыг ойлгуулахад анхаарах. 4-р ангид нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг зорилгоор нь нэрлэж байсан бол 5-р ангид тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны ялгаа, хоорондын харилцаа, хамтын ажиллагааг танин мэдүүлэхэд нь дэмжлэг үзүүлээрэй.*		

5.3. Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал, эрх үүрэг, хариуцлага

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.3а Хүүхэд эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх, эрх зөрчигдсөн тохиолдолд холбогдох байгууллага, хүмүүст хэрхэн хандахыг мэдэж, харилцах	-Хүүхдийн эрх, үүргийг хэрчмэл болон зурагт үзүүлэн ашиглаж, ялгаж, ангилна. -Эрх, үүргээ биелүүлэхийн ач холбогдлыг жишээ, зүйр үгээр тайлбарлаж, ярилцана. -Хүүхдийн эрх зөрчигдсөн тодорхой тохиолдлыг багаар шинжилж, үр дүнг хэлэлцэнэ. -Эрх зөрчигдсөн тохиолдолд сургуулийн хүрээний болон бусад ямар байгуулага, хүмүүст хэрхэн хандах, ямар туслалцаа авах талаар ярилцана. -“Хүүхдийн утас 108”-ны ач тусыг жишээ тохиолдол, баримтад тулгуурлан тайлбарлана.	-Зураг -Тохиолдол -Хүүхдийн эрхийн ангиллыг харуулсан бүдүүвч -Сургамжит өгүүллэг

5.3б Холбогдох мэдээллийг өөрийн түвшинд боловсруулах, хэрэглэх	-Орон нутгийн телевиз болон сонин, сэтгүүл, мэдээллийн бусад эх сурвалжид юу, юуны тухай, ямар, ямар мэдээлэл гардаг талаар ярилцана. -Дээрх эх сурвалжуудад хүүхдийн эрх, үүрэгтэй холбоотой ямар мэдээлэл байгааг цуглуулж, аль нь эрхэд, аль нь үүрэгт холбогдохоор нь ангилна. -Ангилсан мэдээллээс багаараа нэгийг сонгон жишээгээр тайлбарлана. -Орон нутгийн байгууллага, сургуульд хүүхдийн эрх, үүргийн талаар хэнээс, ямар мэдээлэл авах талаар зураглал гаргана.	-Мэдээллийн эх сурвалжуудын танилцуулга -Цахим аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар зөвлөмж

5.4. Миний эх орон - Монгол бахархал

5.4.1 Эх орон, эх түүхийн бахархал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.4.1а Эх орныхоо байгаль, газарзүйн онцлог, үзэсгэлэнт газруудыг мэдэх	-“Миний нутаг” зэрэг шүлэг, дууны үг болон Монголын байгаль, газар зүйн тухай фото зураг, кино, дүрс бичлэгт эх орны байгалийн онцлог, үзэсгэлэнт газруудыг хэрхэн тусгасаныг ажиглаж, тайлбарлаж, ярилцана. -Орон нутгийнхаа үзэсгэлэнт газруудын тухай ярилцах, газар зүйн зурагт таних тэмдэг ашиглан тэмдэглэх -Байгалийн цогцолборт, дархан цаазат газруудыг ямар онцлог шинжээр нь танихыг ярилцан, орон нутгийнхаа холбогдох газруудыг нэрлэнэ. -Эх орны байгаль, газарзүйн үзэсгэлэнт газруудын талаарх аян замын тэмдэглэл уншиж, ярилцах, өөрийн танилцсан байгаль, газарзүйн үзэсгэлэнт газруудын талаар мэдээлэл бэлтгэж, зурагт үзэсгэлэн гаргана.	- Холбогдох баримтат кино, зураг, ном, шүлэг, дуу хөгжим -Монголын болон орон нутгийн газрын зураг -Ажлын хуудас -Үзэсгэлэнт газруудыг таних тэмдэг -Аян замын тэмдэглэл
5.4.1б Монгол орон хүн үүссэн өлгий нутгийн нэг болохыг мэдэх, жишээгээр нотлох	- Эртний хүмүүсийн амьдарч байсан бууц, суурингуудаас өөрийн орон нутагт байгаа эсэхийг домог, хууч яриа унших, ярилцах замаар тодруулж, нэрсийн жагсаалтыг гарган, орон нутгийн зурагт тэмдэглэнэ. -Монгол орон хүн үүссэн өлгий нутгийн нэг болохыг музейн үзмэрт тулгуурлан ярилцана.	- Түүх, соёлын дурсгалт зүйл, бууц, суурин, олдворуудыг харуулсан кино, зураг, дүрс бичлэг -Холбогдох тохиолдол Музей үзэх
5.4.1в Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн онцлогийг тодорхойлох	-Монгол хүний ахуй, амьдралын онцлогийг холбогдох эх сурвалж судлах, тохиолдол шинжлэх замаар хэлэлцэнэ. -Монгол хүний ахуй, амьдрал, эрхлэх аж ахуйн тухай ойлголтыг өөрийн үгээр тодорхойлон бичнэ. -Монгол хүний амьдралын онцлог болон эрхлэх аж ахуйн уялдаа холбоог жишээ, баримтаар үндэслэн тайлбарлана.	-Монгол хүний амьдралын онцлогийг харуулсан кино, дүрс бичлэг, зураг -Монголын нүүдлийн сонгодог мал аж ахуй болон бусад аж ахуйн талаарх жишээ, баримт
5.4.1г Монголчуудын дээд өвөг Хүннүгийн хаан Модунь шаньюгийн тухай сэтгэгдэл бичих	-Модунь шанью хааны намтар, үйл ажиллагаатай холбоотой эх сурвалж, баримтыг уншиж, ямар гавьяа байгуулсан, түүхэн зүтгэлтэн болох тухай ярилцана. -Модунь шаньюй хаан Монгол нутагт нүүдэлчдийн анхны төрт улсыг байгуулсан болон түүний үйл ажиллагаа, авьяас чадвар, эрэлхэг зоригийн талаар сэтгэгдлээ бичиж, ярилцана.	-Модунь шаньюгийн тухай домог, түүхэн баримт, кино, дүрс бичлэг, зураг -Модунь шанью романы хэсэглэл Т.Галсан “Модунь шаньюгийн айлтгал” шүлэг

5. 4.1д Их Монгол улсын нийгэм, аж ахуй, соёлын онцлогийг өөрийн үгээр тайлбарлах	-Их Монгол улс хэзээ, хаана, хэрхэн байгуулагдсан гол үйл явдлыг зураглан харуулна. -Их Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлтой холбогдох мэдээллийг уншиж, түүнийг бусдад танилцуулах төлөвлөгөө гаргана. -Их Монгол улсын аж ахуй, соёлоос өнөөгийн Монголд өвлөгдсөн зүйлсээс нэрлэж, тайлбар бичнэ.	-Их Монгол улсын түүхэн зураг - Их Монгол улсын нийгэм, аж ахуй, соёлын тухай баримтат кино, дүрс бичлэг, зургууд
5.4.1е Суут Чингис хааны үйл ажиллагаа, гавьяаг жишээгээр тайлбарлах, тодорхойлох	-Чингис хааны төрийн бодлого, цэргийн жанжны авьяас билэг, найз нөхдөө таних, үнэнч нөхөрлөх чадвар зэрэг суут чанараас, түүний үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан хэлэлцэнэ. -Чингис хааны өрлөг жанжнуудын талаар багаар хэлэлцэж, дүрийн тоглолт хийнэ. -Эзэн Чингис хааны түүхэн үүрэг, үлгэр дуурайлал,түүнийг хэрхэн бахархах талаар эсээ бичнэ.	-Чингис хааны хөрөг, намтар, Чингис хааны тухай киноны хэсэглэл -Монголын Нууц товчооны холбогдох хэсэг -Эзэн Чингис хааны билиг сургаалын эмхтгэл
5.4.1ж Чингисийг залгамжлагч их хаадын үйл ажиллагаанаас дүрслэн харуулах	-Өгөдэй хаан эцгийн бодлогыг үргэлжлүүлэн Монголын эзэнт гүрнийг хэрхэн, яаж байгуулсан тухай дүрслэн ярилцана. -Өгөдэй хааны хийсэн 4 сайн үйл, 4 муу үйлийн талаар хэлэлцэж, эдгээртэй холбогдох санаа бодлоо бичиж, танилцуулна. -Хубилай хааны бодлого, үйл ажиллагааг жишээгээр тайлбарлан ярилцаж, санал бодлоо солилцоно.	-Чингис хааны 9 өрлөгийн хөрөг -Өгөдэй, Хубилай хааны хөрөг, намтар - Монголын Нууц товчооны холбогдох хэсэг
5.4.1з Манжийн ноёрхлын эсрэг тусгаар тогтнолын төлөө тэмцэгч голлох хүмүүсийн талаар танилцуулга хийх	-Монгол гүрэн бутарч, Монголчуудын тусгаар тогтнол алдагдсан үед улс орноо нэгтгэхэд их хувь нэмэр оруулсан Мандухай сэцэн хатны үйл ажиллагаа, гавьяаны тухай домог, киноны хэсэглэл үзэж, эргэцүүлэн ярилцана. -Манжийн түрэмгийллийн эсрэг, Монголын тусгаар тогтнолын төлөө баатарлаг тэмцэгч Лигдэн хаан, Галдан бошигт хаан, домогт Амарсанаа, Чингүнжав нарын амьдрал, үйл ажиллагааны талаар баримт, жишээгээр нотлон ярилцана.	-Мандухай сэцэн хатны домог, намтар -Галдан бошигт хааны хөрөг, намтар -Чингүнжав, Амарсанаа нарын хөшөөний зураг, танилцуулга -“Хөх Монголын хөх туг” түүхэн киноны эл сэдэвт холбогдох хэсэг

Багшийн анхаарах зүйл:

Эх түүхийн голлох үйл явдлын тухай анхны мэдэгдэхүүн өгөх энэхүү хам сэдвийг эл анги, насны сурагчдын бодит сэтгэхүй, төсөөлөл, дүрслэн бодохуйд тулгуурлан, оролцооны аргаар хичээлийг хөтлөн явуулахад анхааараай. 5 дугаар ангийн “Хүн ба нийгэм” багшийн номыг бүтээлч ашиглах. Мөн сурагчид асуулт гаргах, ярих зүйлийнхээ агуулгын төлөвлөгөө зохиох, уншсан, ойлгосон, үзсэн зүйлээ илэрхийлэх бичиглэл хийх зэрэгт явцын үнэлгээний аргуудыг хэрэглээрэй.

5.4.2 Үндэсний тусгаар тогтнол, орчин үеийн бахархал

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
5.4.2а Улс үндэснийхээ тусгаар тогтнол, сэргэн мандлын тухай тайлбарлах	-Монголчууд Манжийн ноёрхлоос хэдийд (1911.12.29), ямар гол үйл явдлаар, хэрхэн чөлөөлөгдөж, ямар үр дүнд хүрсэн тухай зураглалаар харуулна. -Үндэсний тусгаар тогтнол, төр улсаа сэргээн тунхаглах гэсэн ойлголтуудын талаар тайлбар бичнэ. -Үндэсний тусгаар тогтнолын гарамгай зүтгэлтэн хүмүүсийн (VIII Богд Живзундамба хутагт, Чин ван М.Ханддорж г.м) талаар ярилцаж, тэдний үйл ажиллагаа, үлгэр дуурайллын талаар бяцхан ном, зурагт хуудас хийж, бусдад танилцуулна.	VIII Богд Живзундамба хутагт, Чин ван М.Ханддорж зэрэг түүхэн хүмүүсийн намтар, үйл ажиллагаанаас харуулсан танилцуулга, зураг, цомог, дүрс бичлэг, киноны хэсэглэл -“Монголчууд XX зууны эхэнд зурагт түүх”. 1-р боть, УБ., 2012 номын холбогдох зураг -С.Данзан, Д.Бодоо, Д.Сүхбаатар зэрэг түүхэн хүмүүсийн намтар, үйл ажиллагааны тухай зургууд
5.4.2б Тухайн үеийн Монгол улсын нийгэм, аж ахуй, соёлын шинэ зүйлсийг тодорхойлох	-Ардын эрхт, хэмжээт цаазат Монгол улс (1921.7.11), түүний засгийн газрын зорилго, үйл ажиллагааны тухай түүхэн баримтад үндэслэн, ярилцана. -1921-1940-өөд оны манай улсын нийгэм, аж ахуй, соёлын шинэ зүйл, ололтын талаар баримт, жишээ, тохиолдолд тулгуурлан, багаар хэлэлцэж, үр дүнг харилцан танилцуулна.	-Монголчууд: XX- XXI зуунд зурагт түүх, 2-р боть, номын холбогдох зургууд -Тухайн үеийн монголын нийгэм, аж ахуй, сургууль, соёлын шинэ зүйлийг харуулсан зураг, жишээ, тохиолдол -Хэлмэгдүүлэл, ноёд, тайж нарын хөрөнгө хураалт, шашин, соёлыг сүйтгэсэн талаарх түүхэн баримт, кино, уран зохиолын хэсэглэл
5.4.2в Эх орны түүхэн дэх хүнд бэрх үе, тусгаар тогтнолын бэхжилтийн талаар хэлэлцэх	-Дэлхийн II дайны үед манай улс орон, хүмүүсийн амьдралд ямар бэрхшээл, хүндрэл учирч байсан, түүнийг хэрхэн даван туулсан талаарх жишээ, баримтыг уншиж, холбогдох асуултууд гаргаж, ярилцана. -1945 оны Монголын бүх ард түмний санал хураалттай холбогдох зураг, баримтыг шинжлэн, сэтгэгдэл бичнэ.	-Дэлхийн 2-р дайны хор уршиг, үр дагавар Монголд нөлөөлж байсан тухай түүхэн баримт, зураг, холбогдох киноны хэсэглэл -Монголын бүх ард түмний санал хураалтын (1945) үе дэх хүмүүсийн гарын үсгийн фото зураг
5.4.2г Монгол улсын нэр хүнд дэлхий дахинд өссөн тухай өөрийн үгээр илэрхийлэх	-Монгол улс Нэгдсэн Үндэстний Байгууллагад (НҮБ) элсэж, Монголын нэр хүнд дэлхий дахинд өссөн тухай жишээ, тохиолдолд шинжилгээ хийж, холбогдох зураг, дүрс бичлэг, киноны хэсэглэлийг үзэж, ярилцана. -Энэ талаарх өөрсдийн сэтгэгдэл, бахархлыг хосоор болон багаар хуваалцана.	-Монгол улс НҮБ-д элссэн тухай түүхэн баримт, зураг, киноны хэсэглэл -Энэ тухай гэрчлэх хүмүүсийн дурсамж, сэтгэгдэл

5.4.2д Тухайн үеийн эх орны аж ахуй, нийгэм, соёлын бүтээн байгуулалтыг жишээгээр тайлбарлах	-1960-1980-аад оны эх орны аж үйлдвэрийн шинэ салбарууд, тэдгээрийн бүтээгдэхүүн, мал аж ахуй, газар тариалангийн өсөлт, нийгэм, соёл, боловсролын ололтын талаарх жишээ, баримтыг хэлэлцэнэ. -Холбогдох кино, дүрс бичлэг, түүхэн цомгийн хэсэглэлээс үзэж, ярилцана. -Дархан, Эрдэнэт хот үүсч, шинэ бүтээн байгуулалт, соёл өрнөсөн талаар асуудал дэвшүүлэн хэлэлцэж, үр дүнг танилцуулна. -Эл үеийн аж ахуй, соёл, урлаг, боловсролын алдартнуудын тухай өөрсдийн түвшинд сурвалжилж мэдэх, тэдний хөдөлмөрч, бүтээлч, авьяаслаг үйл хэргээс харуулсан зураг зурах, зохион бичлэг хийх	-Аж үйлдвэр, нэгдэлжих хөдөлгөөн болон газар тариалангийн хөгжлийн талаарх ном зохиол, уран сайхны киноны хэсэглэл, дүрс бичлэг -Нийтээр бичигтэн болсон, номын сан, уран сайхны клуб, музей болон эмнэлэг, ахуйн соёлын үйлчилгээг харуулсан зураг, киноны хэсэглэл Монголчууд: XX-XXI зуунд зурагт түүх, 2-р боть, номын холбогдох зургууд
5.4.2е Монгол төрийнхөө бэлгэдлийн талаар мэдэх, танилцуулах	-Монгол төрийн сүлд, туг, далбааны тухай эх бичвэрийн хэсэглэл, жишээ тохиолдол, зураг, цомог зэрэгт ярилцаж, эдгээрийн утга, агуулга, бэлгэдлийг өөрийн үгээр тайлбарлана. -Монгол төрийн бэлгэдлүүдийг байрлуулах, хүндэтгэх талаар дүрийн тоглолт хийнэ.	-Монгол төрийн сүлд, туг, далбаа, тамга, тэдгээрийн зураг, утга, агуулга, бэлгэдлийн тухай баримт, танилцуулга -Төрийн дуулал, түүнд зориулсан хөшөөний бичвэр, холбогдох зураг
5.4.2ж Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын ололт, амжилтыг тайлбарлах	-Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын гол ололтуудыг жишээ, баримтаар ярилцаж, зураглалаар харуулна. -Ардчиллын нэрт зүтгэлтэн Р.Зориг нарын намтар, үйл ажиллагааны талаар судалж, тэдний тухай танилцуулга бэлтгэнэ.	-Ардчилсан Монголын нийгэм, аж ахуй, соёлын гол ололтуудын тухай баримтат кино, дүрс бичлэг, цахим мэдээлэл -Ардчиллын нэрт зүтгэлтнүүдийн зураг, намтар, үйл ажиллагаанд холбогдох ном зохиол

Багшийн анхаарах зүйл:
Миний эх орон-Монгол бахархал хам сэдвийг Эх түүхийн нэн сонирхолтой жишээ, баримт, эх сурвалж, кино, дүрс бичлэг, цахим мэдээлэл, уран зохиол, урлагийн бүтээл, хүмүүсийн дуртгал, дурсамжид тулгуурлаж, хичээлүүдийг нь аль болох сонирхолтой арга, хэлбэрээр, сэдэв хоорондын болон Эх хэл, математик, бусад хичээл хоорондын холбоог хэрэгжүүлэх замаар хөтлөн явуулахад анхаарах. Холбогдох сэдвүүдээр явцын болон бүлэг сэдвийн үнэлгээний аргуудыг бүтээлч хэрэглээрэй. Үнэлгээ гэдэг нь сурагч хэрхэн суралцаж байгаа, ямар мэдлэг, чадварыг амжилттай эзэмшиж байгаа, юун дээр алдаж байгаа болон багш заах арга, багшлахуйгаа хэрхэн боловсронгуй болгох, дээшлүүлэх талаар мэдээлэл олж авах, багш, сурагч мэдээлллээ харилцан солилцох, улмаар хамтран суралцахуйгаа сайжруулахад чиглэсэн үйл явц юм. Иймээс үнэлгээний аргууд нь суралцахуйн цогц зорилтын хэрэгжилтийг илрүүлэхүйц байх бөгөөд хэд хэдэн аргыг шүтэлцүүлэн хэрэглэх нь багшийн үнэлгээний үндэслэлтэй байдлыг илүү нотлон харуулдаг. Жишээ нь, зөв хариултыг сонгох даалгавар нь тухайн сурагчийн сэргээн санахуй хийгээд мэдлэг, баримтыг таних, ялгах чадварыг хэмжиж байгаа бол эргэцүүлэл бичүүлэх нь тогтоосон хугацаанд бодол санаагаа цэгцлэн бичих чадварыг хэмжих ба хугацаа бүхий бичил төсөлт ажил нь нөөцийг хязгааргүй сонгож авах тохиолдолд тухайн сурагч хэрхэн дүн шинжилгээ хийж байна вэ? гэдгийг хэмжих боломжийг харуулж өгдөг. Иймээс 4-5-р ангийн "Хүн ба нийгэм" сургалтаар явцын болон үр дүнгийн үнэлгээ хийхдээ тухайн ангиудын суралцахуйн зорилт ба агуулгын залгамж холбоо, түвшинг сайтар тооцож, үнэлгээний зохистой арга, хэлбэрүүдийг сонгон ашиглаарай.